

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-80

1.Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох 6-54

2.Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох 54-80

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 31 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, С.Лүндэг, Л.Мөнхбаясгалан, А.Ундраа;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ц.Идэрбат, З.Мэндсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтаншагай.

Нэг.Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, мөн газрын Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Бодлого, төлөвлөлтийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Төмөрбат, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга Л.Алтангэрэл, “Тавантолгой түлш” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын дарга О.Эрдэнэбат, мөн компанийн Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Ариунзаяа, Ерөнхий технологич Д.Өлзийбат, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын дарга Б.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, Үнэлгээ, мониторингийн газрын референт Г.Нямдэлгэр нар байлцав.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Уянга, М.Мандхай, Ж.Батжаргал, У.Отгонбаяр, Т.Мөнхсайхан, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, П.Батчимэг, Ж.Золжаргал, Б.Мөнхсоёл, С.Замира, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, мөн газрын Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга Л.Алтангэрэл, “Тавантолгой түлш” ХХК-ийн Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Ариунзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ 11 цаг 17 минутаас 11 цаг 20 минутад, 12 цаг 37 минутад 12 цаг 49 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Гадаад харилцааны хэлтсийн дарга Д.Ариунтуяа, Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Ундраа, Олон талт оролцооны хэлтсийн дарга Ш.Цэрэндулам, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны дарга Д.Батмөнх, “COP17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар” ОНӨААТҮГ-ын захирал Б.Баттулга, Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч Н.Чимгүүндарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, Үнэлгээ, мониторингийн газрын референт Г.Нямдэлгэр нар байлцав.

Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах бэлтгэл ажлын талаарх мэдээллийг Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэстний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, М.Мандхай, Г.Ганбаатар, С.Одонтуяа, Э.Болормаа нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Гадаад харилцааны хэлтсийн дарга Д.Ариунтуяа, Олон талт оролцооны хэлтсийн дарга Ш.Цэрэндулам, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах Үндэстний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны дарга Д.Батмөнх, “COP17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар” ОНӨААТҮГ-ын захирал Б.Баттулга, Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч Н.Чимгүүндарь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах ажлын талаарх Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэстний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатарын мэдээллийг сонсов.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, Б.Бейсен нар үг хэлэв.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен хэлэлцэх асуудлын гуравдугаар асуудал болох Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэхийг хойшлуулав./14:56/

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 25 минут үргэлжилж, 30 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 31 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53.3-тай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Жигжидийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал, 3 асуудал хэлэлцэнэ.

1 дэх асуудал Өвөлжилтийн биелэлтийн ажлын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох.

2 дахь нь Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал COP-17-г зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох,

3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан сонсох юм байгаа юм.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Ажлын хэсэг оруулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэдээллийг сонсох.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлого, хэрэгжилт зохицуулах газрын дарга, Мөнхнасан Мал аж ахуйн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо С.Төмөрбат, Бодлого төлөвлөлт, биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ц.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Э.Баттулга Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас А.Амартүвшин Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн салбар болон ногоон хөгжил болон Агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Д.Мөнхбаатар Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, Л.Алтангэрэл Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хотын инженер, дэд бүтцийн газрын дарга, “Тавантолгой түлш” ХК О.Эрдэнэбат Үйл ажиллагааны газрын дарга, Х.Ариунзаяа Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга, Б.Өлзийбат Ерөнхий технологич, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв Б.Баттулга дарга нь.

Хүнс, хөдөө аж ахуйн мэдээллийг Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн танилцуулна. 3 номер.

Т.Жамбалцэрэн: Улсын Их Хурлын Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 56 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын мэдээллийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөг 19 арга хэмжээгээр боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын дагуу 7 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 12 арга хэмжээ хэрэгжих шатдаа, 1 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Энэ хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээт тарилга, вакцинаар сольж арилжаалах тухай Эрүүл мэндийн яамтай хамтран хэрэгжүүлэх ажил байгаа. Бэлчээрийн ургамлын ургалтын байдлаас үзэхэд нийт нутгийн 46 хувьд гантай болон гандуу, 54 хувьд хэвийн зуншлагатай байж өнгөрсөн. Холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан гангийн үнэлгээ, дүгнэлтээс үзэхэд баруун бүсийн голдуу 25 сумд маш их эрсдэлтэй, 54 сумд их эрсдэлтэй, 120 сумд дунд эрсдэлтэй, 129

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

сумд бага эрсдэлтэй, 2 сумд маш бага эрсдэлтэй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан байгаа.

Баруун болон төвийн бүс нутагт гантай зуншлага муу байсантай холбогдуулан Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс зудын урьдчилсан төлөвийн газрын ажиглалтын болон хиймэл дагуулын мэдээ, өвөл, хаврын бэлчээрийн даац, агаарын температур, хур тунадасны дундаж зэрэг мэдээлэлд үндэслэн 11 дүгээр сарын байдлаар боловсруулан гаргасан байна.

Уг дүнгээс үзэхэд нийт нутгийн 3 хувьд нэн их, 22 хувьд их, 21 хувьд дунд зэрэг, 26 хувьд бага, 28 хувьд маш бага зудын эрсдэлтэй байхаар дүгнэлт гарсан байна. Өөрөөр хэлэх юм бол Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн ихэнх нутгаар цасны нөхцөл тооцогдоогүй байх үед зудын эрсдэл их болон нэн их түвшинд үүсэж байгаа нь өвөлжилт тухайн аймгуудад өвөлжилт хүндрэх төлөвтэй байгааг харуулж байна аа.

Энэ жил улсын хэмжээнд 113.3 мянган малчин өрхөд 65.7 сая толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 122.5 сая хонь өвөлжиж, хаваржихаар тооцоолол гарсан. Улсын хэмжээнд отрын 16.6 мянган малчин өрхийн 5 сая 724 мянган толгой мал өвөлжихөөр байна. Нийт отроор өвөлжих малын 0.6 сая толгой мал нь өөр аймгийн нутагт, 1.2 сая толгой мал нь өөрийн аймгийн бусад сумдад, 0.1 сая толгой мал нь сум дундын отрын бүсэд, 0.5 сая толгой мал аймаг дундын отрын бүс нутагт, 1 сая мал хилийн зурвас нутагт, 2 сая толгой мал улсын тусгай хамгаалалттай газар нутагт тус тус өвөлжих хүсэлт гаргасанд зохицуулалт, холбогдох зохицуулалтыг салбар яамнаас хийж ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа аймаг дундын отрын бүс нутагт 2025-2026 онд нийтдээ 12 аймгийн 35 сумын 651892 хонин толгой мал өвөлжиж, хаваржихаар шийдвэрлэсэн. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны даргын 2025 оны А82 дугаар тушаалаар аймаг дундын отрын бүсийн нутгуудад мал сүргийн шилжилт хөдөлгөөн хийх чиглэлийн зураглалыг батлан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа.

Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн мэдээгээр 11 аймгийн 33 сумын хил орчмын бүс нутагт 427 малчин өрхийн 315.3 мянган малыг өвөлжүүлэх, хаваржуулах боломжтой байна гэсэн мэдээллийг ирүүлсэн. Аймаг, сумдаас хилийн зурвас газарт 2577 малчин буюу 1.1 сая мал өвөлжүүлэх, хаваржих хүсэлтийг гаргаад байгаа. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа улсын тусгай хамгаалалттай 10 нутагт хонин толгойд шилжүүлснээр 88.1 мянган толгой хонийг отроор өвөлжүүлэх боломжтой гэсэн мэдээллийг ирүүлсэн. Аймаг, орон нутгаас ирүүлсэн хүсэлтээр нийтдээ 2 сая гаруй толгой малыг улсын тусгай хамгаалалттай газар нутагт өвөлжүүлж, хаваржуулах шаардлагатай байна.

Иймээс улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн зурваст газар нутагт мал өвөлжүүлэх, хаваржуулах боломжийг дахин тодотгож нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна. Өөрийн аймаг сумаас өөр нутаг дотроор өвөлжиж, хаваржих малчин өрхөд нийгэм, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж, ажиллах чиглэлийг Эрүүл мэндийн яамнаас аймаг, нийслэлийн эрүүл мэндийн болон төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хүргүүлэн холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ингэснээр отроор өвөлжиж, хаваржиж байгаа 17500 гаруй малчин өрхийн гишүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд саадгүй хамрагдах боломжийг бүрдүүлсэн.

Цаашид эдгээр отрын өвөлжих, хаваржих айл өрхийн гишүүдийн судалгааг нарийвчлан гаргана. Нэн тэргүүнд тусламж, үйлчилгээ шаардлагатай эмзэг ангилалд хамаарах гишүүдийг онцгойлон анхаарах шаардлага үүсэж байна.

Засгийн газрын 2025 оны 26 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд нийтдээ 36.4 мянган тонн бүдүүн, 30.8 мянган тонн хүчит тэжээлийг бэлтгэхээс бүдүүн тэжээлийн бүрдүүлэлт 77.4 хувьтай, хүчит тэжээлийн бүрдэл бүрдүүлэлт 35.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнийг өнгөрсөн оны бэлтгэлтэй харьцуулахад өвс 17.2 мянган тонноор, тэжээл 18.3 мянган тонноор тус тус илүү бэлтгэсэн байна.

Аймаг, сумын аюулгүй нөөцөд бүрдүүлэлтэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын ерөнхий байцаагчийн удирдамжаар хяналт шалгалтыг хийж ажиллаж байгаа. Зуншлага тааруу байснаас хадлан, тэжээл бэлдэх боломжгүй болсон Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Дундговь, Дорноговь, Өвөрхангай аймгуудыг Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад хадлангийн талбай ашиглан хадлан бэлтгэх боломжоор хангах зохицуулалтыг хийж ажилласан.

Ингэснээр 256.1 мянган талбайгаас 400 иргэн, аж ахуйн нэгж хадлан бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлж ажиллаж байна. Мөн Дорнод аймгийн Чойбалсан сумд байрлах аймаг дундын отрын бүсийн нийт 21.3 мянган га талбайгаас 6.8 мянган тонн хадлан бэлтгэж, аймаг дундын отрын бүс нутагт оторлох малд тэжээлийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Энэ онд улсын хэмжээнд малчдын түвшинд 1.2 сая, 3 сая тонн хадлан, 4.7 мянган тонн сүрэл, 51 мянган тонн ногоон тэжээл, 26 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 29.3 мянган тонн гар тэжээл, 3.4 мянган тонн дарш, 66.9 мянган тонн давс, хужир бэлтгэсэн байна.

Малын индексжүүлсэн даатгалд 2025 онд 23 мянган малчин өрх, 3.4 сая толгой малыг 4.1 тэрбум төгрөгөөр хамруулсан байдаг. 26, 25 оны хагас жилийн малын тэжээвэр амьтны тооллогоор нийтдээ 7 аймгийн 10 сумын малын хорогдол, нөхөн олговор олгох босго давсан тоон үзүүлэлт гарсан.

Үүнтэй холбоотой Ховд, Архангай, Төв аймгуудын 52 малчин өрхийн 1.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор тооцоологдсон. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох нөхөн олговор олгох босго үзүүлэлтийг бууруулснаар хамрагдалтын хувь нэмэгдэх боломжийг бүрдүүлнэ гэж ингэж үзэж байгаа.

Малжуулах хөтөлбөрт 2025 оны 9 сарын байдлаар 21 аймгийн нийслэлийн 822 иргэнийг 63.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 50.4 мянган толгой малаар малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Монгол Улсын 2025-2026 онд нийтдээ 162 мянган тонн мах экспортлох нөөц байгаагаас өнөөдрийн байдлаар 59 аж ахуйн нэгж, 211.2 мянган ам.долларын үнэ бүхий 51 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг экспортолсон дүнтэй байгаа. Махаар нь тооцох юм бол 70 гаруй мянган тонн махыг экспортлох ийм үзүүлэлт гарсан. 2025 оны 10 сарын 27-ны

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байдлаар 57 мянган толгой малыг амьдаар экспортод гаргах зөвшөөрөл олгосноос өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 43 мянган толгой малыг амьдаар нь гаргасан байна. Экспортолсон малыг хонин толгойд шилжүүлснээр 2.8 сая толгой малыг экспортод гаргасан ийм үзүүлэлттэй байна.

Амьд малыг экспортыг авч үзвэл Бүгд Найрамдах Узбекистан Улс руу 26.5 мянган толгой хонь, БНХАУ руу 2.6 мянган толгой хонийг тус тус экспортолсон. Малчдын мал худалдаалах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Атарын 4 дүгээр аяны хүрээ хүрээнд мал, мах худалдан авах эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг гаргаж арилжааны банкаар дамжуулан мал төхөөрөх үйлдвэрүүдэд олгохоор шийдвэрлэж холбогдох зохицуулалтыг хийж ажиллаж байна. Ингэснээр малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, зүй бус хорогдлоос урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж байна гэж ингэж үзэж байгаа. Улсын хэмжээнд 10 сарын 27-ны өдрийн байдлаар 278.3 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн улаан буудай, 108.5 мянган тонн төмс, 208.6 мянган тонн хүнсний ногоо, 146.5 мянган тонн тэжээлийн ургамал, 27.4 мянган тонн тосны ургамал нийтдээ 762.5 мянган тонн ургац хураан авч. Нийт хүн амын хэрэгцээт улаан буудай 62.5 хувийг, төмсний 78.5 хувийг, хүнсний ногооны 72.6 хувийг дотоодын ургацаар хангах боломжтой тооцоолол гарч байна.

Ургац хураалтын урьдчилсан дүнгээр энэ намрын ургацаас Стратегийн нөөцөд Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК-д 27.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүдэд 26.4 мянган тонныг тус тус худалдан авсан. 126.4 мянган тонныг тус тус авсан. 153.7 мянган тонн улаан буудайн гурил үйлдвэрлэлийн зориулалтаар нийлүүлэгдэж, 24.5 мянган тонн улаан буудай борлуулалтын шатдаа байна. Спиртийн үйлдвэрт 12.1 мянган тонн малын тэжээлд 18.4 мянган тонн тэжээлийн үйлдвэрт 8.7 мянган тонн нийлүүлэгдсэн. Хөдөө аж ахуйн корпорац үрийн шинэчлэлдээ 7.4 мянган тонн улаан буудай, тариалан бүхий аж ахайн нэгжүүдэд дараа оны тариалалтдаа зориулж 26.8 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн байна.

Цаашид газар тариалангийн салбарын олсон амжилтыг бататгаж энэ байгаль, цаг уурын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, салбарын бие даасан тогтвортой хөгжлийг хангах зорилгоор хэд хэдэн чиглэлийн ажлуудыг хэрэгжүүлж ажиллаж байгаа. Энэ дотор тариалангийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр, хөрсийг салхины элэгдлээс хамгаалах, хашаажуулах, хамгаалалтын ойн зурвас байгуулах, өвчин хортон, ганд тэсвэртэй таримлын шинэ сортыг устгах, ганд тэсвэртэй шинэ сортуудыг нутагшуулж бий болгох, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, хамгаалагдсан хөрсний тариалан буюу хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, бордоо ургамал хамгааллын бодисын оновчтой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Мөн тариалангийн гаралтай бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, худалдааны үр ашгийг дээшлүүлэх цогц бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын мэдээллийг танилцуулж дууслаа. Баярлалаа.

Б.Бейсен: Мэдээлэл танилцуулсан Жамбалцэрэн даргад баярлалаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Одоо Нийслэлийн өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар Нийслэлийн Засаг даргын оролцогч Амартүвшин дарга танилцуулга хийнэ. Индрийн микрофоныг өгөөд.

А.Амартүвшин: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Нийслэлийн 2025 оны 26 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцаар та бүхэнд товч танилцуулъя.

Нийслэлийн 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд инженерийн хангамжийн байгууллага, харьяа газар, дүүргүүд нийт 750 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2025 оны 10 дугаар сарын 24 өдрийн байдлаар 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ оны хувьд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг товч дурдвал 1-д 2025 оны 1 дүгээр сараас инженер хангамжийн байгууллага, харьяа дүүрэг, газар, агентлагуудын ажилтнуудыг оролцуулан ажлын хэсгийг бол бид нар байгуулж ажилласан.

Хоёрт, нийслэл хотод 2025 онд хэрэгжих авто зам, инженерийн шугам сүлжээ, тохижилт, хөрөнгө оруулалтын ажлыг нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, 2025 оны 2 дугаар сард цахим сайтаар болон байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Авто зам сэлгэх, сүвлэх, орц, гарцын хурлыг жил бүрийн 5 дугаар сард бол эхлэн зохион байгуулж, мөн захирамжийг шинэчлэн 2025 оны 3 дугаар сараас бол эхлүүлж ажилласан байгаа. Өөрөөр хэлбэл 5 дугаар сард хийж эхэлдэг ажлыг бид 2 сараас өмнө татаж энэ ажлуудыг бол эхлүүлж ажилласан.

Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөр 2025 оны 6 дугаар сараас 14 хоног тутам нийслэлийн 2025 оноос 2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, тулгамдаж байгаа асуудлыг танилцуулж, газар дээр нь асуудлуудыг шийдвэрлэж ирсэн.

НЗД-ын 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх А/943 дугаар захирамжийн хэрэгжилтийг мөн хангуулж ажиллаж явж байгаа. НЗД-ын зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар нийслэлийн 2025-аас 26 оны өвөлжилтийн хугацаанд хүндэрч болзошгүй 11 сургууль, 9 цэцэрлэг, 7 эмнэлэг, 12 халаалтын зуух, хорооллын дундах шугам сүлжээг шаардагдах 6 тэрбум төгрөгийг бол шийдвэрлэн мөн ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах явцад нийслэлийн харьяа байгууллагуудын хийж гүйцэтгэсэн ажлыг товч танилцуулъя.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн компанийн хөрөнгөөр 6 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бол, Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 8 ажлыг 100 хувийн, 100 хувийнх. Улс, нийслэлийн төсвөөр 8 ажлыг 100 хувь, авто замтай холбоотой 4 ажлыг 100 хувь, нийт дулааны шугам, сүлжээний ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж ажлаа дуусгасан.

Шугам, халаалт солих, халаалт хийх, шугам дулаалах, тоолуур баталгаажуулах, техникийн шийдэл хэрэгжүүлэх зэрэг 15 чиглэлээр орон сууцын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

барилгын хуучирч муудсан халаалтын дотор системийн гадна шугамын засвар, угаалга, шахалтын ажлуудыг 100 хувь гүйцэтгэлээр төлөвлөгөөгөө биелүүлээд ажилласан. “Улаанбаатар цахилгаан түгээх” ТӨХК-ийн 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөгөөр үндсэн шугам тоноглолын нийт 31 төрлийн 98 ажил урсгал засвараар, 3387 шугам тоноглол тус тус засварлан ажил хуваарийн дагуу зохион байгуулагдан ажиллаж явж байна. Төлөвлөгөөний ажлын гүйцэтгэл дээр одоо байна. 96.6 хувийн гүйцэтгэл дээр байна.

Ус сувгийн удирдах газрын ОНӨААТҮГ-ын 2025 оноос 2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд 3 нэр төрлийн 27 ажил тусгагдсанаас 88 хувийн гүйцэтгэлтэй байна. Ариутгах татварын шугам, сүлжээнд хаврын шугам угаалгыг батлагдсан графикийн дагуу 4 дүгээр сарын 7-ноос 5 дугаар сарын 22-ны хооронд 100 хувь хийж гүйцэтгэсэн. ТӨ 502 машинаар 50619 урт метр шугам, 1193 худгийг буудуулж угааж цэвэрлэсэн. Гар цэвэрлэгээгээр 120641 урт метр 2597 худ бөмбөгөөр 3950 урт метр 79 худгийн угаалга цэвэрлэгээ ажил хийгдсэн байна.

Авто замын зорчих хэсэгт эвдэрсэн, эвдэрсэн байсан худгийн тагийг цэвэр усны 57 худаг, бохир усны 74 асфальтаар хучиж засварласан. Намрын угаалгад 8 дугаар сарын 25-наас 11 сарын 1-ний өдрүүдийн хооронд батлагдсан графикийн дагуу гүйцэтгэж байгаа. Гүйцэтгэл 100 хувийнхаар бол одоо бол хүрсэн ажиллаж байна.

Орон сууц, нийтийн аж ахуй удирдах газрын ОНӨААТҮГ-ын их засварын ажил 33 нэр төрлийн урсгал засварын ажил 36 нэр төрөл, урсгал засварын ажил 36 нэр төрөл, бусад 8 нэр төрлийн ажил хийхээр төлөвлөж гүйцэтгэл 95.4 хувьтай байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр 19 байршилд 3км F50-аас 200мм-ийн голчтой шугам шинэчлэл солих ажил 96 хувьтай гүйцэтгэлтэй байна. Ариутгах татварын F150-300мм-ийн 141882 уртааш метр шугам, угаалга 5234 ширхэг худаг угааж цэвэрлэгээний ажил бол хийгдээд биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үерийн далан суваг, хөрсний усны чиглэлээр үерийн далан суваг, хөрсний усны ажил 92.7 хувь, Геодез, усны барилга, байгууламжийн ОНӨААТҮГ нь авто зам дагуу болон ус их тогтдог 8 байршилд 17км борооны ус зайлуулах шугам угсралт 80 хувьтай байна. Мөн Дунд голын дагуух хагшаас цэвэрлэгээний ажил одоо 87 хувьтай үргэлжлээд ажил явж байна.

Халаалтын зуухын хувьд тусгай зөвшөөрөлтэй эзэмшигч 19 аж ахуйн нэгжийн 174 зуух хийн түвшинд холбогдох судалгааг Агаар бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн. Мөн 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлэн байдлыг хангах хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын ОНӨААТҮГ-ын түүхий нүүрснээс халдаг 20 зуух нь технологийн шинэчлэл хийж 2062, бараг 2 гаруй тэрбум төгрөгөөр санхүүжилтийг бол шийдвэрлэлт ажилласан. Тус газарт шинэчилж хийсэн засвар, шинэчлэлийн ажилд хяналт тавин ажлыг гүйцэтгэж 100 хувийн гүйцэтгэлтэйг бол хийж дуусгаад одоогоор бол сайжруулсан мидлинг түлж хэрэглэж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Нийслэлийн авто замын хувьд Нийслэлийн авто замын газрын 2025 оны засвар шинэчлэлээр 104км шинээр зам гүүрний, засвар шинэчлэлээр 104км, шинээр зам гүүрний 58км, авто замын шинэчлэх ажил төлөвлөсөн төлөвлөгөөний гүйцэтгэл 98 хувьтай явж байна. Одоогоор үлдсэн 4 хувийн гүйцэтгэлийн ажил бол хийгдээд явж байгаа. Засвар шинэчлэлийн хүрээнд 44 төсөл, арга хэмжээнээс 42 ажил дууссан. 2 ажил бол хэрэгжих шатдаа 95 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Нийслэлийн боловсролын газрын, нийслэлийн боловсролын хувьд нийслэл, дүүргийн 2025 оны төсөвт 177 боловсролын байгууллагын барилгын их засварыг төлөвлөн батлагдсанаас 2025 оны нийслэл, дүүргийн төсвийн нэмэлт, өөрчлөлтөөр 136 барилгын барилга их засварын ажил хийх хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 95 хувьтай үргэлжилж байгаа. 2025-аас 26 онд хүндэрч болзошгүй сургууль, цэцэрлэгийн засварын ажлыг санал авч, НЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нэмэлтээр 21 сургууль, цэцэрлэгийн засварын ажилд хөрөнгө шийдвэрлэж, ажлын гүйцэтгэлийг бол хийж дуусах шатдаа бол явж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн хувьд Эрүүл мэндийн газрын хувьд Эрүүл мэндийн газрын нийт хөрөнгө оруулалтын 92 нэр төрлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс дууссан 89 арга хэмжээ байна. Ажил хэрэгжиж байгаа 3 ажил байгаа бөгөөд өвөлжилтийн бэлтгэл ажил 98 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Зам цэвэрлэгээ, үйлчилгээ, халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх ажлын, бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд нийт 9518 тонн давс, 9590 тонн бодис нөөцлөх шаардлагатай. Өнөөдрийн байдлаар 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд нөөцөлсөн давс бодис нь 7664 тонн, бодис 7580 тонны үлдэгдэлтэй бол ингээд байж байна.

2025-аас 26 онд нэмэх давс бол 1333 тонн, бодис 2202 тонноор бол нөөцлөхөөр бол нөөцийг бэлтгэл ажлыг хангаад явж байна. Давс, бодис цацагч тусгай зориулалтын 60 машин техник, зам цэвэрлэгээний тусгай зориулалттай 432 техник бол бэлэн байдалтай байна. Дүүргийн өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажил 93-98 хувьтай бол хэрэгжиж явж байна.

Мал аж ахуйн салбарын хувьд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хөдөө аж ахуйн салбарын 2025-аас 26 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд НЗД-ын 2025 оны А/1293 дугаар захирамжийг батлуулж, нийслэл, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн хэмжээ 494 тонноор тогтсон бөгөөд НЗД-ын нөөц хөрөнгөөс 172 гаруй сая төгрөгийг шийдвэрлэж, өвөлжилт, хаваржилтын хүндэрч болзошгүй нөхцөл байдалд үүсэх үед тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 165 тонн өвс, тэжээлийг бэлтгэж, бэлтгэлийг хангаж ажиллалаа. Дүүргүүдийн аюулгүй нөөцөд 329 тонн өвс тэжээл бэлтгэхээр төлөвлөж, 151.9 тонн бэлтгэж, биелэлт 46.2 хувьтай байна.

Шахмал түлшний нөөц хангалтын хувьд нийслэлийн 7 дүүрэгт байрлах 25 агуулахад 2025 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш 1300 тонн, хагас кокс түлш 11200 тонн нөөцтэй байна. Мөн “Тавантолгой түлш”-ийн зүүн үйлдвэр дээр сайжруулсан шахмал түлш 130 тонн, хагас кокс 3255 тонн, савласан кокс нүүрс 8094 тонны нөөцтэйгөөр ингээд үйл ажиллагаагаа явуулж байна. Агаарын чанарыг сайжруулах 7 дүүргийн иргэдэд түлшний

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хангамжийг тогтвортой байлгах зорилгоор 397 борлуулалтын цэгээр түлш түгээлтийг иргэд, олон нийтэд бол түлш түгээлтийг явуулж байна.

Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд алсын зайн дамжуулагчтай угаарын хий мэдрэгч төхөөрөмж нь НЗД-ын захирамжаараа 2025 онд 112 мянган ширхэг алсын зайн дамжуулагчтай угаарын хийн мэдрэгчийг төхөөрөмжийг гэр хорооллын айл өрхүүдэд суурилуулсан. 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/1437 дугаар захирамжаар 45 мянган ширхэг төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Оны сүүлээр нийт Улаанбаатар хотод гал түлж байгаа 172 мянга гаруй айлыг бол бүрэн ухаалаг угаар мэдэгчтэй холбох чиглэлээр ажиллаж байна.

НЗД-ын 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/1276 дугаар “Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулах зарим арга хэмжээ авах тухай” захирамжаар нийслэл болон дүүргийн шуурхай штабууд байгуулагдан 24 цагаар ажиллаж байна.

Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд гарын авлага зөвлөмжийг аж ахуйн нэгж байгууллагад 14881 удаа, иргэдэд 287224 удаа хүргэсэн. Түлш хэрэглэгчид үйлчлэх төв халаалтын улирал эхэлснээс хойш 24605 дуудлага хүлээн авч, 49210 иргэнтэй шууд тулж ажилласан байна. Хяналт шалгалтын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 78566 өрхөд хяналт шалгалт хийж, зөв галлагааны заавар, зөвлөгөө өгч, угаарын хий мэдэгчийн хэвийн ажиллагаа, зуух пийшингийн бүрэн бүтэн байдлыг шалган ажиллаж 545 өрхөд зуух, пийшингийн засвар үйлчилгээг хийсэн. Хяналт шалгалтын явцад зөрчилгүй, түүхий нүүрс хадгалсан, худалдаалсан 3-хан зөрчил илэрснийг бас мэдэгдэх нь зүйтэй байх. Танилцуулж дууслаа.

Б.Бейсен: Танилцуулга хийсэн Амартүвшин даргад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулан асуултаа асуух гишүүн нэрсээ өгнө үү.

Уянга гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2-ын хамтын ажиллагаа хэр байгаа вэ гэдгийг би асуумаар байна. Яагаад гэхлээр өнөөдөр бэлчээртэй холбоотой асуудлууд нэлээн хөндөгдөж байна. Дээрээс нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас орж ирж байгаа мэдээлэл дотор улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн зурвас газарт мал өвөлжүүлж, хаваржуулах асуудлууд хөндөгдөөд эхэлчихлээ. Бэлчээр дээрээ уул нь 2 яам хамтраад арга хэмжээгээ аваад явах ёстой. Тэгээд энэ ажил миний харж байгаагаар бол огт хийгдэхгүй байна. 2 яамны уялдаа холбоо огт харилцан ойлголцлын түвшинд ажиллаж чадахгүй байна гэж харж байгаа.

Ялангуяа цаг уур, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажил 4, 5 сар, 6 сар тодорхой хэмжээнд хийгдэх ёстой. Энэ тодорхой хэмжээний мэдээллүүдийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамандаа захиалаад, хамтарч ярилцаад аль бүс нутгаар зориудаар нөлөөлөх ажиллагаанууд хийгдэх ёстой вэ гэдгээ 4, 5, 6 сардаа та нар хийж байх ёстой байхгүй юу. Тэгээд энэ ажлууд чинь огт хийгдээгүйгээс улбаалаад сүүлийн 2

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

жилийн хугацаанд энэ бэлчээртэй холбоотой, гантай холбоотой, зудтай холбоотой, өвс тэжээлийн бэлтгэл хангамжтай холбоотой асуудлууд хүндэрчихлээ. Энийгээ яах вэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр бэлчээртэй холбоотой, хүлэмжийн ялгарлыг бууруулахтай холбоотой олон төсөл хөтөлбөрүүд явж байгаа. Энэ дээр тодорхой хэмжээний малчдыг бас орлогожуулах хөтөлбөрүүд ч байгаа. 4 нүүдэг байсан бол 8 нүүчих тэгээд тодорхой хэмжээний төсөв мөнгийг олон улсын зах зээл дээрээс босгоод авч байгаа. Ав гэдэг энэ систем 3 аймгийн нутаг дэвсгэр дамжаад явсан шүү дээ. Энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр хэр явж байгаа вэ? Цаашдаа улсын тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой асуудал дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ямар бодлого барьж явах юм бэ? Одоо өвөлдөө гэлтгүй асуудлууд үүсээд эхэлчихлээ шүү дээ. Зун хүртэл бараг тусгай хамгаалалттай газар нутаг руу мал оруулъя гэдэг асуудлууд үүсчихлээ. Эхнээсээ буу шийдэмдээ хүрч байх шиг байна. Тэгээд энэ дээр яам маань ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгийг би 1 дүгээрт асуумаар байна.

Ер нь зүгээр бид нар энэ уг эх сурвалж агуулгаа харахгүй бол асуудал шийдэгдэхгүй л дээ. 2024 онд 57.6 сая толгой малтай гэж байсан бол 2025 онд 1 жилийн дотор 20 саяар ихсээд 77.6 сая толгой мал болчихож байгаа юм.

Тэгээд Хөдөө аж ахуйн яам маань энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Ингээд автоматаар өсөх бодлого нь яваад байх юм уу? Жил болгон 20 сая толгойгоор нэмэгдээд байх юм уу? Араас нь тэгээд бэлчээр хэцүүдлээ, ган, зуд боллоо, өвөлжилт хүндэрлээ гээд энэ асуудлуудаа мөнгөн дүнгээр нь шийдэх гээд ингээд цаашдаа үргэлжлүүлээд явах юм уу гэдгийг би Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас асуумаар байна. Тэгээд дараа нь нийслэлээс асуулт асууя.

Б.Бейсен: 3 номерт Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Жамбалцэрэн. Засгийн газрын түвшинд салбарын яамнуудтайгаа хамтын ажиллагаа сайн ажиллаж байгаа. Ялангуяа манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамгийн тулгамдаж байгаа зүйл бол энэ уур амьсгалын өөрчлөлт. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй энэ ган, зудын давтамжийн нөлөө маш их байгаад байгаа. Ер нь цаашдаа энэ хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд уур амьсгалын өөрчлөлтөөс хараат бусаар, нэг ёсны хурмастаас хамааралгүй гэдэг юм уу энэ байгаль, цаг уурын эрсдэлийг даван туулах чадвартай газар тариалангийн салбар, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байгаа юм.

Тэгээд жил бүр л ингээд сүүлийн жил, ялангуяа сүүлийн жилүүдэд гангийн давтамж, зудын давтамжууд нэмэгдээд байдаг. Байгаль, цаг уур энэ бэлчээр, тэжээлийн нөөц хур тунадасны хэмжээ багасаад байдаг. Тухайн жилд нь мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтраад холбогдох тооцоо, судалгааг нь гаргуулаад, эрсдэлийн үнэлгээ хийгээд, мэргэжлийн байгууллагууддаа санал, дүгнэлтүүдээ гаргаж өгдөг, тодорхой хэмжээний үүлэнд нөлөөлөх захиалгуудаа өгдөг. Харамсалтай нь бас байгаль, цаг уур өөрөө энэ нөхцөлийг бүрдүүлэхэд бас тийм тааламжтай байхгүй байгаад байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ялангуяа энэ жилийн тухайд тариалангийн гол бүс нутгуудад ургац алдсан асуудлууд гарсан. Гангийн нэлээд өндөр гантай байсан. Тухайн бүс нутгуудад зориудаар нөлөөлөх гээд ч үйлийн хуримтлалууд сайн бүрдэж өгөөгүй ийм нөхцөл байдлууд байгаа. Тэрнээс биш яг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цаг уур, орчны шинжилгээнийхээ газруудтай бид нар холбогдох тооцоо, судалгаа хийгээд мэдээллээ солилцоод холбогдох арга хэмжээг аваад ажилладаг гэдгийг хэлье. Яг л энэнтэй адилхан энэ зудын эрсдэл өнгөрсөн жил гээд л тэгэхэд энэ манай зүүн бүсэд нэлээдгүй хэмжээний өндөр зудын эрсдэлтэй байсан. Мал аж ахуйн салбарт зүй бус хорогдлын хэмжээ 10 сая толгойд хүрсэн. Сүүлийн 3 жил энэ хөдөө аж ахуйн салбарын малын тоо, толгой нэг талдаа нэлээд сайн эдийн засгийн эргэлтэд оруулж байна.

Нөгөө талдаа байгаль өөрөө бас нэлээд тоо толгойг бууруулахад нөлөө үзүүлчхэж байна. Тэгэхээр жилдээ бид нар 20 сая толгой төл хүлээж аваад эргэлтэд оруулсан дүнтэйгээ 70 орчим саяд л сүүлийн 3 жил, 4 жил эргэлдээд байгаа. Энэ жилийн тухайд бид нар 65.7 сая толгой мал өвөлжинө гэсэн ийм тооцоо, судалгаа гаргаж байгаа. Саяын танилцуулга дээр нийтдээ нийт газар нутаг гээд ингээд аваад үзэхээр 20 хувь нь өндөр эрсдэлтэй бүсэд хамаарагдчихаж байгаа юм.

Тэгэхээр баруун бүс дээрээ бид нар ямархуу арга хэмжээ авах вэ, яаж энэ зүй бус хорогдлоос энэ мал аж ахуйн салбараа, малчдынхаа амьжиргааг хамгаалж авч үлдэх вэ гэдэг дээр л гол тулгуурлаж ажиллаж байгаа. Ер нь энэ бэлчээрийн таазтай мал аж ахуйн салбарыг тохируулан өсгөж үржүүлэх мал.../минут дуусав./

Б.Бейсен: Байгаль орчин 6 номер Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчны яам Төрийн нарийн бичгийн даргын орлогч Батбаяр байна. Бэлчээрийн хувьд тус тусгай хамгаалалттай газруудын хамрах хүрээ байгаа байгаль орчны нутагт нь өвөлжилт хүндэрсэн нөхцөлд мал бэлчээх асуудлаар Улсын онцгой комисс болон Хөдөө аж ахуйн яамнаас ирсэн чиглэлийн дагуу 233418 тоо малыг өвөлжилт, хаваржилт хийх, мөн хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр чиглэл өгч ажиллаж байгаа.

Тэгэхдээ энэ маань бас манай тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч байгаа зэрлэг болон ховордсон, нэн ховордсон амьтдын бас идэш тэжээл, амьдрах нөхцөлтэй давхар бас уялдаа холбоотой байдаг учраас бид бас мэргэжлийн байгууллагуудаасаа санал аваад ийм тоо гаргаад ажиллаж байгаа.

Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн зээлийн асуудал манай дээр хэрэгжсэн 3 аймгийн 5 сумд би малчдад бас тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд амьдардаг малчдын мал амьжиргааг дээшлүүлэх нөхцөлөөр зээл олгож явж байгаа. Энэ төсөл маань энэ жил дахин эхлээд явахаар Төрийн банкт бид бас яриа хэлцлээ хийгээд явж байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн торуулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ингээд нөгөө ерөнхий мэдээлэл өгсөөр байгаад л дуусаж байгаа юм л даа. Та хэд чинь уул нь мэргэжлийн хүмүүс ажиллаж байгаа гэж би ойлгож байгаа. Мэргэжлийн түвшинд хариулаасай л гэж хүсэж байгаа юм.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

77 сая толгой мал хүрчхээд байна. Жилд 20 сая толгойгоор нэмэгдээд байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ бэлчээрийн асуудлаа яаж шийдэх гээд байгаа юм бэ? Хамтын ажиллагаа өрнөж байгаа гэдгийг чинь ойлгож байна. Гэхдээ та хэд оройтож гарснаас улбаатайгаар наад үүлшилт үүсэх процесс чинь явахгүй байгаа байхгүй юу. Та нар 6 сард гараад ямар ч нэмэргүй шүү дээ. 4 сарын сүүлээс ажиллаж эхэлж байж наад үүлэнд зориудаар нөлөөлөх ажил чинь үр дүнд хүрнэ. Өөр ямар ч арга байхгүй. Тэгээд энэ дээрээ ямар бодлого шинэчлэлтэй ажиллаж байгаа юм бэ л гэдгийг би асуугаад байгаа юм. Одоо тэгээд цаашдаа 77 чинь 80 болох юм уу? Бэлчээр дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Бэлчээр чинь хомсдоод малын тоо толгой чинь ихсээд байгаа учраас наад зуд, ган гачиг чинь ихсээд байгаа юм шүү дээ.

Б.Бейсен: Хэдэн номер вэ? 3 номер Жамбалцэрэн дарга.

Т.Жамбалцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад тодруулж хариулъя. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй л энэ сөрөг нөлөө л гэж яваад байгаа. Газар тариалангийн салбар дээр бид аль болох усалгаатай газар тариалангийнхаа тоо хэмжээг нэмэгдүүлэх, аль болох ургац алдахгүй байх, хурмастаас хур хүлээдэггүй байх л энэ хэлбэр рүү л явах гээд бодлого, зорилтоо чиглүүлээд ажиллаж байгаа.

Мал аж ахуйн салбарын хувьд малынхаа үүлдэр угсаа, нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх энэ чиглэлд, нөгөө талдаа малын тоо толгойгоо зохистой түвшинд барихын тулд эдийн засгийн эргэлтэд оруулах энэ бодлого, зорилт дээр тулгуурлаж ажиллаж байгаа. Эдийн засгийн үр ашигтай хэлбэр рүү нь энэ хөтөлж авч явахгүй бол механикаар бид нар малын тоо толгойг тэдэд бариулна эдэд бариулна гэж малчид, иргэдийн амьжиргаатай учраас шууд тулгаж бид нар чадахгүй байгаа юм. Аль болох л эдийн засгийн эргэлтэд оруулах эдийн засгийн үр.../минут дуусав./

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: За байз яая даа байз. Та хэд арьс ширээ хэзээ үнэд оруулах вэ? Малаас гарч байгаа түүхий эдээ хэзээ үнэд оруулах вэ, хэзээ бүсчилсэн хөгжлийн бодлого хөтөлбөрийн хүрээнд боловсруулах үйлдвэрүүдийг сумдад барих вэ, хэзээ малчдыг нэмэлт орлоготой болгох вэ? Энэ чинь хийгдэхгүй бол наад малын тоо толгой чинь өсөж байж тэр малчин чинь зардлаа нөхөх хэмжээний болох гээд байгаа шүү дээ. Та хэд энэ дээр ямар бодлого хэрэгжүүлж байгаа вэ гэдгийг би асуугаад байгаа юм. Энэний чинь улбаа нь бэлчээр болоод, бэлчээрээс чинь улбаатай нь уур амьсгалын өөрчлөлт болчихоод байна дарга аа. Уур амьсгалын өөрчлөлт гээд эзэн биегүй юм руу чихээд байх юм. Наадах чинь тодорхой хэмжээнд зохицолдлогоог нь хийвэл бид нар бас хийх боломжтой шүү дээ. Орос, Украйны дайнтай холбогдуулаад Оросууд Сибирь дээр явдаг үүл зориудаар нөлөөлөх ажиллагаанууд чинь зогсчихсон шүү дээ. Харьцангуй үйл орж ирдэг болчихсон.

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үнэ цэнийг нь өсөн нэмэгдүүлэх зорилготой Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” гээд хөтөлбөр явж байгаа. Энэ маань өөрөө аж ахуйн нэгжүүдийн боловсруулалт, түвшин, технологийн түвшнийг ахиулъя. Нэмүү өртөг шингэсэн

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнхээ тоо хэмжээг нэмэгдүүлье гэдэг ийм зорилт. Энэ хүрээнд Улаанбаатар хотод Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн асуудал, баруун бүсэд Ховд үйлдвэр технологийн паркийн асуудал, Дархан-Уул аймагт Хөнгөн, хүнсний үйлдвэр технологийн цогцолборын ингээд бүтээн байгуулалтын ажлууд эхлээд явж байна. Ховдын үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил энэ онд дуусаад ирэх жил ашиглалтад орно.

Нөгөө талдаа манай боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа. Нөгөө талдаа бид нар.../минут дуусав./

Б.Бат-Эрдэнэ: Ашгүй микрофон ч олдлоо. Наадах чинь дарга юу байна шүү дээ та хэд ингээд олон жил энэ арьс шир боловсруулахтай холбоотой, үйлдвэртэй холбоотой асуудлуудаа ярьсаар л байна. Үр дүн алга. Та хэд хөдөө, орон нутагт хангалттай ажиллаж байгаа байх. Яам чинь ч хөдөө шилжчихсэн. Арьс шир худалдаж авч байгаа арьс шир чинь үнэд орж байгаа юмнууд байхгүй байна шүү дээ. Малчид чинь энийг үглэсээр л байна. Та хэдийн Төрийн ордонд яг энэ ярьж байгаа юмаа хэдэн жил ярих юм бэ? Малчдаа бид нар яаж орлогожуулах юм бэ л гэдгийг яриад байна шүү дээ. Малчид орлоготой болчихвол, хангалттай орлоготой болж байгаа тохиолдолд наад заавал малын тоо толгойг 1000 хүргэе гэдэг асуудал чинь байхгүй шүү дээ.

Түрүүн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Төрийн нарийн бичгийн дарга бас буруу мэдээлэл өгч байна. 3 аймгийн нутаг дэвсгэр дамжаад явж байгаа хүлэмжийн ялгарлыг бууруулахтай холбоотой карбон кредит зах зээлтэй холбоотой тодорхой хэмжээний мөнгөн дүнг малчид руу оруулж өгөөд явж байгаа. 200 толгой малтай малчин 5 сая төгрөг жишээлбэл нэмэлтээр аваад явж байсан. Гэтэл 200 толгой малтай малчин жилийн арайхийж 5 сая төгрөг олдог байхгүй юу. Тэгээд та хэд малчдаа орлогожуулж байгаа асуудал байхгүй сайхан амьдарч байгаа юм шиг зүйлийг энд яриад байдаг.

Гэтэл нөгөө талд чинь малчид чинь ядуу хэвээрээ ,малынхаа тоо толгойг арайхийж нэмэгдүүлж байж тэнд хүүхдүүдийнхээ сургалтын төлбөр, идэх, уух юмныхаа зардлыг арай хийж дааж байна шүү дээ. Та хэд Хөдөө аж ахуйн яаманд амьдрал сайхан байгаа юм яриад байх юм. Тэнд малчид чинь хэцүү байдалтай л байна ний нуугүй хэлэхэд. Мэдээллээ их зөв өгөөрэй гэж хэлье. Бас зөв яримаар байна.

Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Яг 2 яам Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон нийслэлийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой яг устай холбоотой хэсгүүдийг нь анхаараад харж байлаа. Тэгээд энэ дээрээ асуулт асууя. Худаг уст цэг гээд мэдээлэл дээр байгаагаар энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52, гадаадын төсөл ,хөтөлбөрийн 30, орон нутгийн төсвийн 235, малчдын өөрсдийн санаачилгаар 80 худаг гээд нийт 397 худгийг ашиглалтад оруулсан юм байна аа. Энэ ер нь хэр хангалттай тоо вэ? Нөгөө дандаа бид нар тоо л хараад байна л даа. Нэг тийм хүрэх түвшин нь тэд байсан, тэгээд тэрнийх нь тэдэн хувьд нь хүрлээ гэсэн ийм байдлаар танилцуулаад өгөөч.

Хоёрдугаарт нь ер нь нөгөө манай зарим гишүүд хүртэл ярьдаг юм газрын доорх усны судалгааг ерөөсөө ойлгодоггүй юм. Тэрийг судалж бараг яадаг юм

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гээд. Уул нь худаг ашиглаж л байгаа бол газрын доорх усаа судалж байна гэсэн үг. Худаг ашиглах гэж байгаа бол заавал цааш цаашдаа судлах ёстой гэсэн үг ээ. Тэгэхээр яг энэ судалгаа бас хэр явцтай явж байгаа юм бол? Ингээд 2 дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотойгоор танилцуулсан танилцуулгаас нь энийг асуугаад 3 дахь нь магадгүй Байгаль орчны яамны сайд байгаа юмыг чинь хариулаад явах юм болов уу. Ингээд газрын доор ус байлаа, худаг гаргалаа гэж бодъё. Тэнд дагаад усны чанарын асуудал яригдах ёстой. Ус байна гэдэг шууд аваад уучхаж болно гэсэн үг биш. Өдөрт бид нар усгүйгээр амьдарч чадахгүйтэй адилхан ямар ус хэрэглэж байгаагаасаа шалтгаалаад ирээдүйд өвчлөл нь ямар байх вэ гэдэг нь хүртэл яригдах ёстой.

Тэгэхээр энэ дээр зөвхөн ингээд тоон утгаар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52 худаг хийчихлээ гэхээр хэд байж байгаад хэд болчихсон юм бол усны гүйцэтгэл нь 100 хувьтай юм болов уу гээд дандаа ийм асуулт үлдээд байх юм. Тэгэхээр яг энэ дээрээ гүйцээгээд миний ярьж байгаа зүйлийг ойлгож байгаа байх. Тэгэхээр тийм гүйцэтгэл хангалттай юм уу үгүй юм уу? Ирэх онд хэдийг хийх ёстой юм ? 397 худаг, 400-аас 397 орчхоод байгаа юм уу? Тэгээд давхар усны чанарын судалгаагаа хэр явж байгаа талаар бас мэдээллийг өгөөрэй.

Хоёрт болохоороо нийслэлээс бас яг Ус сувгийн удирдах газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 80 хувьтай байна гээд дүгнэсэн хэсгийг нь нэлээн нарийн харлаа. Тэгэхээр эрчимжүүлэх ажил, 2025 онд оны бүтээн байгуулалтуудаас эрчимжүүлэх ажил гэдгээ дэлгэрэнгүй тавьж өгсөнд талархал илэрхийлье. Цэвэрлэх усны шинэ цэвэрлэх байгууламжтай холбоотой л хэсгүүд байна л даа. Нөгөө усыг бид нар ашиглаж байгаа юмыг чинь эргээгээд дахин ашиглуулах ёстой гэдэг концепц чинь зөв. Энэ төсөл ингээд хурдан орчхоосой. Тэгэхээр нөгөө технологийн горимоо хүйтний улирлаас өмнө зүгшрүүлнэ гэхихсэн байна. Тэгэхээр одоо бараг болчихсон тээ? Тэгэхээр энэ маань яагаад эрчимжүүлэх шаардлагатай ажилд орчхов? Энэ дээрээ хариулт авъя.

Үйлдвэрийн хаягдал усны бохирдлыг бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ гээд энэ үе шаттай хэрэгжинэ гээд нэлээн олон жил болчихсон юм байна лээ дарга аа. Тэгэхээр энэ бас л эрчимжүүлэх шаардлагатайдаа байгаад байх. Тэгэхээр энэ дээр бас нэмэлт тайлбар авъя аа.

Б.Бейсен: Эхлээд Хөдөө аж ахуйн яам дараа нь нийслэл хариулъя. Жамбалцэрэн дарга 3 номер.

Т.Жамбалцэрэн: Уянга гишүүний асуултад хариулъя. Нийт Монгол Улсын газар нутаг, тухайн бүс, сум, багуудад байгаа айл өрх, малын тоонд харьцуулаад үзэх юм бол манай бэлчээрийн усан хангамжийн суурь түвшинд 10 хувийг нь л хангаж байгаа. 10-хан хувийг нь. Тэгээд жилд бид нар улсын төсөв дээр 1 тэрбум төгрөгийн төсөв тавьдаг. Үүгээрээ 54, 5-н худаг л жилд гаргаж байдаг. Эргээд эх үүсвэр байгаад зардал мөнгө байдаг бол боломжтой хэмжээнд нь усны хайгуул, судалгаа хийсэн бүсүүддээ худаг, ус гаргах эрэлт, хэрэгцээ шаардлага маш их өндөр байгаа.

Б.Бейсен: Нийслэл 5 номер.

Л.Алтангэрэл: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга Алтангэрэл. Хотын усан хангамж,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ариутгалын өвөлжилтийн бэлтгэл ажил 88 хувьтай гэж энэ дээр дурдсан байгаа. Энэ дээр энэ 2025 онд Улаанбаатар хотод онцлог томоохон хэдэн бүтээн байгуулалтын ажил орж байгаа энэ салбарт. Хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах ажил энэ онд хийгдэж байна. Мөн түүнчлэн цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усаа дахин цэвэршүүлж ДЦС 3, 4-т технологийн хэрэгцээнд ашиглах энэ үйлдвэр гээд энэ томоохон бүтээн байгуулалтын ажилд энэ жил орж байгаа.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн туршилт, тохируулгын ажил 2025 оны 8 сарын 20-ноос эхэлсэн. Тухайн 8 сарын 25-наас эхэлж хоногтоо 25 мянган м3 усны усыг.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Л.Алтангэрэл: 8 сарын 25-наас 25 мянган м3 усыг туршилт тохируулгаар явж байгаа. Энэ өнгөрсөн долоо хоногоос Төв цэвэрлэх байгууламж 50 мянган м3 ус авч эхэлсэн. Тухайн яг туршилт тохируулах ажил бол төв цэвэрлэх байгууламжууд хийгдэж байгаа. Мөн Төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа усыг дахин, хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрийн туршилтын ажил мөн 10 сарын 1-нээс эхэлсэн. Өнөөдрийн байдлаар жоохон тэн дээр үйлдвэрийн хаягдал үйлдвэрээс хаягдал, энэ цэвэрлэх үйлдвэрээс гарч байгаа усны чанар жоохон асуудалтай байгаа. Энэ нөгөө ТЭЦ дулааны станц 3, 4-ийн технологийн хэрэгцээнд ашиглахад шаардлагыг тодорхой хэмжээнд азотын аммиак эд нар гээд өндөр гараад байгаа. Энэ юутай холбоотой гэхээрээ Улаанбаатар хотын хэмжээнд нийтдээ 700 орчим бохирдуулагч нэртэй үйлдвэр байна. Үүний дотроосоо энэ Төв цэвэрлэх байгууламж руугаа ирж байгаа 70 орчим, 70 үйлдвэр маш их

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Ойлголоо. Ерөнхийдөө ойлголоо. Ажлууд хийгдэж байгаа байх. Эрчимжүүлэх шаардлагатай ажилд яагаад орчхов оо? Бид нарт стандартын асуудал гэж хариулах гэж байсан юм болов уу? Бид нарын зүгээс дэмжлэг юу байна, юу хийх вэ? Яавал яг хэрэгжиж байгаа ажил болох вэ?

Б.Бейсен: 5 номер.

Л.Алтангэрэл: Энэ дээр сая өндөр бохирдлын агууламжтай бохир усыг төвийн шугам нийлүүлж байгаа 70 үйлдвэрийн асуудал байгаа. Энэ болохоороо үйлдвэрийн сүү, сүүн бүтээгдэхүүний 6 үйлдвэр, архи, пиво, спиртийн чиглэлийн 9 үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүний 36 үйлдвэр, талх нарийн боовны 14 үйлдвэр, арьс ширний 1, ноос угаах 4 үйлдвэрийн гэсэн ийм 70 үйлдвэр байгаа. Энэ 70 үйлдвэрүүд дээр тухайн бохир усаа урьдчилан цэвэрлэх байгууламжтай болох талын ажил 1 дүгээрт чухал. Энэ дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны болон бусад яамдын оролцоо маш их чухал байгаа юм аа. Тэр талаасаа бид нар эрчимжүүлэх энэ тал дээр орж ирж байгаа юм гэж юун дээр дурдсан байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ирүүлсэн энэ материал дээр Улсын Их Хурлын 7 тогтоол, Байнгын хорооны 11 тогтоол, Улсын Их Хурлын 27 шийдвэр бид нар шийдвэр яамнуудад ирүүлсэн боловч гүйцэтгэл ерөөсөө л 4, 5

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хувьтай л байгаа юм байна. Хэрэгжилт гэсэн үг тээ. Ирүүлсэн тайлан, өгч байгаа үүрэг, шийдвэрүүд ерөөсөө биелэгдэхгүй явж иржээ. Тэгээд энэнтэй холбоотойгоор бас ноцтой хэлэх юм байна л даа. Энэ эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт хөдөө аж ахуйн салбар дээр 6.9 хувьтай гарчээ. Үүн дээр ялангуяа өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой энэ хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүн, аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан мал амьтны гаралтай

Б.Бейсен: Мандхай гишүүн наадах чинь 3 дахь асуудал байхгүй юу.

М.Мандхай: Өө за за би тэгвэл энэтэй, яах вэ энэтэй чинь уялдуулаад л асуух гээд байгаа юм л даа уг нь. Ялгаа байхгүй энэ чинь гүйцэтгэл шүү дээ тээ. Гүйцэтгэл учраас. Тэгэхлээр энэ хэрэгжүүлээгүй байгаа гарч байгаа энэ үр дагавар өөрөө нэлээн эрсдэлтэй байгаад байгаа юм аа. Тэгэхлээр энийг хэрэгжүүлэхгүй өнөөдрийг хүртэл ялангуяа 36 дугаар тогтоолтой холбоотойгоор хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, энэ нь өөрөө өвөлжилтийн бэлтгэлд шууд хамааралтай учраас энэ ингээд өгсөн үүрэг даалгавар хэрэгжихгүй байгаад байгаа нь өвөлжилтийн бэлтгэл дээр нэгд ямар эрсдэл үүсэж байгаа вэ гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт хөдөө аж ахуйн салбарын энэ өвөлжилтийн бэлтгэлд 20 арга хэмжээ тусгасан. Эндээс аль арга хэмжээ нь хэрэгжээд, аль арга хэмжээ нь хэрэгжээгүй хоцрогдолтой байгаа талаар хэлж өгнө үү гэж хэлмээр байна.

Улсын хэмжээнд 1.3 сая тонн хадлан, 51 мянган тонн ногоон тэжээл, 26 мянган тонн үйлдвэрийн тэжээл бэлтгэгдсэн. Энэ дүн мал сүргийн 65.7 сая толгой өвөлжих нийт хэрэгцээний хэдэн хувийг хангаж байгаа вэ гэдэг асуулт тавимаар байна. Ялангуяа энэ яамны төсөвт хүчит тэжээлийн импорт, нөөцийн сан байгуулах тухай тусгай санхүүжилт тусгагдсан юм болов уу гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт мах, махан бүтээгдэхүүний экспорт 211.2 сая ам.долларт хүрсэн юм байна аа. Энэ нь өөрөө одоо яг ялангуяа энэ өвөлжилт дээр судлаачдын гаргаж байгаа тооцооллоор бараг 5 сая орчим мал хорогдох эрсдэлтэй байна гэсэн тооцоо байгаа. Тэгэхлээр дотоодын мах бэлтгэлийн нөөцийн бодлоготой ер нь хэрхэн уялдаж байгаа юм бэ? Нөөцийн махны худалдан авалт, хангамжийн бодлого 25 оны 12 сар, 26 он.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Мандхай гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын тогтоолоор үүрэг өгөгдсөн. Тогтоолын хэрэгжилт, гүйцэтгэлийг биелэлтийг хангуулаад Засгийн газрын хуралдаанд танилцуулаад эцэслэн шийдвэрлэгдээд тэгээд Байнгын хороонд дахин бас танилцуулна. Өнөөдрийн байдлаар 7 арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн. 12 арга хэмжээ нь хэрэгжих шатдаа, 1 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа. Хэрэгжээгүй байгаа заалтынх нь агуулга нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээт тарилга вакцинаар сольж, нэг ёсны таваарын арилжаа хийх, Эрүү мэндийн яамтай хамтран хийх гэсэн ийм заалт байгаа. Тэгээд энэ арга хэмжээ маань хэрэгжээгүй байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бусад арга хэмжээ бол хэрэгжилтийн түвшин харилцан адилгүй байгаа. Энэ жилийн Засгийн газрын тогтоолоор өвөлжиж, хаваржих малын тоог, айл өрхийн тоог өрхийн ам бүлийн гишүүдийн тоогоор нь нэлээд тийм нарийвчилж гаргасан. Тухайн аймаг, сум, багт өвөлжих малын тоо тухайн баг сумаар гарах, бэлтгэх өвс тэжээлийн нөөцийг нарийвчлан гаргасан. Түрүүн хэлсэн танилцуулга дээр өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад өвөлжилтийн бэлтгэлийн шаардлагатай нөөц бүрдүүлэлтийг 2 дахин нэмэгдүүлж бүрдүүлсэн гээд. Бид нарын гаргасан нарийвчилсан тооцооллоор өмнөх жилүүдэд бэлтгэгдэж байсан өвс тэжээлээс 2-оос 3 дахин илүү бэлтгэх ийм тооцоо, судалгаа гарсан.

Жилдээ бид 20 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүний 50 хувийг нь дотоодынхоо хэрэгцээнд, 50 хувийг нь экспортод гаргах гэсэн ийм бодлого, зорилттой ажилладаг. Энэ жилийн тухайд энэ өвөлжилт, хаваржилт, энэ зуншлагын нөхцөл байдлаас хамаараад, энэ өвөлжилтийн прогнозоос хамаараад эдийн засгийн эргэлтэд оруулах ажлуудыг эрчимтэй хийж байна.

Мал, махны экспорт мөн өнгөрсөн мөн үеийнхтэй харьцуулахад 25 хувиар өсөлттэй дүнтэй байгаа. Ялангуяа баруун бүсийн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, экспорт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн бичиг баримтыг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай нэг цонхны үйлчилгээгээр явуулах, лабораторийн шинжилгээг нь тухайн бүсэд нь хийх энэ чиглэлийн ажлуудыг хийгдэж байгаа. Амьдаар гаргах ажил маань ч гэсэн эрчимтэй явагдаж байгаа. Түрүүн танилцуулга дээр хэлсэн 56 сая толгой малыг амьдаар нь гаргасан байна гээд.

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой улсын төсөв дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дээр 1 ч төгрөг төсөвлөгддөггүй. Аймаг, сум өөрсдөө аюулгүй нөөцийг бүрдүүлж.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер гүйцээж яриулъя.

Т.Жамбалцэрэн: Малчдын түвшинд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажил маань бас нэлээд тавьсан үзүүлэлтүүд бас доогуур дүнтэй байгаа. Аймгуудын бэлтгэл ажил харилцан адилгүй. Яагаад гэхлээр төсвийн хэмнэлттэй холбоотой, төсвийн тодотголтой холбоотой аюулгүй нөөц бүрдүүлэх зардлыг нь багасгасан. Орон нутгийн өөрсдийн төсвийн хүндрэлээс хамаараад зарим аймаг өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр 100 сая төгрөгийн төсөв, аюулгүй нөөц бүрдүүлэх чиглэлээр тавьсан байхад зарим аймгууд нь тэрбум төгрөг тавьсан байх ийм нөхцөл байдалтай байгаа.

Хүнсний тухай хуулиараа аймаг, нийслэл, бүх шатны Засаг дарга хүнсний аюулгүй нөөцөө бүрдүүлэх үүрэгтэй. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээт мал, махыг, нөөцийн махыг бэлдэх үүрэг нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр байгаа. Бидэнд өгсөн мэдээллээр.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Одоо тэгэхээр аймаг бүр дээр төсөвлөгдсөн төсөв ер нь харилцан адилгүй байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө ямар хор уршиг, үр дагавар гарах вэ гэдэг дээр бас яамны зүгээс сонсмоор байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрдугаарт энэ Засгийн газрын 56 дугаар тогтоолоос гадна Улсын Их Хурлын 7 тогтоол, Байнгын хорооны 11 тогтоол, дэд хороодуудаас ирж байгаа тогтоолын биелэлтийг яамнуудад хүргүүлсэн. Энэний хэрэгжилт өөрөө дунджаар 5 хувьтай байгаа юм аа. Тэгэхээр энэ өгч байгаа үүрэг, даалгавар Улсын Их Хурлын энэ бодлого хэрэгжихгүй байх нь өөрөө ер нь яамны зүгээс юу гэж боддог юм бэ? Энэ хэрэгжихгүй бол энэ төрийн хяналт, хариуцлагын асуудал, тогтолцоо ер нь яах ёстой юм бэ? Ингээд нөгөө мэдээллээ өөрсдөө яг бүрэн сайн мэдэхгүй, ямар тогтоол, шийдвэр өгсөн гэдгээ сайн ойлгохоо бүр мэдээгүй гээд дутуу мэдээлэл өгөөд байгаа учраас.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Мандхай гишүүний асуултад тодруулж хариулъя. Өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбоотой бас тодорхой хүндрэлүүд байна аа. Түрүүн хэлсэн төсөв санхүүтэй холбоотой гээд. Аймаг, сум аюулгүй нөөц бүрдүүлэхээс харилцан адилгүй төсөвлөгдөж байна. Тэгэхээр энэ дээр санхүүгийн дэмжлэг бас шаардлагатай байгаа. Яг одоо орон нутаг дээр бодит байдал гээд л тэгэхэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, мал эмнэлгийн байгууллага, Онцгой байдал, эрүүл мэндийн байгууллага гээд өвөлжилтийн бэлтгэл хангах бензин шатахууны зардал байхгүй, туулах чадвартай унаа машин байхгүй гээд хамгийн зам, даваа гүвээ хаагдлаа гээд тэгэхэд зам, даваа гүвээг нь нээгээд өгөх туулах чадвартай хүч техник байхгүй гээд дандаа ингээд төсөв санхүүтэй холбоотой асуудлууд байгаад байгаа юм.

Нөгөө талдаа энэ улсын хилийн зурваст өвөлжих, оторлох малын тоог нэмэгдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутагт өвөлжиж хаваржуулах гээд асуудлууд ордог. Яг.../минут дуусав./

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээлэл орж ирж байгаа юм аа. Мэдээж манай хөдөө аж ахуйн салбарынхан, төв суурин газрынхан өвөлжилтийн бэлтгэл ажлаа нэлээн гайгүй базаасан байх гэж би ингэж ойлгож байна. Хөдөө аж ахуйн салбар дээр 3, 4 зүйл байгаа юм. Угаасаа зуншлага тодорхой, бэлчээрийн гарц тодорхой. Тийм учраас мал ангилалт, мах бэлтгэлийн асуудал юу юунаас л чухал л даа. Тэгэхээр энэ баруун бүс нутаг нэлээн тийм бэлчээрийн гарц тааруу байх шиг байна. Энд ер нь энэ ажил ямархуу байдлаар хийгдэж байна вэ? Бэлтгэгдсэн махны борлуулалтыг дэмжих бодлого, чиглэл гэж ер нь ямархуу юмаар та хэд бодлогын чиглэлээ хангаж ажиллаж байна вэ гэдэг асуудал.

2 дахь зүйл. Малаа ангилаад мах бэлтгэлт явуулчихсан юм бол үлдсэн малаа эрсдэлээс хамгаалж тэжээлийн л асуудал яригдана л даа. Тэгэхээр ургац чинь өөрөө бас ч тийм өмнөх жилүүдтэй адилгүй байгаа. Тэгэхээр гарах тэжээлийн чинь хэмжээ тодорхой. Тэгэхээр энэ дутагдаж байгаа тэжээлийг импортоор оруулж ирэх, тэр тусмаа баруун бүс нутгийн малын тэжээлийн импортын асуудлыг ер нь яаж шийдсэн юм бэ? Энэ хамгийн чухал зүйл байгаад байна.

Дараагийн нэг асуучихмаар байгаа зүйл бол ургац хураалтын мэдээ бүх юмнууд гарчихлаа. Улаан буудайн чанар ямархуу байв аа, борлуулалт ямар байна аа? Гурилын үйлдвэрлэлд үйлдвэрүүдийн элеватор дотор нь байж байгаа өмнөх

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

жилийн будаануудтайгаа энэ жилийн будаагаа жорлогч буюу сайжруулагчаар ашиглаад тээрэмдчихвэл стандарт хангасан гурил гарах бололцоо байна уу? Дутагдаж байгаа будаагаа ямархуу байдлаар зохицуулж шийдье гэж бодож байна? Дараагийн нэг асуудал нь улаан буудай төмс 2-ын үрийн хангалтын асуудлыг хэрхэн зохицуулах вэ? Одоо бид ирэх жилийн тариалалтынхаа юмыг л бодох ёстой хамгийн гол зүйл.

Байгаль орчны яам, Хөдөө аж ахуйн яам хоёр хоёулаа анхаарах ёстой юм. Энэ хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн асуудал дэлхий нийтээрээ яригдаад энэ хүлэмжийн хий ялгаруулаад байгаа томоохон үндэстэн дамначихсан компаниуд чинь дүйцүүлсэн хамгаалалтын асуудал яриад дэлхийн зах зээл дээр энэ чиглэлийн мөнгө нэлээн яваад байна аа. Энэ нь бидэнд хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ гэдэг нь бэлчээрээ сайжруулчих, цөлжилтөө бууруулчих бололцоо байгаад байгаа юм аа. Энэ рүү ер нь яаж идэвхийлэн орьё гэж бодож байна вэ? Дан дамаа Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яамтайгаа энэ 2 яам их холбогдож ажилламаар байна. Энд хэрэгжиж байгаа том төслүүдийг дагуулж энэ чиглэлийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх

Б.Бейсен: Батжаргал гишүүнд 1 минут.

Ж.Батжаргал: Нэмэгдүүлэх бололцоо байгаа. Тэгэхээр энэ яамнууд холбогдож ажилламаар байна. Дараагийн зүйл энэ хот суурин дээр энэ жил 25-аас 26 оны өвөл Улаанбаатарт шахмал түлш, хагас коксожсон түлш яг хэдий хэмжээний хэрэгтэй юм, үйлдвэрлэл дээр чинь ямарваа нэгэн асуудал бий юу байхгүй юу гэдэг асуудал байна. Нийлүүлэлт дээр чинь.

2 дахь зүйл халаалтын зуухнууд гэж 100 гаран зуух яригддаг байсан юм. Одоо яг хэд болсон юм? Тэрний түлшний бүтцийн өөрчлөлтийг ер нь ямархуу байдлаар хийсэн юм бэ гэдэг асуудал байгаад байна л даа. Үүн дээр тодорхой хариулт авчихъя гэж.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн яам 3 номерт Жамбалцэрэн дарга хариулъя. Дараа нь Байгаль орчны яам, дараа нь Нийслэл.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хүлэмжийн хийг бууруулахтай холбоотой энэ карбон зах зээлээс хөрөнгө оруулалт, мөнгө босгохтой холбоотой асуудал, салбарын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд яригдаж байна. Зүгээр яг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дээр энэ чиглэл дээр олон улсын байгууллага төсөл, хөтөлбөрүүд дээр хамтарсан тооцоо, судалгаа, туршилтын төслүүдийн эхлүүлэх ажил л явагдаж байгаа. Манай дээр энэ Засгийн газар, Их Хурал дээр ч гэсэн энэ яг карбон маркет дээр бид нар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотой, карбон зах зээл дээр Монгол Улс ямархуу байр суурьтай, ямар дүрэм, журам, ямар эрх зүйн орчны эрх зүйн хүрээнд оролцох юм бэ гэдгийг бас нэг талдаа журамлаад эрх зүйн орчныг бүрдүүлээд өгөхөд ажиллах өргөн боломж байгаа юм байна гэж харж байгаа. Гадна, дотнын олон улсын байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны ирэх жилүүдэд олон улсын байгууллага төсөл, хөтөлбөрүүдээс санхүүжүүлдэг энэ хэлбэр рүү явна гэдэг чиглэлүүдээ өгөөд байгаа. Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, холбогдох яамнууд бас энэ дээр бас нэмж тайлбаруудаа өгөх байх.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Мал, махаа эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал дээр салбарын яамнаас эрчимтэй ажиллаж байгаа. Ялангуяа энэ сүүлийн жилүүдэд гадаадын, дотоодын энэ өндөр, дээд хэмжээний айлчлалуудын хүрээнд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох хорио цээрийн протоколууд тохирох, гэрчилгээ, мэдэгдлүүд тохирох ажлуудыг эрчимтэй хийгдэж байгаа. Энэний үр дүнд ялангуяа энэ Төв Азийн буюу истаны орнууд руу экспорт эрчимтэй нэмэгдэж байна. Ялангуяа Узбекистан, Киргизстан, Казахстан, Иран, тэгээд Оман гээд Африкийн зарим орнууд руу ч гэсэн мал, мах гарах ийм бололцоо бүрдсэн. БНХАУ-тай махны экспорт хийгдэж байна. Ойрын хугацаанд нэмээд бид нар адууны дайвар бүтээгдэхүүнийг экспортлох хорио цээрийн нөхцөлөө тохирчихсон. Одоо албажуулах үлдсэн. Ингээд явах юм бол бусад төрлийн гүн хөлдөөс ингээд дараагийн шат руугаа бид нар оролцох бололцоо байгаа. Нийтдээ өнөөдрийн байдлаар 37 улстай хорио цээрийн протоколд тохирчихсон, гэрчилгээ мэдэгдэл тохирох ажлууд хийгдэж байгаа. Аль болох эдийн засгийн эргэлтэд оруулах, хил гааль дээр учирч байгаа тэр хүндрэл чирэгдэл, бичиг баримтыг хөнгөвчлөх чиглэлийн ажлуудыг хийж ажиллаж байгаа.

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой УОК-оос өгсөн чиглэлийн дагуу салбарын яам ажилласан. Тодорхой хилийн бүс нутгуудад ажилласан. Энэ чиглэлээр Засгийн газар дээр тодорхой шийдвэр гаргаад маргаашийн Засгийн газрын хурлаар Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж, Их Хуралд өргөн барихаар ажиллаж байгаа. Улаан буудай нөөцийн хувьд 100 мянган тонн улаан буудай бид нар импортоор авахаар ийм тооцоо, судалгаа гарсан байгаа.

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя. 4 номер.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Энэ жилийн тухайд ургацын чанар бид бас хэдийгээр хэмжээ бага байсан ч гэсэн чанар урьд жилүүдтэй харьцуулахад харьцангуй сайн байлаа. Тухайлах юм бол бид нар хөдөө аж ахуйн корпорацад 28 мянган тонн буудай аваад байна. Урьд жилүүдээс харахад бол 1, 2 дугаар ангилалд нь 10-15 хүн тушаагддаг байсан бол энэ жилийн буудай бол энэ 28 мянган тонн дээр аваад үзэхэд яг 25 хувиар ингээд тэнцүүхэн 4 ангиллын будаанууд тушаагдсан байгаа. Тэгэхээр энэ жилийн будаа бол гурилын үйлдвэрүүдийн үлдэгдэл 18 мянга дээр үйлдвэрүүдийн авсан 126 мянган тонн будаа, дээрээс нь хөдөө аж ахуйн корпорацын авсан 28 мянгыг ингээд нэмээд үзэхэд бол чанар дээр ямар нэгэн асуудал гарахгүй нь гэж ингэж харж байгаа.

Сая би Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг хуралдуулж импортоор авах хүнсний улаан буудай болон үрийн улаан буудайн хэмжээ, квотыг батлуулсан байгаа. Тэгээд ингээд.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Эрсдэлийн хувьд бол улаан буудай үрэн дээр анхаарах ийм зайлшгүй шаардлага байна. Тариаланчдын хувьд урьд нь 40-өөс, 40 гаруй мянган тонн үрийн нөөц бүрдүүлдэг байсан бол энэ жилийн тухайд 26 мянган тонныг бүрдүүлсэн байна. Хөдөө аж ахуйн корпорац сая энэ намрын ургацаас 7 мянга гаран тонн үрийн улаан буудайг худалдаж авлаа. Дээрээс нь 15 мянган, 12 мянган тонн үрийн улаан буудайг үрийн шинэчлэлд зориулж аж ахуйн нэгжүүд импортоор авахад нь энэ Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөс квотыг нь гараад

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаад ингээд зохион байгуулалтын арга хэмжээг авч байна.

Гурил үйлдвэрлэлд шаардлагатай 150 хүртэл мянган тонн хүнсний улаан буудайн квотыг бас гурилын үйлдвэрүүд, холбогдох туслах аж ахуйтай тэжээлийн үйлдвэрүүдэд ингэж олгохоор энэ сонгон шалгаруулалтын ажлаа зарлаад хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Б.Бейсен: Байгаль орчны яам Батбаатар сайд.

Б.Батбаатар: Уур амьсгалын өөрчлөлт, энэ хүлэмжийн хий, Парисын конвенц гээд ингээд энэ чиглэлд Монгол Улсын Засгийн газар ажиллаж эхэлсэн. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр “3.0”-г Засгийн газрын хуралдаанаар батлуулж НҮБ-ын конвенцын газарт хүргүүлсэн байгаа. НҮБ-ын 80 дугаар ассамблейгаас өмнө. 2013 онд Япон улстай хүлэмжийн хийн хэлэлцээрээр гэрээ байгуулснаас хойш нийтдээ 13 төсөлд 160 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтыг Япон улсаас авсан. Үүний 50 орчим сая доллар нь Японы Засгийн газраас буцалтгүй тусламжаар орж ирсэн. Сая 3 жил гацчихсан байсан Монгол, Сингапурын хүлэмжийн хийн хэлэлцээрийг гарын үсэг зурснаар энэ 1 дүгээр сард.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Энэ 1 дүгээр сард 2 улсын Засгийн газраас байгуулах ажлын хэсгүүд ярилцаад ингээд нөгөө төслүүдийг эрэмбэлээд урьдчилсан санхүүжилт олгохоор ярьж байгаа. Үүн дээр хүнс, хөдөө аж ахуйн салбар, хот байгуулалтын салбар, зам тээврийн салбар, эрчим хүчний салбар, байгаль орчны салбаруудад урьдчилсан санхүүжилт буюу эрсдэлийн санхүүжилт олгохоор ийм зүйлийг ярьж байгаа. Мөн өнөөдөр Засгийн газар дээр энэ 3 дахь өдөр маргаашийн хурлаар оруулахаар бэлтгэж байгаа Швейцар улстай хүлэмжийн хийн хэлэлцээр байгуулахаар яамнуудаас санал авах ажлууд явж байгаа. Энэ ажил харьцангуй сүүлийн 10 гаран жил хөдлөөгүй байсан ажлууд хөдөлж байна гэж ойлгож болно.

Б.Бейсен: 6 номер Нийслэлийн Засаг даргын орлогч Амартүвшин хариулъя.

А.Амартүвшин: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар хагас коксын нөөц бол сайжруулсан түлш 1800 тонн, хагас кокс 11200, мидлинг 69.2 мянган тонн бас бэлэн байна. Хагас кокс импорттой холбоотойгоор бол гааль дээр бол бага зэргийн удаашралд байгаа. Тэгэхдээ гаалийнхантай яриад энэ удаашралын асуудлыг бол шийдвэрлээд явж байгаа. Юун дээр халаалтын зуух дээр нийтдээ Улаанбаатар хотод 60 байршилд 174 усан зуух бол усан халаалтын зуух үйл ажиллагаа явуулж байгаа. Засаг даргын 8 сард гаргасан түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглосон буюу өнгөрсөн оны 8 сард гаргасан түүхий нүүрсийг Улаанбаатар хотод бол ашиглахыг хориглосон ийм захирамжийн дагуу эдгээр зуухнууд бол бүгд хий болон мидлингийг хэрэглэх рүү бол шилжиж орсон байгаа.

Мөн Хэсэгчилсэн инженерийн төвийн 12 зуухыг Засаг даргын нөөц хөрөнгө.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

А.Амартүвшин: Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 тэрбум төгрөгийг бол гаргаж нийтдээ энэ 12 зуухыг бол ул ширмийг засаж янзлах, шинэчлэх ажлууд хийгдээд дуусаж байна. Эдгээр зуухнууд 87 мянган тонн түүхий нүүрсийг бол хэрэглэдэг байсан. Энэ нь бол нийтдээ бол 302 мянган тонн хагас коксыг хэрэглэсэнтэй адил агаарын бохирдлыг Улаанбаатар хотод бол нийлүүлдэг байсан. Одоо бол мидлинг бол хэрэглэгдээд зарим нь бол газ болон цахилгаан руу бол шилжсэн байгаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм Хөдөө аж ахуйн яам анхааралдаа авмаар байгаа юм. Тэр малын тэжээлийг баруун бүс нутгаар импортоор оруулж ирэх асуудлыг тооцоо, судалгаатай маш яаралтай шийдэх ёстой. Ингэж байж бид энэ тэжээлийн хангалтыг хийнэ. Хүнсний улаан буудай импортоор оруулж ирж болно оо. Та бүхэн минь квотоо их нарийн бариарай. 2021 онд 200 гаруй мянган тонн улаан буудай оруулж ирснээс чинь болж газар тариалан гурилын үйлдвэрлэлийн салбарт салбарт зохицохгүй хэрүүлүүд үүссэн шүү. Үүнийг ямарваа нэгэн байдлаар давтаж таарахгүй ээ. Тийм учраас энийг онцгой анхаарах ёстой.

Гэхдээ бидний суурилуулсан хүчин чадал 800 гаруй мянган тонны суурилуулсан хүчин чадал байгаад байдаг будаа тээрэмдэх. Үнэхээрийн экспортынхоо гэрээ хэлцлийг хийчихсэн газар байдаг юм бол будааг нь импортоор оруулж ирээд тээрэмдүүлээд гаргах хэрэгтэй байгаа юм бүтээгдэхүүнийг нь. Ингэж байж энэ суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлж нэг хэсэг хүмүүсээ бид.../минут дуусав./

Б.Бейсен: Батжаргал гишүүн үг хэллээ. Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе. Надаа мал, махыг эргэлтэд оруулах чиглэлээр ганц нэг асуулт байна. Үндсэндээ. 2024 оны мал тооллогын дүнгээр 57.7 сая мал, 25 онд 20.5 сая төл хүлээж авсан гээд нийтдээ 78.4 сая мал Монгол Улсад өнөөдөр байна. Тэгээд үүнээс 14.9 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн тооцоо, судалгаа байгаа юм байна. Уг нь энэ 14.9-өөс 4.9. сая толгой малыг экспортод гаргана гэсэн байдлаар энэ танилцуулгад сая танилцуулагдлаа. Яг өнөөдрийн байдлаар яг хэдэн улсад хэдэн 2025 оны хувьд хэдэн улсад хэдэн сая мал экспортод гаргаад байна вэ? Өнөөдөр яг гадагшаа экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийн хэчнээн аж ахуйн нэгж байна? Цаашдаа энэ аж ахуйн нэгжүүдийн тоо толгой нэмэгдэх боломж байгаа юу гэдэг дээр бас маш тодорхой хариулт өгөөч ээ.

Яг одоогийн байдлаар энэ 10 сар, 10, 11 сарын байдлаар энэ 4.9 сая толгой малын экспортод гаргах малын гүйцэтгэл хэдэн хувьтай байна вэ? Он, энэ оны төгсгөл мөн энэ өвлийн байдлаар он гараад хүлээгдэж байгаа гүйцэтгэл ямаршуу тоо толгой гарах вэ? Энэ дээр тодорхой бас мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Үндсэндээ Монгол Улс нийтдээ 37 улстай мал, амьтан, түүний дагалдах бүтээгдэхүүнтэй хорио цээрийн протокол тохирсон байдаг. Өнөөдрийн байдлаар адууны махыг

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ОХУ, Япон, БНХАУ, Узбекистан, Казахстан, Тажикистан гээд эдгээр улсуудад гаргаж байна. Адууны мах нийтдээ 25 мянган тонн, мөнгөн дүнгээр нь аваад үзэх юм бол 93.7 сая долларын мах гаргасан. Хонь ямааны махыг Азербайжан, Иран, Ирак, Хонконг, Узбекистан, Арабын Нэгдсэн Эмират, Катар, Вьетнам, Армен, Оман, Кувейт, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс гээд нийтдээ 14.9 сая тонныг нийтдээ 62.2 сая долларын ийм бүтээгдэхүүн гаргасан байна.

Үхрийн мах Узбекистан, малын дайвар Азербайжан, Ирак, Япон, БНСУ, малын дайвар бүтээгдэхүүн дотроо өлөн гэдэс Азербайжан, Австри, Испани, Нидерланд, Япон, Итали, Узбек гээд улсууд руу гарч байна. Адууны махны экспортын эрхтэй Монгол Улсад 14 аж ахуйн нэгж, хонь, ямааны махны, түүхий мах экспортын эрхтэй 18 аж ахуйн нэгж, үхрийн түүхий мах экспортод гаргасан 1 аж ахуйн нэгж, малын дайвар бүтээгдэхүүн 5 аж ахуйн нэгж, өлөн гэдэс 7 аж ахуйн нэгж, дулааны аргаар боловсруулсан мах, энэ дотор консерв гэдэг юм уу бусад төрлийн БНХАУ руу гарч байгаа дулааны аргаар боловсруулсан махыг нийтдээ 14 аж ахуйн нэгж гаргаж байгаа ийм үзүүлэлт байна.

Өнөөдрийн байдлаар гээд тэгэхэд үндсэндээ 56 мянган тонн мах нийтдээ гарсан. Бид нар 160 гаруй мянган тонн махыг экспортлох боломж байна гэж ингэж тооцож байгаа. Урьдчилсан гүйцэтгэлээр бид нар 120 орчим мянган тонн махыг энэ явж байгаа урсгалаараа гаргачих бололцоо байна л гэж. ингэж харж байгаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Ер нь мах экспортлох аж ахуйн нэгжүүдийн тоо цаашдаа нэмэгдэх үү, нэмэх шаардлага байгаа юу? Одоогийн тохирлын гэрчилгээ авсан экспортолж байгаа аж ахуйн нэгжүүдийн чадамж, боломж бололцоо ер нь хэр байгаа юм? Яагаад би ингэж асууж байна гэхээр маш олон аж ахуйн нэгжүүд тэр дундаа манай зүүн бүсийн, зүүн бүсэд мал бах мал, мах бэлтгэж байгаа аж ахуйн нэгжүүд маш ихээр бас мах экспортлох боломж байна. Бидэнд энэ чөлөө зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ юм нь олдохгүй, чөлөө зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж дээр бас мах экспортлох ажил өнгөрсөн хугацаанд маш ихээр хийгддэг энийг өөрсдөө хийдэг болмоор байна гэдэг асуудлуудыг маш их тавьдаг аа. Энэ тал дээр бас яам тодорхой хариулт өгөөч.

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Салбарын яамны хувьд энэ мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийг аль болох л тухайн улсууд руу нь уламжилж, экспортын эрх авах, тухайн улсдаа импортлох эрх олгох чиглэлд нь идэвхтэй ажилладаг. Гол нь энэ ДМАЭМБ, энэ хүнсний хорио цээрийн энэ олон улсын конвенцоор импортлогч улс импортлох бүтээгдэхүүнийхээ зөвшөөрлийг өөрсдөө өгдөг. Өөрсдөө эрсдэлийн үнэлгээ хийж, хянан магадалгаа хийж өгдөг. Манайхаас тухайн улсуудын хорио цээрийн нөхцөл, шаардлагад тохирсон үйлдвэрийнхээ хянан магадалгаанд орох итгэмжлэл, хүсэлтийг тухай бүр ч хүргүүлдэг. Энэ хүрээндээ импортлогч улсуудаас холбогдох зөвшөөрлийг олгодог. Энэ суурь нөхцөл нь өөрөө энэ малын эрүүл мэндтэй холбоотой. Нөгөө талдаа энэ үйлдвэрлэлийн.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулъя 3 номер.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Т.Жамбалцэрэн: Технологийн урсгал гэдэг юм уу, энэ халаал технологи гэдэг юм уу өөрсдийнх нь шаардлага технологи байдаг. Энд нь нийцүүлээд бид нар аж ахуйн нэгжүүдийнхээ гаргасан хүсэлтийг тухайн импортлогч улсад хүсэлтийг гаргаад эцсийн шийдвэрийг тухайн улсууд гаргадаг. Дээр нь энэ өвчний нөхцөл байдлаас хамаараад бусад олон улсуудтай энэ хорио цээрийн нөхцөл, шаардлагад тохирох боломжууд байдаг хэдий ч тээврийн ас асуудал маш их хүндрэлтэй байдаг. Ялангуяа манай 2 хөрш буюу ОХУ, БНХАУ-ын нутгаар салаа туурайтан мал, амьтны арьс шир, үс ноос, дайвар бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэхгүй гэдэг асуудал байдаг. Тэгээд энэ асуудлыг бид нар төрийн дээд хэмжээний олон айлчлал арга хэмжээнүүд дунд удаа дараа энэ хүсэлтүүдийг тавьдаг боловч тухайн улсуудад транзит тээврийн асуудлуудыг зөвшөөрдөггүй асуудал байгаа. Энийг бид нар шийдвэрлэж чадах юм бол дэлхийн бусад орнууд, энэ далайн тээврээр гэдэг юм уу бусад өөр өргөн боломжууд ашиглах бидэнд боломж, бололцоо байгаад байгаа юм.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүнд тодруулъя.

У.Отгонбаяр: Ер нь миний асуугаад байгаа зүйл одоо энэ экспорт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэх шаардлага байна уу үгүй юү? Та нар юу гэж бодож байгаа юм? Ямар бодлого барьж байгаа юм, эс үгүй бол яг энэ 14, 18 гээд нөгөө төрөл, махныхаа төрлүүдээр саяын тоонууд аж ахуйн нэгжүүдийн тоонууд хэлж байна шүү дээ. Эд нар өшөө нэмэгдэх шаардлага байна уу үгүй юү зах зээлийнхээ зарчмаар? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Дээрээс нь энэ хонины ноосыг эргэлтэд оруулах чиглэлээр яам ямар бодлого барьж байна вэ? Би саяхан тэр “Share Mongolia” гээд олон улсын биш, ТББ-ын Монгол дахь салбарын төлөөлөлтэй уулзсан. Тэгээд цаашдаа энэ хонины ноосыг эргэлтэд оруулах чиглэлээр сургалт, семинар Хөдөө аж ахуйн яамтай хамтарч хийх ийм боломж, бололцоо байгаа гэж ярьж байсан. Цаашдаа тэр ноос хяргах чиглэлээр залуучуудыг бэлтгэх сургалтуудыг хийх боломж байгаа гэж ярьж байсан. Мөн тэд нар нь өвөл.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Отгонбаяр гишүүний асуултад тодруулж хариулъя. Экспортын эрхтэй аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлага байгаа. Улс болгон харилцан адилгүй өөр өөрийн тавьдаг стандарт шаардлагуудтай. Манайд дийлэнх мал, махны экспорт явж байгаа БНХАУ-д экспорт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлага байгаад байгаа. Гэхдээ импортлогч улс бол тодорхой тоонд бариулах тийм зорилготой байдаг гэж хэлж болохоор байгаад байгаа юм. Тодорхой шалгуур, шаардлагын үндсэн дээр зарим аж ахуйн нэгжүүдийн эрхийг цуцлаад буцаагаад зөрүүлж оруулах тохиолдлууд байдаг. Түрүүний тэр улсуудын экспортын эрхийг тоог ярьсан. Зарим аж ахуйн нэгжүүдийнх нь эрх нь давхацсан байгаа шүү. Дулааны аргаар боловсруулах эрхтэй мөртөө давхар Ойрх Дорнод бусад улсууд руу гаргах эрхтэй гэдэг юм уу, хонь, ямааны мах эрхтэй гээд давхардсан тоо бас байгаа.

Хонины ноосон дээр салбарын яамнаас “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ахиц гаргахаар ажиллаж байгаа. Энэ чиглэлээр олон улс.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Т.Жамбалцэрэн: Олон улсын байгууллагуудтай хэд хэдэн хамтын ажиллагааг эхлүүлээд ажиллаж байна. Мөн Монгол Улсын Төрийн тэргүүний айлчлалын хүрээнд бид нар Киргиз улстай хамтарсан хонины ноос боловсруулах, ноосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулаад хамтарсан үйлдвэр байгуулах чиглэлээр холбогдох судалгааг хийгээд ажиллаж байна. Мэргэжлийн байгууллагууд, ТББ-ууд, мэргэжлийн холбоодоо нэгтгээд ажлын хэсэг байгуулчихсан бизнесийн байгууллагын төлөөллүүд ажилласан. Тэнд нэлээд өндөр хүчин чадалтай үйлдвэр ашиглагдахгүй байгаа. Манайхаас түүхий эдээ аваад хамтраад ажиллая гэсэн ийм тооцоо байгаа.

Нөгөө талдаа ноосны асуудал гээд ярихаар нөгөө талдаа үржлийн асуудал ярих болж байгаа юм. Тэгэхээр манай ноосны маань өөрийн нөгөө шаардлага маань үйлдвэрлэлийн шаардлагыг зарим тохиолдолд хангахгүй нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр үржил дээрээ бид нар нарийн, нарийвтар ноосныхоо чиглэлээр үржүүлж байж нарийн, нарийвтар ноосоо бүрэн арагш ашиглах ийм шаардлага байгаа. Одоо байгаа.../минут дуусав./

Б.Бейсен: Жамбалцэрэн дарга Отгонбаяр гишүүнд бас бичгээр энэ юугаа бас өгчхөөрэй тодруулаад.

Мөнхсайхан гишүүн асуулт асууя.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд бид нар өвөлжилтийн бэлтгэл ажлыг нэлээн эртнээс л өнгөрсөн жилүүдэд ярьж эхэлдэг л дээ. Тэгээд яг эрсдэл гарсан тохиолдолд авч байгаа хариу арга хэмжээ маань бас төдийлөн хурдан шуурхай, оновчтой биш ийм зүйлүүд гараад байдаг. Тэгэхээр бид нар энэ өвөлжилтийн бэлтгэл ажил хангах энэ арга барилаа бас ер нь нэлээн шинэчлэх ийм шаардлагатай болов уу гэж харж байгаа юм.

Жишээ нь саяын энэ нийслэлийн танилцуулга дээрээс харахад 177 боловсролын байгууллагад их засварын 27.1 тэрбум төгрөг тавигдсанаас энэнээс 41 ажлын төсөв нь хасагдсан байгаа юм. Тэгээд үүнээс үүдэлтэйгээр 30 сургуульд цэцэрлэг, сургуульд хүндэрч болзошгүй гэдэг ийм эрсдэлтэй нөхцөл байдал байна гэдэг ийм мэдээлэл энэ дээр байна л даа. Тэгэхээр энэ нийслэлийнхэн маань энэ бусад улсууд ДНБ-ийхээ энэ Ази Номхон далайд, Ази Номхон далайн улсуудад 5.1 хувийг энэ сургууль, цэцэрлэгийнхээ дэд бүсэд зарцуулаад байдаг. Гэтэл манайх дөнгөж 1.8 хувьтай буюу 3 дахин бага байгаад байдаг. Гэтэл энэ төсөв дээрээ тодотгол хийгээд хэмнэлт хийхээрээ энэ сургууль, цэцэрлэгийнхээ их засвар, халаалт, дулаалгаас хасаад байдаг нь ямар учиртай юм бэ? Энэ дээрээ та бүхэн маань ер нь энэ төсөв дээрээ ямар хэмжээний үнэлгээ, дүгнэлт хийж энэ төсвөө ер нь ингэж хасаж танаж байгаа юм бэ? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Ер нь бусад улсууд энэ боловсролын байгууллага сургуулийн өвөлжилтийн тусгай ийм төлөвлөгөөтэй байдаг. Нийслэл хотын хувьд ийм төлөвлөгөө байна уу? Байгаа бол энэ яг ямар төлөвлөгөө энэ 30 сургууль дээр ер нь ямар арга хэмжээ авах гэж байна аа? Тэгэхгүй бол одоо энэ сургуулиуд ид хүйтний үеэр сургууль доторх дотоод орчны температур 18 градусас доош ороход сургууль, цэцэрлэгийн хүүхэд багш нар өвдөх эрсдэл 2.5 дахин нэмэгддэг гэдэг ийм судалгаанууд байгаа. Тэгэхээр энэ 30 сургууль дээр энэ хүүхдүүд, багш, ажилчид маань эрсдэлд орох нь ээ. Тэгэхээр энэ ямар 30 сургууль ийм эрсдэлд

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

орох гээд байгаа юм? Энийгээ эргээд эцэг эх, ар гэрийнхэнд нь энэ мэдээллийг нь та бүхэн хүргэж өгч байгаа юу? Хүргэж өгөөгүй бол энийг та бүхэн маань мэдээлэх эртнээс бэлтгэл ажлыг нь бас хангуулах ёстой, тийм үүрэгтэй байх аа. Эдгээр асуултуудад хариулт өгөөч.

Б.Бейсен: 6 номер Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Мөнхсайхан гишүүний асуултад хариулъя. Эхний хөрөнгө оруулалтын хувьд бол эдгээр 30 сургууль, цэцэрлэгийн асуудал бол хасагдсан гол зүйл нь батлагдсан нөгөө зураг, төсөвгүй учраас хасагдсан байгаа. Тэгээд бид нар зураг, төсвийнх нь ажлыг нь хийж гүйцэтгэж дуусгаад Нийслэлийн иргэдийн хурлын Төлөөлөгчдийн хурлын төсвийн тодотгол дээр нэмж оруулаад дээрээс нь Засаг даргын нөөц хөрөнгөөс мөнгө гаргаад эдгээр сургууль, цэцэрлэгүүдийн ажлын явц хий эхлээд явж байгаа. 11 сарын 15-наас өмнө бид нар дуусгана гэж бол ажлыг бол шахаад бол явж байгаа.

Одоо бид нар дээр боловсролын салбар дээр нэг анхаарах гээд маш том зүйл байгаа. Бид нарын насжилт гэдэг асуудлууд явчихсан. Одоо бид нар шинээр барих энэ асуудлууд яваад байдаг. Нөгөө хуучин сургуулиудын засвар нь бараг шинэ сургуулийн барихдаа ч адилхан тийм засваруудын мөнгө шаардагдахаар болчихсон ийм асуудлууд явж байгаа юм.

Жишээлбэл сургуулийн барилгын, нийт Улаанбаатар хотод байгаа сургуулийн барилгын 53.3 хувь нь буюу юунаас 16 жилээс дээш насжилттай болчихсон гээд. Их засвар орохоос өөр ямар ч аргагүй болчихсон. Дандаа их засварууд шаардлагатай болчихсон. Өмнө нь орж байгаагүй нөгөө шугам, тэгээд барилгын битүүмж гээд, дээвэр гээд энэ бүх асуудлууд.

Цэцэрлэгийн нийтдээ 31.8 хувь нь ингээд 16 жилээс дээш насжилттай болчихсон. Одоо ингээд нийслэлийн ирэх жилийн хөрөнгө оруулалт дээр бид нар дахиад энэ засвар, үйлчилгээнийх нь мөнгийг нэлээн 30-40 тэрбумыг бол тавихаар төлөвлөөд явж байгаа. Энэ жил бид нар 30 тэрбумыг бол тавьж өгч засвар, үйлчилгээнд зарцуулсан. Дараа жил бид нар энийг дахиад нэмж тавьж өгөхгүй бол эдгээр өндөр насжилттай сургууль, цэцэрлэгүүд ингээд үйл ажиллагаагаа явуулахад шууд утгаараа хэлэхэд үйл ажиллагаа явуулах хад маш хүндрэлтэй заримууд нь үйл ажиллагаа явах боломжгүй болчихоод байгаа. Ямар ч байсан бол энэ жилдээ бид нар шаардлагатай байгаа бүх сургууль, цэцэрлэгүүдийн засварыг бол төсвийн тодотголоор орж нөхөж оруулж ирээд засвар, зураг төслийг нь хийж дуусаад засаад дуусаж байгаа. Дараа жил хийгдэх эдгээр сургууль, цэцэрлэгийн засварын ажил, их засварын ажил, зураг төслүүдийг бол хийгээд эхэлчихсэн байгаа. Тийм болохоор дараа жил дээр ингэж араас нь цаг алдаж хийхгүй, асуудал үүсэхгүй гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа.

Б.Бейсен: Мөнхсайхан гишүүн тодруулъя.

Т.Мөнхсайхан: Тийм. Тэгэхээр та бүхнийг энэ төсвөө батлахдаа эрсдэлтийн үнэлгээ хийж энэ асуудлаа энэ эрэмбэлж чадаж байна уу гэдэг асуудлыг цаашдаа анхаарахгүй бол ингээд сургууль, цэцэрлэгийн энэ гол асуудал халаалт энэ өвөлжилтийн бэлтгэл ажил нь ингээд тасалдаад байх ийм эрсдэлүүд өндөр байна. Тэгэхээр энэ дээр эрсдэлийн үнэлгээ хийдэггүй бол тэрийгээ та бүхнийг хийдэг болооч гэдэг асуудлыг ярьж байгаа юм.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2 дугаар гол асуудал энэ сургууль, цэцэрлэгүүдийг өвөлжилтийн тусгай төлөвлөгөөг та бүхэн минь гаргах хэрэгтэй байна. Гэхдээ энэ жил та нар энэ жилийн өвөлжилтийн тусгай төлөвлөгөө биш одоо та нар ирэх жил сургуулиудын өвөлжилтийн төлөвлөгөө ямар байх вэ? Энэ дээр сургууль, цэцэрлэгийнхээ өвөлжилтийн тусгай төлөвлөгөөг ирэх жилийнхийгээ гаргаад энэ төсөвтөө тусгах асуудлаа эртнээс шийдэж яваач ээ. Байхгүй бол энэ төлөвлөгөөгөө гаргаарай гэдгийг хэлж байгаа юм.

Б.Бейсен: Мөнхсайхан гишүүн үг хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Хөдөө аж ахуйн яамны мэдээлэлтэй холбоотой 3 асуулт байна.

1 дүгээрт нь энэ жил улсын хэмжээнд 1656 багт ,213 мянган өрхөд 65.7 сая мал өвөлжих нь. Нийт газар нутгийн бэлчээрийн 46 хувь нь гантай гэж байна. Гэтэл 25 онд нөгөө даатгуулсан энэ чинь 25 оны даатгал чинь 26 оноо үйлчилдэг тиймээ? 23 мянган малчин өрх 3.4 сая малыг 4.1 тэрбум төгрөгөөр даатгуулсан гэж. Ер нь энэ малчдыг мал сүргээ даатгуулах энэ сэтгэлгээ, хандлагыг нь өөрчлөх чиглэлээр яам юу хийж байна аа? Ялангуяа маш хүндрэлтэй байгаа гэх тэр Баян-Өлгий, Увс, Ховдынхонд даатгуулсан уу? Тэгээд энэ чинь бас хэдийгээр хувийн өмч ч гэсэн бид энэ даатгалынх нь тал дээр төрөөс баримтлах бодлого нь ер нь юу явах юм цаашдаа? Бас өмч хөрөнгөө даатгуулах сэтгэлгээнд сургах хэрэгтэй байна 1 дүгээрт нь энэ чиглэлээр юу хийгдэж байна?

Хоёрт нь одоо энэ Төв аймгийг Хэнтийг дуусгаад Дорнод руу орж байгаа энэ олон мянган адуутай энэ баячуудыг яах ёстой вэ? Адуу 5 амтай гэж ярьдаг. Үндсэндээ бэлчээрийн хамгийн их сүйтгэл чинь адуун дээр явж байгаа. Тэр уядаг хүлдгийг нь чөлөөлөөд эсвэл өндөр татвар тогтоох юм уу? Одоо Дорнодын нөгөө сайхан нарийн бэлчээртэй юу чинь адууны хөлд үрэгдээд дуусаж байгаа юм байна лээ шүү дээ. Бэлчээр хамгаалах энэ чиглэлээр юу хийдэг юм? Түрүүнд бэлчээр хамгаалалтыг уур амьсгалын өөрчлөлттэй холбоод яриад байгаа харагдана лээ. Үүнээс гадна энэ чинь хувь хүний хандлага, манай малчдын ялангуяа энэ увайгүй зөвхөн өөрсдийгөө бодсон энэ баячуудын энэ сэтгэлгээ бас өөрчлөх цаг болсон байх аа. Тэр 100, 200-д нь болох юм гэхэд тэр мянга мянгаар нь бэлчээр талхлахдаа зүгээр уядаг хөлдөх ч юм байхгүй бие биедээ аархдаг юм уу яадаг юм энэ чиглэлээр юу хийх юм?

3 дахь асуудал нь хөдөө бол яг үнэндээ хавартай ноолуур, энэ жил яах вэ мах гайгүй байна. Экспорт гаргаад. Өөр ерөөсөө үнэтэй юм байхгүй шүү дээ. Нөгөө арьс шир, түүхий эд, нөгөө Цагаан алт хөтөлбөр гээд л бид Хүнсний хувьсгал гээд л олон гоё гоё хөтөлбөр батлаад Улсын Их Хурлаас олон тэрбум, их наядаар нь мөнгө тавьж өгөөд байгаа юм. Цагаан алт дээр чинь бид нар чинь улсын төсвөөс 682.4 тэрбум төгрөг тавьж өгсөн юм байна шүү дээ. Тэгээд нөгөө боловсруулалтын түвшин 25-55 хувь хүрнэ ээ ноос боловсруулалт. Арьс шир боловсруулалтын түвшин 30-50 хувь хүрнэ гэсэн одоо хаа байна аа? Сая тойрогтоо ажиллаад ирлээ. Амьдрал үнэхээрийн энд ярьж байгаагаас чинь өөр байна шүү. Бодлогын яам яг энэ чиглэлээрээ яг юу хийх вэ гэдгийг маш тодорхой үр дүн юу гарсан бэ гэдгээ ярихгүй бол ингээд үлгэр яриад байхаа одоо ер нь болимоор байна шүү хаа хаанаа. Бид энд баахан хөтөлбөр, мөнгө тавиад байдаг. Гаргаад, батлаад төсвийг

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нь тавиад байдаг үр дүн гардаггүй. Тойрогтоо очихоор бид нарыг өөдөөс шахаад байдаг.

Нийслэлтэй холбоотой. Шахмал түлшний нөөц түгээлт чинь ер нь хэр байгаа вэ? Сая энэ 10 сарын дундуур жоохон цас ороод хүйтэрсэн хүмүүс түлшиндээ очерлоод байгаа харагдсан.../минут дуусав./

Б.Бейсен: Ганбаатар гишүүнд 1 минут. Ганбаатар гишүүн микрофоныг.

Г.Ганбаатар: Сая нэг хэсэг машиндаа хийх бензингүй, гэртээ түлэх түлээгүй боллоо шүү дээ энэ гэр хороолол. Гэр хорооллынхон ч юу байх вэ дээ бараг бүгдээрээ тийм болсон. Тэгээд энэ ч энэтэй холбоотой. Өнгөрсөн хавар хагас кокс нүүрс оруулж ирнэ л гэж ярьж байсан Нийслэл дээр. Нямбаатарын дарга энд мэдээлэл хийж байсан. Тендерт нь тэр сая юм харж байсан тэр “shanxi coal semical industry group” шалгарсан юм байна. 2200 км-ийн цаанаас ямар үнэтэй ирж байгаа юм наад нүүрс чинь? Бид 200 км төмөр замаа тавих гэж үйлээ идээд 70 доллароор зардаг нүүрсээ өнөөдөр хэдээр авч байгаа юм, хэдийн алдагдалтай иргэдэд өгч байгаа юм? Ер нь яг ямар ухаанаар 70 доллароор зарсан нүүрсээ бид 2200 км-ийн цаанаас аваад байгаа юм.

Дараагийн асуулт нь өнөө өглөө би тэр доктор Энхбаярын бичсэн юмыг уншиж байлаа. Үнэн, худлааг нь би мэдэхгүй. Гэхдээ тэр бас доктор хүн ортой байлгүй 12.1 мянга 9

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн яам Есөн-Эрдэнэ. Төрийн нарийн хариул эхлээд 3 номер.

Т.Жамбалцэрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Малчин өрх малаа даатгуулж байгаа асуудал улсын хэмжээнд нийтдээ 23 мянган малчин өрх 3.9, 4 сая толгой мал даатгалд хамруулагдсан. Үндсэндээ Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс гээд эрсдэл бүхий аймгууд нийтдээ сая мал даатгуулсан. Малчин өрхийн тоо 3400 өрхийг даатгуулсан ийм үзүүлэлттэй байна. Малын индексжүүлсэн даатгал өөрөө бас их сайжруулах шаардлага байгаа. Засгийн газар дээр Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Салбарын яамны хувьд энэ малын тоо толгойд албан татвар ноогдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Намрын чуулганд багтаад Улсын Их Хурлаар өргөн барьчихна. Энэ хуулийн гол агуулга, өөрчлөлт нь суурь татварыг тавиад өгчхөж байгаа юм. Малын амьд толгой л байгаа бол суурь нь тэдэн төгрөг. Дээшээ аймаг, орон нутгийнхаа иргэдийн хурлаараа дээд хязгаарыг нь тогтоочихно. Энэ дээр адуу, үхэр гээд тодорхой ангиллаар нь хамгийн дээд хэмжээгээр нь тогтоогоод өгөх боломж нь нээлттэй байгаад байгаа юм. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар зарим эрхийг нь, бүх эрхийг нь ер нь орон нутгийн иргэдийн хуралд өгчихсөн. Зарим бүс, аймаг, орон нутгууд бид нар тэмээгээ өсгөх гэж байгаа гэдэг юм уу адуугаа өсгөх гэж байгаа гэдэг юм уу татвараас чөлөөлчихсөн асуудлууд бий. Гол маргаан хаана үүсдэг вэ гэхээр тариалангийн гол бүс нутгуудад энэ татвартай холбоотой асуудлууд үүсдэг. Тэгэхээр энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулаад энэ намрын чуулгандаа өргөн барина гэж ингэж тооцож байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой Цагаан алт хөтөлбөр хэрэгжээд жил хүрэхгүй хугацаа өнгөрч байна. Аж ахуйн нэгжүүд тодорхой хэмжээний арилжааны банкны санхүүжилтүүдээ аваад өргөтгөл шинэчлэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, бүтээн байгуулалтын ажлуудаа эхэлсэн. Эхний үр дүнгүүд бол ирэх жилээс гараад явах болов уу гэж ингэж тооцож байна. Зөвхөн үндэсний томоохон үйлдвэрүүд, бас технологийн түвшин нь боловсруулалтын түвшнээсээ хамаараад зээлүүдэд хамрагдаж байгаа асуудлууд байна. Эдгээр үйлдвэрүүд маань хүчин чадлаараа ашиглалтад ороод явах юм бол ЖДҮ-үүд дагаад кластер үйлдвэрлэлүүд орон нутагт хөгжөөд явах бололцоо.../минут дуусав./

Б.Бейсен: Нийслэл 6 номер хариулъя.

А.Амартүвшин: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Шахмал түлшний нөөц яг өнөөдрийн байдлаар сайжруулсан түлш 1800 тонн, хагас кокс 11200 тонн, мийдлинг 69.2 тонн нүүрстэй бол би яг өнөө өнөөдрийн байдлаар явж байна. Цэгүүд дээр яг өнөөдрийн байдлаар 2325 тонн нүүрс бол ингээд зарагдаад явж байна.

Тасарсан асуудал бол 2 асуудал зэрэг үүсээд нүүрс тасарсан байгаа. Нүүрсний бол нөгөө түгээлт дээр бол ингээд асуудал үүссэн байгаа. Энэ дээр нь бол юу вэ гэх юм бол нөгөө түгээлтийн компани нийслэл дээр бол тендер зарлаад түгээлтийн 26 компани тендерээр шалгасан. Энэ юу вэ гэх юм бол “Тавантолгой түлш”-ээс борлуулалтын цэг, “Тавантолгой түлш”-ээс агуулах руу зөөдөг эдгээр 26 компаниас бол 2 компани нь үйл ажиллагаагаа 20 хувиас доош явуулсан байгаа. Үүнтэй холбогдуулаад тухайн компанитай хариуцлага тооцоод тэгээд гэрээг бол цуцалж ажилласан байгаа. 18 машиныг бол нийслэлийн нийтлэг үйлчилгээнээс бол авто машин техникийг бол гаргаад түгээлтийг хийгээд явж байгаа. Одоогийн байдлаар түгээлт жигдрээд явж байгаа.

Хоёрт нь болохоор нөгөө “Хотула” систем рүү бол бид нар холбосон байгаа. Сайн картыг холбоод дээрээс нь “Хотула” систем маань болохоороо Дан систем e-Mongolia, Хас юу руу орсон байгаа. Тэгээд энэ холболтын явц дээр нийтдээ нөгөө 2 280 гаруй мянган карт бүртгэгдээд гараад ирсэн. Тэгэхэд түлш хэрэглэгч дээр бол 172 мянган айл өрх хэрэглэдэг. Тэгсэн мөртөө 282 мянга гаруй карт ашиглагдаад яваад байдаг. Тэгэхээр энэ картын цэгцлэлтийн ажлыг хийгээд энэ долоо хоногтоо бол бид нар хийгээд дуусна гэж төлөвлөгөөтэй ажиллаад явж байна. Энэ дундаас бол ингээд нийтдээ 7200 гаруй нас барсан иргэн одоо хүртэл.../минут дуусав./

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя. Гүйцээж хариулъя 6 номер, 5 номер. 2200км-ийн цаанаас ингээд түлш зөөж байгаа юм байна шүү дээ наашаагаа.

Х.Ариунзаяа: Сайн байна уу? Ганбаатар гишүүний асуултад хариулъя. “Тавантолгой түлш” компанийн Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ариунзаяа. Бид 7 дугаар сард нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаад бүгд БНХАУ-ын Шаньси мужийн Шинму хотод байрлах үйлдвэр шалгарсан байгаа. Аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулаад тээвэрлэлтийг 9 дүгээр сараас эхлээд бид зохион байгуулаад ажиллаад явж байгаа. Ингэхэд 2200 километрийн цаанаас биш 1500 орчим километрийн цаанаас би тээвэрлэлтийг хийж байгаа. Гадаад

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тээвэртэй Эрээн хүртэлх үнэ маань тонн тутамд 738500 төгрөг байгаа. Үүн дээр нэмэгдээд дотоод тээвэр, компани дээр ирээд савлах зардал, тээвэрлэх, түгээх зардалтайгаа нийлээд ойролцоогоор 1 сая 100 орчим мянган төгрөг байгаа.

Иргэдэд борлуулж байгаа үнийн хувьд гэх юм бол Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Х.Ариунзаяа: 9 дүгээр сарын 9-ний өдөр Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороон дээр хагас коксожсон шахмал түлшний үнийг тонн тутамд нь 200 мянган төгрөг буюу 1 шуудайг нь 5 мянган төгрөгөөр тогтоосон байгаа. Үүний дагуу иргэдэд нийлүүлээд ажиллаж байгаа. Чанарын хувьд гэх юм бол Хятад Ард Улсын ахуйн хэрэглээний шахмал түлшний стандартад нийцсэн шахмал түлш байгаа. Чанарын хувьд бол бидний экспортод гаргаж байгаа 70 долларын үнэтэй нүүрснээс өөр байгаа.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: 2200 биш 1500км-ээс ирж байгаа юм байна. Ойрхон юм байна тээ? Дээрээс нь энд 1.1 саяд орчим төгрөгөөр ирж байгаа юм байна шүү дээ. Дотоод тээврээ нэмээд тэгээд 200 мянган төгрөгөөр нийлүүлж байгаа. тонн тутамд 900 мянган төгрөгийн алдагдалтай энэ зөв үү?

2 дахь асуудал нь зөвхөн ингээд энэ 10 дугаар сарын байдлаар 1600 хүн угаартсан гэж байна. Өнгөрсөн 8 жилд бид түлшээ 2 удаа, дээрээс нь энэ зуухаа 2 өрхийнхөө айл өрхийн зуухыг 2-3 удаа, дээрээс нь тэр угаарын мэдрэгчийг нь 3-4 удаа солилоо. Асуудал юундаа байна? Яагаад энэ олон хүн угаартаад байна? Нийт нас барсан угаарын хийгээр нас барсан хүний тоо хэд хүрчхэв? Монгол хүний үнэ цэн, амь нас гэж юм байна уу? Яг надад тоо тодорхой хэлээдэх энэ Байнгын хорооны хурал дээр. Нийт өнгөрсөн 8 жилд 12.9 мянган хүн угаарын хийгээр хордож нас барсан, хордсон юм байна. Түүний яг хэд нь нас барсан?

Б.Бейсен: 6 номер хариулъя. Амартүвшин дарга.

А.Амартүвшин: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2025-2026 оны шилжих өвөл буюу одоо 9 сарын 15-наас хойш нийт эмнэлэгт хүргэгдсэн гэсэн үг, нийт эмнэлэгт хүргэгдэж эмчилгээ авсан 269 иргэн байгаа. Угаартай холбоотойгоор эмнэлэгт хэвтэж эмнэлгийн анхан шатны болон дунд шатны үйлчилгээ авсан. Харамсалтайгаар бол 9 иргэн угаартаж бол нас барсан. Энэ бол юутай холбоотой гэх юм бол өрхөө бүтээсэн, агааржуулалтынхаа системийг унтраасан, дээрээс нь нөгөө ухаалаг мэдрэгчүүдээ унтраасан, ухаалаг мэдрэгчүүдээ салгасан иймэрхүү өрхөө бүтээсэн, яндангаа авсан гэдэг иймэрхүү асуудлууд бол мэргэжлийн болон цагдаагийн, эрүүл мэндийн байгууллагуудаас шинжилгээний дүгнэлтүүдийг гаргаж нийслэлд хүргэсэн байгаа.

Б.Бейсен: Гүйцээж яриулъя 6 номер.

А.Амартүвшин: Угаарын хий мэдрэгчийн хувьд бид нар өнгөрсөн жил 172 мянган айлдаа буюу нөгөө түлш хэрэглэж байгаа 172 мянгатай айлдаа 121 мянгыг нь бол ухаалаг угаар мэдрэгчээр холбочихсон ажиллаж байгаа. Яг одоо бол 12

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мянган ухаалаг угаар мэдрэгч айлдаа холбогдоод тест нь бол хийгдээд явж байна. Дахиад НИТХ-ын хурлаар 2 сарын өмнө төсөв дээр нэмэгдэл дээр 6.5 тэрбум төгрөг батлаад 45 мянган угаар мэдрэгчийг бол нэмэлтээр худалдаж авах ажлыг зохион байгуулаад явж байна. Гэрээний шатан дээр бол яг явж байна. Энэ ондоо багтаагаад 45 мянган айлаа холбох ажлыг зохион байгуулж дуусаад ингэснээр нийт манай Улаанбаатар хотод түлш хэрэглэж байгаа бүх айлууд ухаалаг угаар мэдрэгчтэй, нэгдсэн хяналтын систем дээр бол энийг бол хянаад тэгээд шууд хяналтад авсан айлууд, өрхүүд рүү энэ.../минут дуусав./

Б.Бейсен: Гишүүдийн асуусан асуултад энэ Төрийн нарийн, сайдуудаасаа гадна салбарын дарга нар бас тодорхой хариулт өгч байвал зүгээр байна.

Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өвөлжилтийн асуудлаар хэдүүлээ бас хэлэлцэж байна. 2023-аас 24 оны бас өвөл Монголчууд бидэнд бас нэлээн сургамж болсон. Сүүлийн 60 орчим жил тохиолдоогүй бас нэлээн хүнд өвлийг бид бүхэн бас туулсан. Монгол Улсын хэмжээнд нийтдээ 9.3 сая малыг бид бүхэн хорогдуулсан. Үүнд хамгийн их бас хохирлыг амссан бүс нь Зүүн бүс нутаг болсон. Зүүн бүс нутаг 15- 50 хүртэлх хувийн малаа алдсан байгаа. Тэгээд энэ нэлээн хатуу ийм сургамж болсон. Үндсэндээ 9.3 сая малыг бид нар эдийн засгийн тооцооллоор нь авч үзэх юм бол 3.4 их наяд төгрөгийн асуудлыг бид бүхэн малын зүй бус хорогдлоор алдсан байгаа. Ойролцоогоор манай мал аж ахуйн салбарын энэ 10 орчим хувийг давсан ийм үзүүлэлт. Тэгэхээр энэ өвөлжилтийн нөхцөл байдал, малын зүй бус хорогдолтой холбогдолтой асуудал дээр бид нар нэлээн сайн нарийн дүн шинжилгээ хийх ёстой. Энэ 2023-аас 24 оны шилжих энэ бас өвлийн хамгийн чухал асуудал нь түлш, шатахууны асуудлаас болсон ийм асуудал бас үүссэн.

Тийм учраас өнөөдрийн энэ өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдолтой асуудал ярьж байгаа дээр Байнгын хорооноос тодорхой санал чиглэл өгдөг юм уу, ер нь салбар яамнууд бүгд энэ асуудал дээр нэлээн онцгойлон анхаарахыг нь бас зөв юм гэж ингэж бас харж байна. Сая би Хэнтий аймгийн Мөрөн сумын Иргэдийн хурлын даргатай бас уулзалт хийгээд ингээд орж ирж байна. Төв зам дагуу байгаа сумууд хүртэл бензиний хомсдолтой ирэн очин ийм нөхцөл байдалтай байна. Тэгэхээр бид өвөлжилтийн бэлтгэл ажил гээд л баахан бас юм яриад л ингээд л явдаг. Тэгэхдээ яг бодит байдал дээрээ нөгөө малчид маань өвс тэжээлээ бэлдэх, түүнтэй холбогдолтой асуудлаа хийхэд маш энгийн асуудлаас болоод л бид бүхэн бас ингээд даван туулж чадахгүй нөхцөл байдал үүссэн. Тэгээд энэ бас битгий давтагдаасай. Энэ жилийн хувьд бас гол анхаарах зүйл нь энэ байгаасай гэдгийг би бас сануулж хэлье.

Цаашдаа эдийн засгийн үр өгөөж талаасаа зүй бус хорогдлыг бууруулах чиглэл дээр гол анхаарлаа хандуулах дээр мал бэлтгэлийн үйл ажиллагааг энэ жил их тийм өөр түвшинд зохион байгуулах шаардлагатай талаар гишүүд хэлж байна. Хүнсний хувьсгалын хөтөлбөр, Шинэ хоршоо хөдөлгөөн гээд олон хөтөлбөрүүдийг бид бүхэн хийсэн. Ингээд сайн үр дүнгүүд гараасай гэж бодож байна. Энэ дээр тодорхой ногоон тэжээл тариалсан, тэжээл бэлдсэн малчдын тоо хэр их өссөн бэ? Энэ жил энэ үүний үр нөлөө хэр гарах вэ? Мөн дээрээс нь мах бэлтгэлийн хөргүүр, зоорь, түүнтэй холбогдолтой ийм бас аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тоо хэр нэмэгдсэн бэ? Эдгээр аж ахуйн нэгжүүдийг мал

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бэлтгэлийн үйл ажиллагаа явуулахад нь бид яаж дэмжих вэ гэдэг энэ агуулга руу бид бүхэн хоёрт бас анхаармаар байна.

3 дахь нь тэжээл бэлтгэлтэй холбогдолтой, уялдаа холбоог нь сайжруулахтай холбогдолтой энэ газар тариалан болон мал аж ахуйн салбарын энэ уялдааг захиалгат тариалан тодорхой хэд хэдэн арга хэмжээнүүдийг урьд нь авч хэрэгжүүлж байсантай холбогдолтой ажлыг бас хэрхэн хийж байна? Энэ чиглэлээр бас тэжээлийн үнэ нэмэгдүүлэхгүй байх чиглэл дээр.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга. 4 Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Ганхүлэг гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр ер нь зудын давтамжийн ой санамж бас их ойрхон байгаа энэ жилийн тухайд. Тийм учраас бас энэ жилийн энэ зуны гангийн нөхцөл байдалтай уялдуулаад өвөлжилтөд бас дор бүрнээ тодорхой хэмжээнд, малчдын түвшинд, сум орон нутгийн түвшинд, аймаг орон нутгийн түвшинд энэ бэлтгэл тодорхой хэмжээнд бас урьд жилүүдийнхээс илүү хангагдаж байгаа гэж ингэж үзэж байгаа. Ер нь таримал тэжээлийн үнэ цэнийг малчид нэлээн сайн ойлгосон. Энэ нь бол энэ сүүлийн 10-аад жилийн хугацаанд сүүлийн 10 жилийн хугацаанд гарч байгаа энэ ган, зудын давтамжийн хугацаа ойртсон энэ цаг үед, хуучин бол үйлдвэрээс гарч байгаа хивэг, гурилын үйлдвэрээс гарч байгаа хивэг, байгалийн хадлан дээр л түшиглэж малчид малын тэжээлийг нөөцөлдөг байсан бол одоо ингээд өөрсдийн түвшинд малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх, өөр хүчит тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч байна.

Тухайлах юм бол энэ эрдэнэ шиш, шар буурцгийн тариалалтуудыг нэлээд аж ахуйн нэгжүүд хийдэг болоод эхэллээ. Хамгийн дээд талын аж ахуй 550 га-д эрдэнэшишийн тариалалтыг хийж дарс хийж байна. Энэ нь бол энэ эрчимжсэн мал аж ахуй, цаашлаад энэ малчдын түвшинд энэ уурагт тэжээлээр хангах энэ боломжийг бүрдүүлж байгаа нь бол бас энэ их эрсдэлийг бууруулах, зудыг даван туулахад тодорхой дөхөм болж малчдын ойлголт бас нэг талдаа арай өөр болж байгаа нь бол мал сүргийнхээ тоонд анхаарах, чанарт анхаарах энэ чиглэл рүү явж байна гэж ингэж хэлж болохоор байгаа.

Тэгээд малчид бас хоорондоо энэ Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршоод тэжээл тариалалт дээр нэлээдгүй хэмжээний бас хөнгөлөлттэй зээлийг авсан. Нийт шинэ хоршоогоор авч байгаа зээлийн 60 орчим хувь нь малын үүлдэр угсааг сайжруулахад гарсан бол 10 орчим хувь нь энд техник, тоног төхөөрөмжийг шинэчлэл дээр гарсан байдаг. Үүнтэй холбоотойгоор малчдын түвшинд энэ тэжээл тариалалт бас багагүй хэмжээгээр нэмэгдэж байгаа ийм тооцоо судалгаанууд байна.

Бид нар энэ Хүнсний 36 дугаар тогтоол үргэлжлүүлээд Атарын IV аяны хүрээнд олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлээрээ энэ махны зоорины аж ахуйг нэмэгдүүлэх чиглэлээр бас хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон. Энэ дээр аж ахуйн нэгжүүд орон нутгийн түвшинд бас жижиг зоориудыг байгуулах хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд нэлээдгүй хэмжээгээр хамрагдсан. Энэ хамрагдаад бас хүчин чадал нэмэгдсэн тоо баримт, судалгааг танд бас албан бичгээр хүргүүлье. Энэ дээр дорвитой, ялангуяа сүүлийн жилүүдэд төмс, хүнсний ногооны зоорь, махны зоорины хэмжээ бол нэлээдгүй хэмжээгээр нэмэгдсэн. Сүүлийн 3 жилээр аваад үзэх юм бол хүнсний ногооны зоорины хэмжээ бол 54 мянган тонноор

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэмэгдсэн, махны зоорь 20 гаруй мянган тонн, 30-аад мянган тонноор нэмэгдсэн ийм тооцоо судалгаанууд гарсан байгаа.

Тэгэхээр мэдээж энэ хэт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд хэрэгжээд 1, 2 жилийн дотор үр дүнгээ өгөхөөсөө илүүтэй энэ 1, 2 жилийн дотор олгосон зээлүүд дээрээ бүтээн байгуулалтаа хийгээд 3 дахь жилээсээ үр дүнгээ өгөөд явах ийм боломжтой. Гэсэн хэдий ч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөтөлбөр тус бүр дээр хагас жилээр, жилийн эцсээр үнэлгээ хийж ажиллаж байна гэдгийг бас танд хэлье.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хөтөлбөрүүдийн уялдаа холбоон дээр тодорхой үр дүнгүүдийг гаргаад явах ёстой. Таны хэлж байгаа саналыг илүү нарийвчилж цаашдаа бид ярих ёстой. Ингэж байж үндсэндээ зудын эрсдэлт байдлыг малчид өөрсдөө бие дааж даван туулах энэ бололцоо бидний зорилго энэ рүүгээ чиглэнэ.

Отрын бүс нутагтай холбогдолтой асуудал дээр бас нэмж асууя. Хэнтий аймгийн бас тодорхой сумдууд, Дорнод аймгийн бас тодорхой хэсгүүд дээр жилийн жилд үндсэндээ отрын малууд бас очиж өвөлждөг. Энэ жилийн хувьд бэлтгэл ажил түүнтэй холбогдолтой ямар ажлууд хийгдэхээр байна? Хэдий хэмжээний мал хуй бас очиж өвөлжихөөр байна. Мөн дээрээс нь энэхүү тодорхой зохицуулалттай холбогдолтой асуудлууд жилийн жилд бас гардаг. Бусад энэ төвийн бүс нутгаар бас отор нүүдлийн энэ асуудал бас жилийн жилд хийгд бас гардаг. Түүнийг бас хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг тал дээр бас нэмэлт хариулт авъя. Дахиад бас экспорт.../минут дуусав./

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 2 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Өдрийн мэнд хүргэе. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүрэг гүйцэтгэгч Мөнхнасан. Энэ жилийн тухайд нийтдээ 6 орчим сая мал отроор өвөлжүүлэх, өвөлжих шаардлагатай байгаа. Эдгээр малын 1 орчим хувь нь улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээрт өвөлжихөөр байна. Аймаг дундын отрын бэлчээрт өвөлжих малын тоо, малчдын хүсэлтийг оторчин цахим системээр дамжуулаад энэ жилээс эхлээд авч эхэлсэн байгаа. Ингээд аймаг дундын отрын бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малд бас энэ жилийн тухайд нэмэлтээр өвс тэжээл бэлтгэж, хашаа саравчийг засварлах ажлууд хийгдсэн. Цаана нь аймаг хооронд, сум хооронд отроор өвөлжих 3 сая гаруй мал байгаа. Энийг бол зөвхөн аймгийн Засаг дарга нар, сумын Засаг дарга нар хоорондоо гэрээ байгуулах, отроор.../минут дуусав./

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Цахим систем хөгжүүлнэ, орж, гарч байгааг нь мал эмнэлгийн үндсэндээ хяналт доор хийнэ энэ тэр гээд байсан. Тэр ажлууд ямаршуу байж байгааг нэмээд бас харуулчхаарай. Гол суурь асуудал бол бид нар экспортоо нэмэгдүүлэх, түүнтэй холбогдолтой асуудал болно. Энэ чиглэлээр л ерөнхий нэлээн олон асуудлыг бид бүхэн яриад байгаа. Тодруулаад Болорчулуун дарга нөгөө хамгаалагдсан аж ахуйтай холбогдолтой, хамгаалагдсан аж ахуйгаас бид нар экспорт хийх асуудал ер нь хэзээ яах вэ? Үүнтэй холбогдолтой асуудлыг яаж

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдэх вэ? Төрийн нарийн маань хариулах уу? Амьд малын худалдааны энэ гарцуудыг Баруун болон Зүүн бүсүүд дээр ер нь нээх энэ чиглэлээр ажиллавал яасан юм бэ? Тодорхой энэ ажлуудыг бас удаа дараа бас илэрхийлээд ингээд бас ажиллаж байна.

Бид нарын ажиллаж байгаа 37 орон тодорхой протоколын тухай хэлж байна. Тэгэхдээ асуудал бас нэлээн удаан байна. БНХАУ-тай хийж байгаа үндсэндээ хэлцэл бол хугацаанаасаа хэдэн жилийн дараа хийгдлээ. Ярьж ярьж зөвхөн адууны дайвар бүтээгдэхүүн дээр ингээд.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотой мал аж ахуйн салбар тогтвортой эдийн засгийн эргэлтэд оруулах ийм шаардлага бидэнд байгаа. Тийм учраас энэ хагас эрчимжсэн, эрчимжсэн хагас суурин маллагаатай мал аж ахуй, тэр дундаа энэ тусгаарлагдсан аж ахуйгаас бид нар экспорт хийх бодлогыг эрчимтэй хийж ажиллана. Тусгаарлагдсан аж ахуй байгуулах баруун, зүүн бүсээрээ амьд мал гаргах асуудал өөрөө бас яг импортлогч орны шаардлагаар бий болж байгаа юм. Өнөөдөр бид нарын амьдаар гаргаж байгаа БНХАУ руу гаргаж байгаа хэлбэр бол Замын-Үүдэд байгаа бүсээр л гаргаж байгаа шүү дээ. Замын-Үүдийн бүсийг Хятадын гааль хорио цээрийн байгууллага дээр Дорноговь аймгийг эрүүл бүс гээд зарлачихсан. Тэгэхээр бид нар зүүн бүсээ эрүүл бүс, баруун бүсээ эрүүл бүс гэж зарлуулж байж эндээсээ БНХАУ, бусад улсууд руу. Узбекийн амьдаар гарч байгаа асуудал бол 2 орны тэргүүн тэргүүний.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ярьж зогссон асуудлын хүрээнд аль аль талдаа бас нэлээдгүй тийм хөнгөвчлөлттэй нөхцөлөөр явж байгаа. Тэгээд бусад бид нар жилийн 4 улиралд мал аж ахуйгаа эдийн засгийн эргэлтэд оруулах, бусад экспортын баримжаатай улсууд руу экспорт хийхийн тулд ялт ч үгүй энэ тусгаарлагдсан аж ахуй, хорио цээрийн бүс бүхий байгууламжуудыг байгуулах чиглэлээр ажиллах шаардлага байгаа. Энэ чиглэлээр хувийн хэвшлийн санаачилга дээр тулгуурлаад явж байгаа. Тодорхой аймаг, бүс, сумууд дээр хорио цээрийн тусгаарлагдсан аж ахуй, тусгаарлагдсан аж ахуй байгуулах чиглэлээр аж ахуйн нэгжүүд газраа аваад энэ Хүнсний хөтөлбөр, Атарын IV аяны хүрээнд хөнгөлөлттэй зээлээ аваад ингээд аваад ингээд явж байгаа.

Түрүүн тэр отрын отор нүүдэлтэй холбоотой асуудал ярьсан. Мал эмнэлгийн нэгдсэн систем болон Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаан дээр хөтөлж явуулж байгаа otorchin.mn гээд цахим хуудаснуудаар захиалгыг аваад холбогдох гэрээ хэлцлүүдийг хийгээд ингээд явж байгаа. Дээр нь отор нүүдлээр яваа айл өрхийн судалгаа, тэр нийгмийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, цэг, байршлуудыг нь нарийвчилсан тооцоо судалгаануудыг.../минут дуусав./

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Нийслэлийн удирдлагуудаас ирсэн энэ өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх танилцуулгыг үзэж харлаа. Амартүвшин дарга бид нарт ирсэн,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооны гишүүдэд ирсэн материалыг бараг бүгдийг нь ингээд ярьчихлаа л даа. Тэгж бас цаг авах хэрэггүй байсан юм. Үүнийхээ оронд юу ярих ёстой байсан бэ гэхээр өнөөдрийн хамгийн тулгамдсан асуудал энэ шахмал түлш болон энэ мидлингийн түлш, 2 янзын түлшний өнөөдрийн энэ хор урхаг, ард иргэдээс ирж байгаа, иргэдээс ирж байгаа энэ санал, гомдол яг юун дээр чиглэгдээд байна? Энийг цаашид яах юм, ямар гарц шийдэл байна? Энэ зөөвөрлөлт, шахмал түлшний зөөвөрлөлт, тээвэрлэлт, түгээлт, борлуулалтын асуудал, энэ гэр хорооллын цэгүүдийн асуудал, очоод үзэхээр зарим цэг нь ажиллахгүй байгаа, түлш хомсдолтой байгаа, хүртээмж аягүй муу байгаа, шахмал түлшний чанар асар муу байгаа. Өмхий үнэртэй тэгээд хий уугьдаг. Ерөөсөө утаа үйлдвэрлэж байна уу гэхээс биш дулаан үйлдвэрлэж байгаа юм байхгүй гэдэг энэ иргэдийн олон олон иргэдийн гомдлыг нийслэлийн удирдлагууд хэрхэн авч үзэж, тэн дээр ямар шийдэл гаргаж байгаа вэ, ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асуучихъя. Яг ийм байдлаар явах юм бол энэ гэр хорооллын 204670 өрх энэ 715 мянган иргэдийн өвөлжилтийн асуудал яаж шийдэгдэх юм, яаж энэ өвлийг давах юм? Энэ дээр та ер нь хариулт өгөөч гэж хэлмээр байна.

Энэ сая хавар бүгдээрээ энэ 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлын 53 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн. Нөгөө утааны асуудлаарх. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл ийм сэдэвтэй том хэлэлцүүлэг явагдсан. Сонсгол явагдсан. Тэгэхээр энэ хэлэлцүүлгээс гарсан Засгийн газарт өгсөн үүрэг, чиглэлийн тогтоолын хэрэгжилт ямар байгаа юм? Та яг одоо хэд хэдэн Засгийн газарт яг ямар үүрэг чиглэл өгсөн энийг бүүр ингээд дурдаадах даа 1, 2, 3, 4 гээд.

Б.Бейсен: Нийслэл 6 номер Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Түлшний хор уршиг гээд асуудал яригдаж байгаа. Бид нар бол шинээр хагас кокс шахмал түлшийг бол өнгөрсөн жилээс хойш бол ингээд туршаад лабораториудад өгөөд туршилт явуулаад тэгээд дээрээс нь ШУА, ТИС-ийнхнийг энд мөн энэ дээжүүдийг өгч туршилтуудыг явуулж үзсэн байгаа. Үүний дүн дээр бол мөн Монголын Стандарт хэмжил зүйн газар дээр хүртэл бол энэ асуудлууд яагаад энэ тохирлын гэрчилгээгээ бид нар бол энэ зун бол авсан байгаа. Тэгээд тохирлын гэрчилгээнийхээ хүрээнд энэ стандартыг бол хангуулаад хагас кокс болон шахмал түлшийг бол энэ жилээс бол тохирлын гэрчилгээтэйгээр гэрчилгээний хүрээнд бүх лабораторийн шинжилгээг нь хийлгүүлээд хийж байгаа. Лабораторийн шинжилгээнүүдийг импортоор орж ирж байгаа нүүрс дээр бол хил дээр хийж байгаа, орж ирж энэ лаборатори хийж байгаа. Хятадын тал дээр ч гэсэн л шинжилгээг хийгээд ингэснээр бол энэ нүүрс бол орж ирж иргэд, олон нийт дээр бол түгээгдэж байгаа.

Тээвэрлэлт, борлуулалтын хувьд 3-н долоо хоногийн өмнө бол “Тавантолгой түлш” буюу Налайхаас борлуулалтын цэг, “Тавантолгой түлш”-ийн агуулахаас агуулах руу хүргэж явдаг нийтдээ тендерээс шалгасан. 26 компаниас 2 компани нь бол 20 хувьдаа хүрэхгүй гүйцэтгэлтэй байсан. Үүнтэй холбогдуулаад дээрх 2 компанитай арга хэмжээ аваад Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газраас 16 тээврийн автомашиныг бол гаргаж тээвэрлэлтийг хийгээд явж байгаа. Одоо тээвэрлэлт бол жигдрээд явсан байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Зарим цэгүүд дээр бол түлшгүй байгаа асуудал дээр сүүлийн долоо хоногт бол нийслэлийн зүгээс бол ажиллалаа. Би өөрийн биеэр ч гэсэн ажилласан байгаа. Энэ дээр ямар асуудал гарч байна гэх юм бол нэлээн хэдэн хүчин зүйлтэй холбоотой байгаа. Нэг нь бол тээвэрлэлт байгаа. Нөгөөдөх нь бид нар 172 мянган өрх гал түлж байгаа өрх байгаа. 172 мянган өрх байгаа мөртөө бид нар “Хотула” системийг ашиглалтад оруулаад “сайн карт” дээрээс нь Улсын бүртгэл, E-Mongolia, ХАӨМС-ныг ингээд нэгтгэснээр нүүрс авч хэрэглэж байгаа 282 мянга гаруй карттай иргэн гараад ирсэн. 172 мянган өрх байгаа мөртөө 282 гараад ирсэн. Тэгээд үүн дээрээс нь ингээд бид нар хяналт хийгээд бүх системээр шүүлт хийгээд явахад нийтдээ 7200 гаруй сүүлийн 3-5 жилд нас сурсан иргэд хүртэл өнөөдрийг хүртэл картыг нь ашиглаж байгаа тийм зөрчлүүд гарсан. Түр оршин суугчид гэдэг нэрийдлээр карт авсан мөртөө тухайн хаяг дээрээ амьдардаггүй, байшин хороолол руу нүүж шилжсэн, дээрээс нь хөдөө орон нутаг руу нүүж ирсэн эдгээр асуудлуудыг бол шийдвэрлээд явж байгаа.

Эдгээр асуудалтай шийдвэртэй холбоотой иргэдээс бол бас гомдол, санал ирж байгаа. Улсын бүртгэл бүртгэлтэй, ХАӨМС дээр бүртгэлтэй байгаа иргэд дээр бол ямарваа нэгэн асуудал байхгүй. Орон нутагт бүртгэлтэй нийслэл рүү шилжиж ирээгүй ХАӨМС.../минут дуусав./

Б.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя 6 номер. 6 номер.

А.Амартүвшин: Эдгээр айл өрхүүд зөвхөн хорооноосоо очоод тодорхойлолтоо аваад тэгээд нөгөө сайн карт юм уу, “Хотула” систем дээр юм уу, иргэний үнэмлэхийнхээ QR кодыг бол уншуулаад авч явж болж байгаа.

Бодлого, шийдвэрийн хувьд бол Үндэсний хороон дээрээ бол бид нар бодлого, шийдвэрээ гаргаад дундын болон алсын бодлогоо хийгээд явна. Ойрын бодлого гэх юм бол мэдээж энэ хагас коксыг нэвтрүүлээд явж байгаа. Энийг ирэх 2 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа. Энийг зөвхөн газ руу шилжиж байх хугацаанд эдгээр бол хэрэглэж явна. Энэ бол энэ жил бид нар 5 мянган айл өрхийг бол дулаалаад газ руу шилжүүлнэ. Дараа жил бид нар 50 мянган айлыг бол шилжүүлэхээр судалгаагаа хийгээд дараа жилийн нийслэлийн төсөв дээр батлах бэлэн байдлаа бол хангасан байгаа. Тэрний дараа жил бид нар 65 мянган айлыг шилжүүлнэ. Энэ шилжилтийн явцад бид нар бол энэ нүүрсийг бол хэрэглэхээр явж байгаа. Энэ нүүрсний хэрэгслээр 45-50 хувиар бол нийс.../минут дуусав./

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Амартүвшин дарга яг тодорхой миний асуусан асуулт, сонирхсон асуултад та яг гүйцэд бас сайн хариулж чадсангүй. Хамгийн сүүлийн Засгийн газрын саяын хаврын хэлэлцүүлгийн, утааны тухай хэлэлцүүлгийн Засгийн газарт өгсөн үүрэг, чиглэл, тогтоолыг та энийг би яг ингээд бүгд дурд гэсэн тээ 1, 2, 3, 4, 5 ч гэдэг юм уу тэгээд дурдаах даа. Тэгээд яг энэ тогтоолын хэрэгжилт дээр өнөөдөр нийслэлийн удирдлагууд хэрхэн, ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ тэр талаараа тодруулъя даа.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Мөнхбаатар: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар байна. Улсын Их Хурлын 53 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас манай дээр асуулга ирүүлсэн. Түүний биелэлтийг хүргүүлээд явсан байгаа. Яг энийг тодорхой дурдах юм бол төсвийн мөнгөөр хагас кокс авах нь өөрөө хуульд нийцэж байна уу гэдэг байдлаар асуудал тавигдсан байдаг. Энд “Тавантолгой түлш” компани жил болгон “Эрдэнэс Тавантолгой” компаниас татаас авч, 300 тэрбум төгрөгийн татаас авч шахмал түлшийг үйлдвэрлэдэг. Тэгээд яг энэ мөнгөөрөө ахиад нийслэлд, нийслэл улсын төсвөөс 1 ч төгрөгийн ахиж нэмэгдэл гаргахгүйгээр тухайн төсөвтөө тааруулан хагас коксыг худалдаж авч байгаа учраас энийг улс, нийслэлийн төсөв гэж бид нар үзэхгүй байгаа.

Дээрээс нь 53 дугаар тогтоол дээр Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуул гэдэг ийм чиглэл гарсан байсан. Энэ чиглэлийн дагуу Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороог бол Ерөнхий сайд ахлаад явж байгаа гэж хэлж болно. Дээрээс нь өмнөх асуулт руу эргээд ороход ер нь хагас коксыг бид нар 10 дугаар сарын байдлаар туршиж үзсэн. Агаарын чанар дээр шинжилгээ хийсэн. Энэ шинжилгээ хийхэд хүний биед хамгийн хортой гэж ярьдаг СО маань өнгөрсөн жил 1177 микрограмм метр куб байсан бол энэ жил 1053 микрограмм метр куб болж багассан байгаа. НОКС (NO_x), SO₂, PM 10, PM 2.5 эд нар бол өнгөрсөн жилүүдтэйгээ эд нар харьцуулах юм бол 10-15 хувиар буурсан гэсэн ийм судалгаа манай агаарын чанарын суурин 19 харуул дээр гарч ирсэн байгаа. Аиад 53 дугаар тогтоол үндсэн агуулга нь ерөөсөө яг энэ хагас коксыг төрийн болон орон нутгийн өмчөөр авах нь өөрөө хуульд нийцэж байгаа юу л гэдэг ийм асуудал байсан. Тэгэхээр энэ дээр би өөрөө хариулсан гэж үзэж байна.

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Та бас хариулж амжсангүй. Тэгэхээр та энэ хаврын тэр 5 сарын хэдэнд хийсэн Их Хурлын гишүүдээр бүрдүүлж юу яасан шүү дээ. Тэр том хэлэлцүүлэг хийчхээд байхад өнөөдөр Засгийн газраас Засгийн газарт хүргэсэн тэр тогтоолын шийдвэрүүдийг та өнөөдөр мэдэхгүй байна л даа. Энийг уншина та дахиж энэ дээр бүүр ажиллах ёстой байна. Яагаад гэвэл ердөөсөө шал өөр юм яриад явчихлаа л даа. Жишээ нь энд ингэж байгаа шүү дээ гэр болон барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах стандарт боловсруулан батлуулна гэсэн байгаа юм. Энэ стандартыг боловсруулсан уу? Ингээд л 1 шийдвэр нь байхгүй юу яг ийм чиглэл өгсөн шүү дээ. Тэгэхээр та энийг сайн дахиад судлаад эргээгээд та дахиад дараа уулзалт дээр хариулсан нь дээр байх аа.

Б.Бейсен: Тэр 53 дугаар тогтоолын биелэлтийг бас бид чуулган дээр Их Хурал дээр сонсох ёстой. Саяын асуултад хариулаарай. Хэдэн номер? Үг хэлсэн байна. Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Түрүүн 1 тонн түлшний нийт өртөг нь 1.1 сая төгрөг болж байна гэж сонссон. Нийлбэр дүнгээрээ. Энийг та бүхэнд бэлэн байгаа байлгүй дээ. Эрээн дээр тэдэн төгрөг, Улаанбаатар руу тээвэрлэж ирэх зардал нь тэдэн төгрөг, үйлдвэр дээр савлагаа тэдэн төгрөг, түгээлт тэдэн төгрөг, борлуулалтын зардал тэдэн төгрөг гээд хэлж өгнө үү? “Хотула” аппликэйшн болон угаарын хийн сенсор тавиад нийтэд нь хянадаг систем байгаа. Тэр системүүд ямар хөрөнгө оруулалтаар хэдэн төгрөгийн дүнтэй хийгдсэн бол?

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2 дахь асуулт Шаньси мужийн Шинму сумын компанитай гэрээ байгуулсан гэсэн. Хэдэн үйлдвэрээс энэ түлш нийлүүлэгдэж байгаа вэ? Нэг дор үйлдвэрлэгдэж байна уу? 3, 4 газар байна уу 5, 10 газар байна уу? Энэ түлшний өөрийнх нь шинж чанар нь өөрчлөлттэй холбоотой асуулт байна. Хэдэн үйлдвэрээс нэгдэгдэж байна? Цаг байна уу 1 асуулт байна аа. Нийтийн байрнууд гээд байдаг гэр хороололд нийтийн түрээсийн байр ажиллуулж байгаа хүмүүс, орон сууцын асуудал шийдэж байгаа чадлынхаа хэрээр тэгээд хүмүүс түрээслээд суулгадаг, түлш авч чаддаггүй, нэг байран дотор нь ингээд л 10 айл 10 өрх ч юм уу, 20 ч юм уу ингээд амьдардаг. Тэгээд түлшээ болохоор нөгөө картаа орон сууцад амьдардаг ээжийнхээ нэр дээр 1, нөгөө юунд амьдардаг ахынхаа нэр дээр 1 гээд ингээд тэгж шингээж авч хангадаг юм байна лээ. Тэгээд энэ айлуудыг яах вэ? Нийтийн энэ байр түрээсэлж байгаа хүмүүс чинь бас уул нь утаа бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа хүмүүс. Энэ асуултыг асуучихъя.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

А.Амартүвшин: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Юунаас нь эхлээд явчихъя түрээсийн байран дээр бол тийм байгаа. Нийтийн байр, түрээсний байр 1 хашаандаа ч юм уу 2 хашааг нийлүүлсэн дээр 5-10 өрх амьдардаг. Эдгээр айлууд дээр бол аж ахуйгаар нь тооцоод, аж ахуйгаар нь тооцоод бид нар мидлингийг хангах зохицуулалтыг хийгээд хэрэгжүүлээд явж байгаа. Энэ нь бол бид нар хороон дээрээ хүсэлтээ гаргаад л шууд “Хотула” аппликэйшн дээр бол аж ахуйн нэгжээр тооцож оруулаад тэгээд нүүрснийхээ олголтыг бол аваад явна. Ямар нэгэн асуудал байхгүй ээ.

“Хотула” аппликэйшн бол “Тавантолгой түлш”-ийн зардлаар бид нар 400 сая төгрөгийн зардал гэсэн байгаа. Энэ чинь ганцхан энэ нүүрс гэдэг биш. Хотула аппликэйшн бол нийтдээ өөрөө Улаанбаатар хотын иргэдийн ашиглалтын ийм аппликэйшн болж байгаа. “Civil take” гэж ярьдаг “payment take” энэ “Хотула” аппликэйшн ганцхан нүүрс зориулалттай нүүрстэй ашиглалтын зориулалттай биш энэ бол зөвхөн аппликэйшнийх нь 5 хүрэхгүй хувь нь л байгаа. Цаашаа энэ нийгмийн сүлжээнийх, төлбөр тооцооных тэгээд ухаалаг иргэн, ногоон иргэн, ногоон онооны систем гээд энэ цогц системээр бол явагдаж байх ийм “Хотула” аппликэйшн байгаа. “Хотула” аппликэйшныг та бол app store-оос бол хуулж аваад тэгээд сонирхож ашиглаж болно. Бета бол ашиглалтад бол гараад эхэлчихсэн байгаа. Энэ дээр хамгийн гол “Хотула” аппликэйшн цаад утга нь бол нүүрс борлуулалт гэж хэдүүлээ харж болохгүй. Энэ нь бол цаад зөв ногоон иргэн гэдэг зүйлийг бол бий болгочихсон оноо өгдөг ийм аппликэйшн явж байгаа.

Жишээлбэл алхах юм бол 10 оноо авна, автобус хэрэглэх юм бол 5 оноо авна, тэгээд сүүтер, мопед хэрэглэх юм бол тэдэн авна гээд. Дараа нь энэ цуглуулсан оноогоороо тогныхоо зардал, юуныхаа зардал дээр ингэж ашиглаж болох ийм зүйл байгаа шүү. Тэгээд ганцхан “Хотула” аппликэйшныг нүүрсний аппликэйшн гэж бас харж болохгүй байх аа.

Угаар мэдрэгч нийслэлийн төсвөөс авагдаад худалдан авалт хийгдээд явж байгаа. Нийтдээ 122 мянган айлыг ухаалаг угаар мэдрэгчтэй холбосон. Одоо дахиад төсвийн тодотголоор 2 сарын өмнө ороод 6.5 тэрбум төгрөгөөр дахиад 45 мянган угаар мэдрэгчийг авахаар явж байгаа. Одоо гэрээ байгуулах шатдаа бол явж байна. Нүүрсний задаргааны юуг та хариулчих уу.

Б.Бейсен: 5 номергүй цээж хариулъя.

Х.Ариунзаяа: Золжаргал гишүүний асуултад хариулъя. “Тавантолгой түлш” Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсээс Ариунзаяа байна. Шинму хотоос БНХАУ-ын Эрээн өртөө хүртэл 738500 төгрөг байгаа. Өөрөөр хэлбэл гадаа тээвэртэй үнэ. Үүнээс Эрээн өртөөнөөс Баян өртөө, Баян өртөөнөөс түлшний үйлдвэр хүртэл ойролцоогоор 90 орчим мянган төгрөгөөр 1 тонн хагас коксожсон шахмал түлшний дотоод тээвэрлэлтийг хийж байгаа. Үүн дээр нэмэгдэх нь компанийн савлагаа, буулгалт, савлалт, шуудайны өртөг оруулаад тооцох юм бол 141700. Үүн дээр нэмэгдэх нь удирдлага болон борлуулалтын зардал, хуваарилагдах зардлууд нэмэгдэж байгаа. Мөн борлуулалтын зардал нэмэгдээд нийтдээ сая 100 орчим болж байгаа.

Б.Бейсен: Золжаргал гишүүн тодруулъя .

Ж.Золжаргал: Санал хэлье. Бид нар ингээд үхрийн махтай бууз идмээр хүн байна. Тэгсэн чинь та байцайтай бууз ид, эсвэл төмстэй бууз ид, эсвэл ямааны махтай бууз ид гээд ингээд сонголт тавиад байгаа юм. Уг нь бол гоё нүүрснүүд байдаг. Байгалийн утаа багатай антрацит байна, модон шахмал байна, янз бүрийн түлшнүүд байж болно. Тэгээд ерөөсөө та үхрийн махтай бууз идэж болохгүй би танд жоохон давс ихтэй ийм байцайтай л юм өгье гээд нь тийм дүлий, нөгөөх нь тийм үйрмэг, нэг нь тог хийдэг чулуу шиг иймэрхүү хүчээр ингэж юмыг хийх асуудал бол ер нь бодлогын хувьд байж болохгүй ээ. Энийг өөрчлөх хэрэгтэй. Тэгээд л аппликэйшн, их өндөр тээг яриад байдаг.

Б.Бейсен: 6 номер хариулъя Амартүвшин дарга.

А.Амартүвшин: Золжаргал гишүүн дээр асуултад хариулъя. Энэ дээр агаарын бохирдолд үзүүлж байгаа чанараас нь л авч байгаа гол асуудал л даа. Бид нар нөгөө ШУА-тай хамтраад, ШУА дээр бүх судалгааг нь гаргаад, ШУА-ийн гаргасан дүгнэлт, дээрээс нь тэд нарын зөвлөмжийн дагуу энэ ажлуудыг зохион байгуулаад явж байгаа. Мөн Үндэсний хороон дээр танилцуулаад ажлууд Үндэсний хорооноос шийдвэрүүд нь гараад хэрэгжилтийг бол нийслэл хариуцаад явж байгаа. Тэрийг та сайн мэдэж байгаа.

Хамгийн гол нь хэдүүлээ энэ зүйлийг л анхаарах ёстой. Хүхрийн хий гэхэд бол Тавантолгой шахмал түлшнээс гарч байгаа утаанаас 89.2 хувиар хүхрийн хий бага ялгаруулж байгаа. Азотын исэл нь 72 хувиар бага, угаарын хий нь 24.5 хийгээр бага, нийт тоосонцор буюу нөгөө уушгинд шүүгддэггүй тоосонцор нь 68.15 хувиар бага. Цаад зорилго нь.../минут дуусав./

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Өглөөний амар амгаланг айлтгая. Тэгээд өвөлжилт гээд ярихаар ялт ч үгүй бид нар нэг талдаа нөгөө утаа, түгжрэл гээд маш олон ийм асуудлын цуврал яригддаг мэдэж байгаа. Нөгөө талдаа энэ нь өөрөө манай Улаанбаатар хотын Монгол Улсын иргэдийн амь амьжиргаа, хүний эрхийн асуудал яригддаг гэсэн үг. Маш том чухал сэдэв гэдгийг би хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ олон сэдэв хөндөж болно ч гэсэн нэгд хамгийн гол халуун сэдэв нөгөө нүүрсээ л ярья гэж бодож байна. Олон инженерүүдийг сонссон, гэр

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хорооллын иргэдийг бас сонсож байна. Тэгээд энэ өмнөх гишүүд ч гэсэн асууж байна. Амартүвшин болон бусад маань хангалттай сайн баталгаатай хариулт өгч чадахгүй байна. Тийм ч учраас нотлогдохгүй байгаа учраас иргэд бухимдалтай хэвээр байгаад байна. Бид иргэдийг төлөөлж сууж байгаагийн хувьд асуухаас өөр аргагүй, зөв шийдлийг хүлээхээс өөр арга, нэхэхээс өөр аргагүй гэсэн үг.

Угаар үүсгэж байна. Угааргүй гэдгийг баталж чадахгүй байна. Энэ нь өөрийгөө цаанаа хүний амь насны асуудал шүү дээ. Дахиад хүүхэд, өрх гэр бүл хүн бурхан болчихлоо гэдэг юм сонсоод сууж байх вий гэдэг айдас байна аа.

2 дугаарт эрчим хүчний нэмэлт зарцуулалт яригдаж байна шүү дээ. Эрчим хүч. Нөгөө эрчим хүчээр дутагдаад байна, эрчим хүчээр хангаж чадахгүй байна, төсөв, мөнгө хүрэлцэхгүй байна гээд байсан. Энэ эдийн засгийн хохиролтой байна.

3 дугаарт нь мэдээж түрүүн хүмүүс бас яриад байна шуудай тутмаас 20 мянган төгрөгийн алдагдалтай гэдэг чинь одоо ямар ч 10-н жилийн хүүхэд ч гэсэн үгүй би ингэж хохирмооргүй байна гээд сууж байх ёстой биз дээ. Тэгэхээр дахиад эдийн засгийн асуудал.

4 дүгээрт нь чанарын асуудал яригдаж байна. Сайжруулсан түлш гэхээр хүн чинь ямар ч инженер биш, эсвэл энэ уул уурхайн салбарын бус нүүрстэй зууралдаагүй хүн хүртэл сайжруулсан түлш гэхээр сайжирсан юм байна гээд, илчлэг нь сайжирсан юм байна гээд ойлгоно шүү дээ. Гэтэл тэр нь харагдахгүй илчлэг харин ч хуучин “Эрдэнэс Тавантолгой” нүүрстэйгээ харьцуулахад тийм давуу талтай шууд харагдахгүй байна энэ ерөөсөө батлагдахгүй байна гээд хэлээд байна. Энэ дээр л тодорхой сайн яриадхаач. Өмнөх гишүүдийн хэлж байгаачлан иргэдэд аягүй хүндрэл үүсгээд байна. Одоо энэ сошиалаар ч гэсэн бичээд байна лээ шүү дээ. Бид нар зах зээлийн нээлттэй зах зээлийн чөлөөт эдийн засгийн нийгэмд амьдарч байгаа. Гэтэл очер үүсгээд, хар өвлийн хүйтнээр очер үүсгээд улам дааруулаад байх вий дээ иргэд ээ. Гэртээ ч, гадаа ч. Тэгэхээр яг хамаатан садан байна уу Амартүвшин, бусдад нь гэр хороололд очиж асууж сураглаж байна уу? Яг дотно ажлаа хийсэн болоод хамгаалах зорилгоор биш яг дотно ажлаа хийсэн болоод хамгаалах зорилгоор биш яг чин сэтгэлээсээ хүн гэдэг утгаараа сайхан хариулаач хөө.

Б.Бейсен: 6 номер Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ энэ дээр манайхан нийслэлийнхэн бүх баг бүрэлдэхүүнээр бол гараад ажиллаж байгаа. Тодорхой хэмжээний хүндрэл бол гарч байгаа. Энийг иргэд дээрээ очиж уулзаад учир шалтгааныг нь тайлбарлаад уучлалтуудыг хүсээд явж байгаа. Тэгэхдээ түрүүн хэлчихсэн бид нар 172 мянган өрхтэй байж байж сайн түлшээрээ 182 мянга гаруй айл авч байна. 100 мянга гаруй илүү картаар. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол өнгөрсөн жилүүдтэй харьцуулаад үзэхэд иргэд дээрээ очихгүйгээр 100 мянган тонн сайжруулсан түлш юу гэдэг юм ёс бус аргаар ч юм уу, хууль бус аргаар орон нутаг руу болон энэ уурын зуухууд руу, нам даралтын зуухууд руу дамлагдаж зараад байгаа. Энэ дээр нь бол бид нар цэгцлэхийн тулд энэ “Хотула” нүүрсний аппликэйшнийг бол ингээд салгаж оруулж ирж байгаа асуудал юм. Энийг бид нар зун бүртгэлийг нь хийгээд явсан.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхдээ зун нүүрс хэрэглэхгүй хүмүүс амарч ингээд явчихдаг болохоор идэвх муутай байсан. 9 сарын 15-наас хойш бол ингээд идэвх сайжраад ингээд явсан. Энэ дээр бол зарим улсын бүртгэлд бүртгэлтэй, ХАӨМС дээрээ бүртгэлтэй иргэд дээр ямар ч асуудал байхгүй байгаа. Яг нөгөө түр оршин суугч ХАӨМС дээр бүртгэлгүй улсын бүртгэл дээрээ, хөдөө орон нутаг дээр ч юм уу, эсвэл нөгөө байшин хороолол руу нүүчихсэн айлын ийм бүртгэл дээр амьдардаг. Энэ дээр нь бол бүртгэлийн асуудлууд явж байгаа. Тийм болохоор энэ дээр яг бид нар ХАӨМС Улсын бүртгэл, “Тавантолгой түлш” ингээд хамтаар энэ бүртгэлийн асуудлыг цэгцлээд явж байгаа юм.

Угаарын асуудал дээр яах ч аргагүй таны зөв өө. Энэ нөгөө юу ч түлсэн угаар гарна аа. Мод түлсэн, цаас түлсэн ч. Харин бид нар бол хамгийн бага угаар гаргагч бол, хамгийн бага эрсдэлтэй энэ хагас коксыг бол ингээд Монгол Улсад үйлдвэрлэдэггүй ч гэсэн ингээд хилээр оруулж ирээд, импортоор оруулж ирээд түлж байгаа. Угаарын хий нь энэ чинь 24.5-аар хувиар бол бага ялгаруулж байгаа нөгөө сайжруулсан түлшээ бодвол. Тэгэхдээ бид нар иргэддээ яг одоогийн байдлаар бол ингээд сонголтоор түлшүүдийг хэрэглүүлж байгаа. Яагаад гэвэл яг таны хэлснээр иргэдээс ингээд маш их хүсэлт ирж байгаа. Түүхий нүүрсээ хэрэглэмээр байна, сайжруулсан түлш нь дээр юм байна, хагас кокс нь дээр юм байна, хагас кокс нь муу юм байна, сайжруулсан нүүрс нь ийм гээд маш их хүсэлт ирж байгаа. Тийм болохоор энэ иргэдэд өөрсдөө дүгнэлтээ хий гэж энэ 3 төрлийн түлшийг гурвууланг нь зэрэг борлуулалтад гаргаад явж байгаа.

12 сарын эхээр бид нар бүрэн хагас коксны түлшнүүд бол хэрэглээд эхэлнэ. Ингэснээр бид нар өнгөрсөн оны 12 сарын дундуур агаарын бохирдол ямар байсан, энэ оных дээр ямар байна гэдэг бол хийгээд хийгээд явна. Иргэд, олон нийтдээ ч гэсэн танилцуулаад явна. Энэ асуудал дээр бол НҮБ, Хүүхдийн сан, Дэлхийн банк яг энэ дээр хамтарч явж байгаа. Тэд нараас бас бид нарт ингээд заавар, зөвлөгөө өгөөд явж байгаа. Тэд нарын дагуу бол явж байгаа.

Эрчим хүчний асуудал гэвэл таны зөв өө. Бид нар бол эрчим хүч нь хангалттай байсан бол бүх айлуудыг бол heat pump гээд байгаа тээ.../минут дуусав./

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Энэ яг энэ ганц удаагийн асуулт асуугаад, хариулаад явчихаар зүйл биш юм байна лээ. Ялт ч үгүй энэ өөрсдөө ч анзаарч байгаа маш их асуултууд байна. Сая товчхон хариулт авлаа. Хангалттай 100 хувь гэж үзэхгүй байна. Тэгээд цаашдаа анхаарах хэрэгтэй. Энэ иргэдийн гомдол, санал, инженерүүдийн хэлээд, анхааруулаад байгаа юмнуудыг сайн сонсох хэрэгтэй гэж бодож байна. Нэгэнт ингээд гэрээ хийчихсэн, явчихсан юм чинь өнгөрсөн үүгээрээ дүргүй бух шиг ингээд явна гэдэг бол үнэхээрийн буруу хохирол ихтэй байж болохгүй ээ.

Нөгөө талдаа би энэ Хөдөө аж ахуйн яам ч тэр, нийслэлийнх ч тэр энэ танилцуулга дээрээ бас анхаараасай гэж бодож байна. Түрүүн Батчимэг бас гишүүн хэлсэн. Маш цэгцтэй өвөлжилтийн үеэр тулгамддаг олон гол цогц асуудлууд байгаа шүү дээ. Тэр дээр яг замбараатай нөхцөл байдал benchmark ийм байна өнөөдрөөр ноднин өвөл. Одоо яг энийг ингэж ахиулсан хэмжээгээр өвөлжилт маш сайн байдлаар давж гарах гээд байгаа юм аа учир нь гээд яривал

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бас их зүгээр байна шүү. Тэгэхгүй ингээд аймаар замбараагүй ийм цогц цэгцтэй.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Д.Мөнхбаатар: Асуултад нэмэлтээр хариулъя. Хагас коксын үндсэн чанар. Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар. Хагас коксын үндсэн шинж чанар нь гишүүн ийм байгаа юм Улаанбаатар хот бид нар агаарын бохирдлоосоо нэн яаралтай хугацаанд салах хэрэгтэй шаардлага үүссэн. Улаанбаатар хотод яг энэ өвлийн байдлаар сая 700 мянгаас 2 сая иргэн оршин сууж байна. Бид нар агаарын бохирдолд энэ утаа гэж харагдаад байгаа зүйл маань өөрөө нарийн ширхэглэгт тоосонцор, азот, нокс, сокс гээд хүхрийн давхар исэл ингээд ийм зүйлүүдээс агаарын бохирдол маань үүсээд байгаа юм. Бид нар энэ жил хагас коксыг нэвтрүүлснээрээ гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлыг 68 хувиар бууруулна гэдэг ийм тооцоо, судалгаа гаргасны үндсэн дээрээс хагас коксыг 12 сарын 1-нээс бид нар бүрэн шилжүүлнэ гэдэг ийм байдалтай явж байна. Энэний ар талд энэ 2 сая иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ нөхцөл бололцоог л бид нар бүрдүүлэхийн төлөө л ажиллаад байгаа. Хагас коксын илчлэгийн асуудлыг ярьж байгаа. Хагас кокс маань өөрөө БНХАУ-д.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Би хэд хэдэн юм тодруулмаар байна. Хөдөө аж ахуй, Байгаль орчны яамнуудаас. Ер нь жил болгон ингээд өвөл дөхөөд ирэхээр манай байгалийн гамшиг, өвөлжилтийн бэлтгэл ажиллагаа, зуд гээд 35 жил ярьсан уу юу билээ бараг тэгсэн байх аа. Тэгээд энэний эсрэг авч байгаа хариу арга хэмжээ байна уу? Энийг цөлжилтийг яаж зогсоох вэ? Одоо дэлхий даяараа уур амьсгалын өөрчлөлт орсон байгаа ихэнх улс орнууд. Тэгэхдээ эсрэг зөндөө юм хийгээд өөрсдөө буулгаад байна шүү дээ. Жишээ нь бид нар Киргиз улсад очлоо, Тажикстанд очлоо. Тэр улс орнуудад ер нь зундаа ямар ч бороо ордоггүй юм байна. Тэгээд бас халуун нь 40- 50 юм байна. 50-аас ч илүү гардаг юм байна. Тэгээд намраас өмнө тэд нар 2 ч удаа ургац хураалт хийнэ гэнэ ээ. Малын тэжээлээ бэлдэнэ, өөрсдийн өвс ургамлаа тэр ургуулж бүгдийг нь. Бороо, хэзээ ч бороо харахгүй юм байна. Тэд нар бороонд 10, 9 сард орно гэнэ . Тэгээд бид ер нь яах ёстой юм бэ? Ингээд сууж байх ёстой юм уу? Нөгөө энэ жил бас цөлжилттэй байна, өвс ургамал гараагүй байна, байгалийн гамшиг, мал, мах яах вэ гээд л. Тийм учраас та нар тийм хийж байгаа ер нь судалгаа байна уу? Бид нар бороо орохгүй бол яах ёстой гэж 1 дүгээрт.

2 дугаарт би тэр улсуудаар явж байхад асуусан л даа. Та нарт ер нь бороо орохгүй ийм халуун байна тэгээд яаж өвс ургамлаа болгож байна гээд. Тэд нар усан сан бий болох юм байна, усны суваг татдаг юм байна, шлангийг ашиглаад газрыг чийгшүүлээд тэгээд өвс ургамал бүх юмаа хэвийн байдалд оруулаад тэгээд явдаг юм байна шүү дээ. Яг энэ тал дээр хийсэн судалгаа ер нь та хэдэд санаачилж байгаа юм байна уу? 1 дүгээрт.

2 дугаарт ингээд яах вэ Ерөнхийлөгчийн санаачилгаар Цагаан алт гээд яриад байна. Цагаан алт гэдэг нь би ноос юм болов уу гээд ноос, ноолууран юм болов уу гээд бодож байна. Арьс ширний тал дээр ер нь хийж байгаа юм байна

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

уу? Одоо арьс шир тэр чигээрээ хогонд хаяж байна шүү дээ. Энэ чинь маш үнэтэй юм шүү дээ.

2 дугаарт нийслэлийн юунаас юм асуумаар байна. Өвөл дөнгөж эхэлж байхад харамсалтай мэдээнүүд фэйсбүүкээр яваад байх юм. Энд хэдэн хүн гэр бүлээрээ ингээд угаартаж өнгөрлөө, энэ хорвоогоос саллаа гээд хэд хэдэн тийм мэдээ гарлаа. Энэ нь үнэн юм уу? Тэгээд тэр чинь ханахын түлш тэр хүмүүс түлж тэгээд угаартаж байна? Ер нь танайх харийн орнуудаас бас түлш аваад байгаа юм уу? Бид өөрсдөө нүүрс хангалттай байж байдаг. Тэрийг хямд экспортолно. Тэгээд гадаадаас үнэтэй юм уу худалдаж авч байгаа юм уу? Ер нь.../минут дуусав./

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Замира гишүүний асуултад хариулт өгье. Ер нь энэ байгаль, цаг уурын нөхцөл байдал дэлхий дээр явагдаж байгаа дулаарлын нөлөөлөл Монгол оронд бас хүчтэй сүүлийн жилүүдэд нөлөөлж байгаа. Тухайлах юм бол ган, зудын давтамжийн хэмжээ бол давтамжийн хугацаа их ойрхон болсон. Бид нар сүүлийн энэ 10 жилээр аваад үзэх юм бол 2015, 2017 онд ингээд 2 жил дараалсан ган болсон. 2022, 23-24 онд зудын нөхцөл байдал үүссэн гээд энэ олон асуудлууд байна. Тэгэхээр энэний эсрэг мэдээж газар тариалангийн салбарт аваад үзвэл технологиудыг өөрчлөх, шинэчлэх ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Манай тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж иргэд ер нь 6 дугаар сарыг бараг 1 өдөр ч бороогүйгээр төсөөлж тэрэнд таарсан технологиор тариалалтаа хийж байгаа.

Тариалалтын тухайлах юм бол тариалалтын хугацааг хойшлуулж байна. 6 сарыг бороогүйгээр тооцож, 7 сарын эхний долоо хоногт бороотойгоор тооцож тариалалтыг хийж байна. Энд нь таарсан техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлж байна. Энэ техник, тоног төхөөрөмжийг дагаад технологи нэвтэрч байгаа гээд ингээд дэлхийн жишиг дээр явж байгаа энэ технологиудыг бас боломжийн хэрээр, чадал чинээхнийх нь хэрээр Монгол Улсад нутагшуулах чиглэлд ажиллаж байна. Таны хэлээд байгаа тэр орнуудын цаг агаарын нөхцөл байдал тийм байдаг хэдий ч бас яг дулааны улирал байх хугацаа нь бид нараас арай бас өөр байдаг. Бид нар бас очиж үзэж байсан, судалж байсан.

Тэгэхээр таны хэлж байгаачлан тэр усалгаатай газар тариалан нэмэгдүүлэх, усжуулах, усан сан бий болгох гэдэг асуудал хамгийн талаар тавигдаж байгаа. Энэ дээр бол мэдээж төдийлөн улсын төсвөөс хөрөнгө оруулалтаар бүгдийг нь шийдэж чадахгүй ч гэсэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хэд хэдэн услалтын системүүдийг шинээр байгуулах ажлууд хийгдэж байна. Тэгээд энийг цаашлаад бид нар энэ усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх чиглэлд онцгой анхаарч ажиллаж байж бид нар энэ байгаль, цаг уурын нөхцөл, ган, зудын эрсдэлийг даван туулах ийм боломжийг бүрдүүлнэ гэж харж тооцоолж ажиллаж байна.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

А.Амартүвшин: Замира гишүүний асуултад хариулъя. 25-26 оны шилжих энэ өвлийн галлагааны улиралд харамсалтайгаар бол 9 иргэн бол нас барсан. Энийг бол шүүх шинжилгээний эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, цагдаагаас бол дүгнэлтүүдийг нь бол ингээд гаргахад ихэнхдээ бол нөгөө угаар мэдрэгчээ, тэр дундаа ухаалаг угаар мэдрэгчээ унтраасан, өрхөө бүтээсэн,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

яндангаа сугалж авсан, зуухных нь битүүмж нь алдагдсан эдгээр бол нөхцөл байдлууд газар дээр нь бол мэргэжлийн байгууллагуудаас шинжилгээний дүгнэлтүүд нь гараад явсан байгаа. Энэ оны сүүл гэхэд бид нар нийт гал түлж байгаа 172 мянган айл ухаалаг угаар мэдрэгчээр холбож дуусна. Ингэснээр бол ингээд бид нар бүх айл өрхүүдээ угаардалтын асуудлаас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг шууд 5 минутын дотор үйл ажиллагаагаа явуулах ийм бололцоо 100 хувь бүрдэнэ ээ.

Нүүрсний импортын асуудлаар.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: Нүүрсний импортын асуудлаар асуулаа. Хаанахын түлш гаднаас орж ирсэн түлшийг оруулж ирж байгаа юм бэ гээд. Одоо бид нар “Энержи Ресурс”-оос Эрдэнэс Тавантолгойгоор дамжуулаад үйлдвэрийн худалдаж авахад үйлдвэрийн өртөг барьцалдуулагч, цалин, тээвэр, технологи материалыг нийлээд 600 орчим гаруй төгрөгөөр бол болж байгаа.

Дээрээс нь бол үндсэн түүхий эдийн үнээ нэмээд зах зээлийн хамгийн хямд үнээр нь ингээд тооцоод бодоход 100 мянган төгрөг нийлэхэд сайжруулсан түлш маань бол 700 мянган төгрөгт гарч байгаа. Хагас кокс түлш маань 738 мянган төгрөгөөр худалдаж аваад тээврийн зардал нь ороод 1 сая гаран төгрөг болж байгаа. Тэгэхдээ нөгөө агаарт үзүүлэх сайн чанар нь болохоороо 45-50 хувийн бол агаарын бохирдлыг бол шууд шийдэж чадах ийм бол түлш байгаад байгаа юм. Энэ өөрөө ингээд бүрэн боловсруулсан, жигнэсэн ийм бүрэн боловсруулагдсан ингээд идэвх бүтээх.../минут дуусав.

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Тийм тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ Цагаан алт хөдөлгөөн энд бол үндсэн 3 салбар багтаж байгаа. Ноос, ноолуур, арьс шир. Тэгэхээр таны асууж байгаа арьс ширний салбар бол энэ Цагаан алт хөдөлгөөний хүрээнд хамрагдаад явж байгаа гэж ойлгож болно. Энэ хөдөлгөөн хэрэгжээд жилийн нүүр үзэх гэж байна. Энэ хугацаанд бид нар үйлдвэрлэгчтэйгээ, энэ ноосны, ноолуурын, арьс ширний холбооны, төрийн бус байгууллагуудтайгаа нягт хамтарч ажиллаж байна. Энэ хүрээнд бас хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрүүдийг эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүдийг гаргаж байна. Энэ салбарууд дээр тодорхой хэмжээний боловсруулалтын түвшинг 2 дахин нэмэгдүүлэх ийм бодлого, чиглэлийг гаргасан. Энэ хүрээнд үйлдвэрлэгчид маань бас зээлээ аваад үйлдвэрийнхээ өргөтгөлийг хийх гээд ингээд эргэлтийн хөрөнгийн зээлээрээ түүхий эдээ авах гээд олон ажлуудыг хийж байна. Ингээд жилийн эцсээр тодорхой үр дүнгүүд эхнээсээ гарч эхэлнэ гэдгийг бас танд хэлье.

Б.Бейсен: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Өнгөрсөн та ярьж байна шүү дээ нөгөө улсууд л болохоор маш дулааны улирал урт байгаа гээд. Манайд богино ч гэсэн бид нар 2 ч удаа өвс ургамал авч чадахгүй ч гэсэн 1 удаа боломжоор авах боломжийг усан сан байгуулах, суваг татах, тэд нарын туршлагыг бид нар нэвтрүүлэх л хэрэгтэй. Та ярьж байна шүү дээ сая борооны улирал эхлэх үедээ бид нар газар тариалангаа эхэлнэ гээд. Тэр чинь буруу байгаад байгаа байхгүй юу. Бороо хүлээх биш та

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

манай Монгол оронд ус бол хангалттай байгаад байгаа. Тэрийг аль болох энгийн аргаар бороо хүлээхгүйгээр өвс ургамлаа ч гэсэн, малаа ч гэсэн, ард түмнээ ч гэсэн хүнс, өвс ургамлаар хангах боломж, бололцоо манайд байгаа. Яагаад гэвэл манай газар хангалттай, ус хангалттай. Аль болох энэ бүгдийг та хэд маань дараа жил гэх.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн гүйцээж тодруулъя.

С.Замира: Дараа жил гэхэд бас дараа дараачийн жилүүд зовлон ярихгүйгээр энийг яаралтай зохион байгуулах нь зөв болов уу гээд би бодож байна. Нийслэлийн юунд би гадаадаас ер нь манайх нүүрс авч байгаа юу, түлш авч байгаа байв уу гээд асуусан тэрэнд хариулт өгөөгүй байна. Тэгээд ер нь манайх, манай улс өөрснөө хангалттай нүүрстэй юм чинь өөрснөө хамтарсан хөрөнгө оруулалтаар ер нь нүүрсний, түлшний үйлдвэр байх бололцоо байгаа шүү дээ. Энэ тал дээр ер нь бас судалгаа хийж бас хөрөнгө оруулагч нарыг татаж, хамтран ажиллавал сайн л байна. Санал хэллээ л дээ.

Б.Бейсен: Замира гишүүн санал хэллээ. Миний хувьд энэ Хөдөө аж ахуйн яамныхнаас асуух 1 асуулт байна. Энэ баруун аймгууд зарим төвийн бүсийн аймгууд ер нь өвөлжилтийн байдалд хүндэрчихсэн байна, хүнд байдалд орчихсон. Энэ гурил, тэжээлийн асуудал хангалт өнгөрсөн жил 40.9 хувийн импортын гурил авсан байна. Энэ жил хэчнээнийг авах гэж байна? Тэжээлийн асуудал Засгийн газрын хуралдаанд оруулна гэсэн. Хэзээ оруулаад шийдэх гэж байна? Одоо үнэд орсон хойно нь шийдэх биш ойрдоо яаралтай шийдэх асуудал байна. Баруун аймгууд бараг малаа нядлаад дуусаж байна. Үлдсэн малын тэжээлд оруулах тийм асуудлыг ярьж байна. Увс, Ховд, Баян-Өлгий аймгууд. Энэ дээр ямар бодлого бариад ажиллаж байна? Мөн “Тавантолгой түлш” тэгээд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас манайх нүүрсээ импортолж, экспортолно мөртөө гаднаас түлш авна гэж юу гэсэн үг юм. 2200 км-ээс-ээс нүүрс татаад авна гэдэг чинь ичмээр л байх ёстой. Ноднин хавар ярьсан хатаагч байхгүй, зарим гал өдөөгч, барьцалдуулагч байхгүй шалтгаан ярьж байсан. Энэ жил ер нь хойтон жил дахиад авах юм уу? Үйлдвэр барих дээр төлөвлөгөө төсөвт тусгасан уу хотын, Улаанбаатар хотын төсөв, улсын юунд энэ талаар ямар арга хэмжээ авах гэж байна? Үнэхээр хариуцлагагүй асуудал байна шүү дээ. Тэрний оронд тэр Ховдын шахмал түлшний үйлдвэрийг яагаад 1600-аас тэндээс татсан нь хамаагүй тэр биз дээ. Хаа байсан Хятадын 2200 км-ээс түлш татаж байснаас. Энэ дээр ямар бодлого барьж байна та нар ер нь? Гадна улсууд энийг чинь өөрсдөө нүүрс экспортолдог мөртөө гаднаас түлш авдаг.

Нөгөө талаар энэ хэвлэл мэдээллээр 112 хүн нас барсан гээд явж байх юм. Сая та 9 сарын байдлаар энэ ... хойш 9 хүн нас барлаа гээд ярьж байна. Энэ хэвлэл мэдээллүүд жаахан буруу яагаад байна уу энэ талын талаар асууя. Нөгөө талаар энэ ирж байгаа түлш нь сая Батчимэг гишүүн бас ярилаа ерөөсөө түүхий түлш ирж байна гэж байна. Нөгөө талаар утаа ихтэй гэж байна. Энэ дээр хяналт шалгалт хийж үзсэн үү та бүгд?

4 номер Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Бейсен даргын асуултад хариулт өгье. Тэгэхээр энэ баруун бүсийн хилийн боомтууд дээр улаан буудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг татваргүй оруулах чиглэлээр нэр бүхий 64 гишүүнээс хүсэлт

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ирсэн. Энэ тухай ажиллаад бид нар яг одоо Засгийн газарт ийм эрх байхгүй учраас Их Хурлын тогтоолоор урьд нь бас 5 удаа Засгийн газарт энэ чиглэлийн эрхийг олгож байсан. Энэ зохицуулалтын дагуу бид нар Их Хурлын тогтоол, холбогдох судалгаануудыг гаргаад Сангийн яам, Хууль зүйн яам хамтарсан, хамтарч батлаад яамнуудын саналыг аваад маргаашийн Засгийн газрын хуралдааны Их Хурлын тогтоолоо оруулж байгаа. Оруулахдаа бас яаралтай горимоор хэлэлцүүлж, шийдвэрлэж өгнө үү гэсэн ийм байдлаар оруулж байгаа.

Тэгээд Засгийн газрын хуралдаан дэмжээд явуулах юм бол маргаашаас бид нар Их Хуралд энэ тогтоолыг өргөн барих. Ингэснээр Их Хурал энэ тогтоолыг батлаад өгсөн тохиолдолд бол Засгийн газарт эрх нь ирсэн тохиолдолд энэ баруун бүсийн аймгууд дээр, хилийн боомтууд дээр гурил тэжээлийг татварыг хөнгөлөх энэ боломж нь бүрдэх юм. Тэгэхээрээ процесс бол ийм байдалтай явагдаж байгаа. Мэдээж энэ сая бас Хууль зүйн сайдын асуудал солигдсонтой холбоотойгоор дахиж санал аваад ингээд явсан учраас энэ дээр бас долоо хоногийн цаг хугацаа алдсан ийм тал байгаа тэгээд хэлье. Бусад ажил. Болсон.

Б.Бейсен: 6 номер. “Тавантолгой түлш”-ийнх юм байна уу? 6 номерын хариулъя.

А.Амартүвшин: Бейсен даргын асуултад хариулъя. Манай Монгол Улсад бол яг үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотын хэрэгцээг хангах хагас коксын үйлдвэр бол одоогоор байхгүй байгаа. Төр, хувийн хэвшлээр хагас коксын үйлдвэр байгуулах ажлын судалгааны ажлыг нийслэл бол эхлүүлчихсэн. Хамгийн хурдандаа 34-өөс 30 сарын, 36 сарын дотор бол хагас коксын үйлдвэрийг ашиглалтад оруулаад явуулах боломжтой гэсэн судалгааг явсан байгаа. Дараа оны 3 сард бид нар төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ ажлыг эхлүүлэх ажлын бэлтгэл ажлыг аль хэдийнээ эхлүүлчихсэн ажлуудыг бол эхлүүлээд ингээд явж байгаа. Энэ түлшний үйлдвэр ингээд байгуулагдсанаар бид нарын цаад дундын болон холын бодлогын хүрээнд бол энэ хагас коксоор хэрэглэж байгаа гаргасан нүүрсээ бол эрчим хүчний үйлдвэрүүд болох нөгөө ТЭЦ 3, 4-үүд дээрээ бол өгч хэрэглүүлэхээр бол төлөвлөж байгаа. Харин айл өрх.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: Айл өрхүүдээ бол бид нар газ руу холбох энэ жил 5 мянга, дараа жил 50 мянга, тэрний дараа жил 65 мянган айлаар холбоод. Дээрээс нь нөгөө дэд төвүүд байгаа Сэлбэ, Баянхошуу, Шар хад, Ханын материал гээд эдгээр орон сууцжуулалтаар ороод ингээд айл өрхүүдийг 2028 он гэхэд ахуйн хэрэглээний энэ нүүрс түлэлт гэдэг асуудлыг бүрэн шийдвэрлэх энэ зорилтыг тавиад бол ажиллаад явж байгаа. Энэ үйлдвэрийн асуудал тэгээд явж байгаа.

Яагаад бид нар энэ жилээс ингээд хагас коксыг оруулаад явж байна гэх юм бол мэдээж энэ Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийх ёстой томоохон ажлуудын нэг байгаа. Энэ хугацаандаа хагас коксын үйлдвэр байгаад газтай шилжих хугацаанд бид нар энэ хагас коксыг бол импортоор орж хэрэгжүүлье. Энэний нийгэмд үзүүлэх дам нөлөө нь хамаагүй өндөр байх юм аа.

Жишээлбэл, эрүүл мэндийн хувьд гэх юм бол ханиад томуу багасна, хатгаа, түүнтэй холбоотой аллерги, астам гээд. Мөн та бүхэн мэдэж байгаа нүүрсэн түлэлтээсээ холбоотойгоор нарийн тоосжилт их гардаг PM 2.5, PM 10 гээд эд нар

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нь уушгинд шүүгдэхгүйгээр шууд цусанд ордог. Энэ нь ямар аюултай гэх юм бол цусанд ордоороо нөгөө ургийн гажилт үүсдэг. Ургийн хүүхэд дотор байгаа хүүхдийн зүрх судасны асуудлыг үүсгэдэг, дээрээс нь цаашлаад бүүр ингээд ургийн эндэлтэд хүргэдэг ийм аюултай зүйл байгаа юм аа. Ингээд хагас коксыг ингэж оруулж ирж хэрэглэснээр энэ нийт тоосонцор гэхэд л хагас коксоос бид нарын өмнө ашиглаж байсан “Тавантолгой түлш”-ийн шахалттай харьцуулахад 68.15 хувиар бол ингээд бага байгаа. Угаарын хий нь 24 хувиар, азотын исэл нь, хүхрийн хий нь ингээд бараг 85 хувиар ингээд бага байгаад байгаа юм.

Тийм болохоор ингээд нийтийн бас эрүүл мэндийн төлөө бид нар бол ингээд импортоор оруулж ирж байгаа зүйл байгаа юм. Тэгэхдээ бол бид нар дан импортоор болно гэсэн бодлого нийслэлд байхгүй. Бид нар тэр хугацаанд өөрсдийнхөө үйлдвэрийг барьж байгуулна. Ингэснээр бол дотоодын хэрэгцээг бүрэн хангана. Дээрээс нь хий рүү шилжээд энэ утаа, нүүрс гэдэг асуудлыг 100 хувь шийдэхээр ингээд нийслэл эргэж буцалтгүй орчихсон явж байгаа гэдгийг Бейсен даргад хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Жилийн жилд л ийм бие биеэ аргацаасан юм ярьсаар байгаад л дуусаж байна л даа. Бэлчээрийн төлөв байдлын тайлан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцдаг. Байгаль орчны төлөв байдлын тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариуцдаг. Энд алдаа гарч байгаа бэлчээртэй холбоотой асуудал дээр. 2 яамны уялдаа холбоо сайн байгаа гэж хэлээд байгаа. Тийм сайн биш байгаа. Би тэр өнөөдөр явагдаж байгаа үйл ажиллагаа, шинээр хийгдэх гэж санаачилж тухайн үед явуулж байсан үйл ажиллагаа, мөн хөдөө орон нутагт малчидтай уулзаад явж байхад үүсэж ярьж байгаа асуудлаас улбаатайгаар би энэ үгийг хэлж байгаа юм. Тэгэхээр 2 яамны үйл ажиллагаа сайжрах ёстой. Ер нь цаашдаа энэ Бэлчээрийн төлөв байдлын тайлан, Байгаль орчны төлөв байдлын тайланг хоёулаа ингээд 2 яаман дээр явах ёстой юм уу, үгүй юм уу гэдгээ ч гэсэн бид нар эргэж харах ёстой юм байна лээ. Тэгэхгүй болохоор үйл ажиллагааны хувьд голд нь хохирч байгаа нь өөрөө хөөрхий нөгөө малчид, бэлчээрийн хомсдол, эргээд мах, махан бүтээгдэхүүн, бусад бараа, бүтээгдэхүүний үнэ, өсөлт, ган, зуд гээд ингээд олон асуудлууд үр дагаврууд гарч байгаа шүү гэдгийг би 1 дүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулиа мөрдөж ажиллах юм уу ажиллахгүй юм уу гэдгээ бодоорой. Цаашдаа бэлчээрийн асуудлууд улам ихээр хөндөгдөнө. Тэр үед отрын мал оруулдаг болох юм уу болохгүй юм уу? Хадлангаа үргэлжлүүлж авах юм уу авахгүй юм уу? Сүүлдээ наад бэлчээргүй болсон малчид чинь тусгай хамгаалалттай газар нутаг руу чинь орно шүү. Энэ дээр бол би сайд байхдаа хатуу зарчим барьж байсан. Тэгээд энийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бас бодно биз дээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бол тусгай хамгаалалттай газар нутаг руу мал оруулъя л гэж байгаа юм байна. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэдгийг түрүүн хариулсангүй.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Нийслэлтэй холбоотой асуудал дээр өнөө түрүүн би юм асуух гэж байгаад бас амжсангүй. Автобусаа цагаар нь явуулж өгөөрэй дарга аа. Автобусаа цагаар явдаг болгоорой. Тэр цаг чинь ерөөсөө хэдэн минут хүлээгээд ирэхгүй юм. Одоо өвөл болохоор бүр хэцүү. Цагаар явдаггүй автобустай хүлээгээд байдаг. Аргаа бараад сүүлдээ буцаад машинаа гаргаж унах л асуудал үүсэж байгаа. Тэгээд энэ дээр нийслэл өвлийн бэлтгэл ажлынхаа хүрээнд энэ автобусаа цагаар нь явуулдаг хэлбэр рүүгээ оруулаарай. Бас энэ чандлан мөрдөөрэй гэдгээ хэлэх гэж байгаа юм.

Батбаатар сайдад буруу мэдээлэл өгчихсөн юм шиг байна. Энэ яамныхан өөрсдөө албан тушаалтнууд яагаад энэ сайдаа буруу мэдээллээр хангаад байдаг юм. Сингапуртай байгуулсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны зөвшөөрлийн хэлэлцээр 3 жил гацаагүй шүү дээ. Энэ чинь 2023 оны 6 сард би санамж бичгийг нь байгуулж байсан юм. 2 жилийн өмнө. Тэрний дараагаар Гантөмөр сайд Эдийн засаг, хөгжлийн сайдаар очоод энэ хэлэлцээрийн чинь асуудлыг үргэлжлүүлж авч яваад 2025 оны 2 сард энэ хэлэлцээр чинь бүрэн бэлэн болчихсон байсан. 1 асуудал байсан нь Улсын Их Хурлаар соёрхон батлах уу, Засгийн газар шууд баталчих процесс руугаа явах уу гэдэг л юм байсан байхгүй юу. Тэгээд л Улсын Их Хурлаар соёрхон батлаад яах юм бэ Засгийн газрын түвшиндээ явчихъя гээд л энэ асуудал эцэслэгдэн шийдвэрлэгдээд л Сангийн яам шийдвэрээ өгөхгүй байсан. Ер нь бол Улсын Их Хурлаас соёрхон батлах ёстой буюу олон улсын гэрээний 8.3-аар явах ёстой гэдэг заалтыг барьж байсан. Энэ дээр Сангийн яам зөвшөөрлөө өгөөд ингээд хэлэлцээр байгуулагдсан шүү. Энэ Сингапуртай байгуулсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны зөвшөөрөлтэй холбоотой хэлэлцээр бол гацсан зүйл байхгүй шүү гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ дээр өнөөдөр яам ажил хийх ёстой. Зөвшөөрлийн тухай хууль дотор энэ зүйл нь байхгүй байгаа. Яагаад гэхээр манайх уур амьсгалын өөрчлөлтийн буюу хүлэмжийн хийн хуульгүй орон. Энэ хуулийг яаралтай явуулж байж Зөвшөөрлийн тухай хууль дээр тодорхой зүйлсийг нь оруулахгүй бол хамтарсан хороо чинь үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа шүү гэдгийг бас анхааруулж хэлэх гэж байгаа юм. Ийм зүйлсийг хэлье дээ. Баярлалаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдолтой хийгдэж байгаа ажлуудыг бас яах вэ бүхэлд нь үгүйсгэхгүй ээ. Ажлууд бас жилийн жилд тодорхой төлөвлөгөөнийхөө дагуу хийгдээд явна аа. Гэхдээ ер нь бид бүхэн малчдадаа, иргэддээ бас нэмэр болохгүй юм гэхэд нэрмээс болохгүй байх ажлууд дээрээ гол анхаарал хандуулах ёстой юм гэдгийг өнөөдөр бид бас ярих ёстой. Энэ чиглэлээр тодорхой анхаарал хандуулах ёстой. Хамгийн нэн тэргүүнд түлш, шатахууны асуудал дээрээ яг энэ өвлийн бэлтгэл ажил явагдаж байгаа энэ цаг үе дээр онцгой анхаарч өгөөч ээ гэдгийг шат шатанд нь хэдүүлээ уламжилж ажиллах хэрэгтэй байна. Шадар сайдын бас өнгөрсөн долоо хоногт мэдээлж байгаагаар 100 гаруй сумууд түлшний асуудалтай, доголдолтой байна гэдэг ийм нөхцөл байдал үндсэндээ бас яригдаад байгаа. Улаанбаатарын нөхцөл байдал ч тийм амаргүй байгаа. Сайд нь өөр мэдэгдэл хийгээд яг сум, орон нутаг дээрээ очоод ингээд харахаар үндсэндээ түлшний асуудлаас болоод юмаа бэлдэж чадахгүй ийм нөхцөл байдалд очно оо. Тийм учраас нэмэр болохгүй юм гэхэд нэрмээс болохгүй

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байх ажил дээр бид бүхэн яг тодорхой бас асуудлаа бас хэлээд анхааруулаад ингээд ажиллаасай гэдэг ийм эхний саналыг дэвшүүлээд байгаа юм.

2 дахь нь мал бэлтгэлтэй холбогдолтой асуудал өвлийн энэ эрсдэлийг бууруулах хамгийн чухал асуудал болно. Бид хэчнээн тооны малыг үндсэндээ махыг үндсэндээ бэлтгэх вэ хэрэгцээлэх вэ, түүнийгээ бас өмнөх өмнөх жилүүдийн энэ алдаа оноон дээрээ тулгуурлаад их сайн хиймээр байна. Хүнсний хувьсгалын хүрээнд хийгдсэн энэ томоохон аж ахуйн нэгжүүд нэлээдгүй хөргөгч, зоорь, агуулахуудтай болсон. Энэ хүчин чадлыг бүтэн ашиглахын тулд тодорхой бодлого гаргаж ажилламаар байна. Нийт малчдадаа анхааруулж хэлэхэд энэ жил нийт газар нутгийн 20 орчим хувьд өндөр эрсдэлтэй ийм өвөл болох нь ээ.

Тийм учраас малаа хэрэгцээлэх энэ агуулгыг үндсэндээ Монгол орон даяар дэмжих энэ бодлого ажлыг бид бүхэн зохион байгуулах ёстой. Нөөцийн махыг яаж хийх вэ? Энэ нь малчдадаа эргээд хүнд тусдаг ийм асуудлууд бий болдог. Энэ дээр тодорхой бас бодлогыг зөв зохистой хийхгүй болохгүй. Өнгөрсөн 1, 2 жил салбар яам маань экспортыг хязгаарлах хүртэлх арга хэмжээг авна гээд хэв сууж байсан. Дараа нь сайд маань би хэлсэн, хэлээгүй гээд ингээд үндсэндээ булзаж байсан ярьсан агуулгаасаа. Энэ байдлыг энэ жил бас битгий гаргаасай. Экспортыг нэмэгдүүлэх энэ чиглэлдээ зарчмын тодорхой ийм байр суурьтай бас цаашдаа бас ажиллаасай. Тэгэхээр 2 дахь асуудал энэ мал бэлтгэлийн энэ бас асуудал дээр онцгой анхаарлаа хандуулах, нөгөө олгосон компаниуд, зээл олгосон компаниудаа идэвхжүүлэх, нөгөө хоршоогоор үндсэндээ бас тодорхой тоног төхөөрөмж энэ мал бэлтгэлийн үйл ажиллагаа явуулах чиглэлийн хоршоонуудаа өөр бодлогоор яаж дэмжих вэ гэдэг стратегия гаргаж ирэх чиглэл дээр бид нар хоёрт анхаарах хэрэгтэй байна.

Тэжээл бэлтгэлийн гол ажлууд зарим талдаа илүүддэг, зарим талдаа үндсэндээ дутагддаг. Газар зүйн байршил, тээвэртэй холбогдолтойгоор үнийн өсөлтүүд бий болдог. Тэгэхээр үүнтэй холбогдолтой асуудал дээр бас тодорхой бодлогын зохицуулалтуудыг эртнээс хийж яг цаг тулсан үед цасанд боогдох, түүнтэй холбогдолтой бас тэжээлийн хомсдолд орох ийм асуудлуудыг бас үүсгэхгүй байх гэсэн энэ 3 цаг үеийн асуудал дээр онцгой анхаарал хандуулахыг Байнгын хорооноос бас өнөөдөр тодорхой чиглэл, саналуудыг, бусад гишүүдийн саналыг нэмээд бас гаргах нь зөв байх гэж ингэж бодож байна. Ингээд детальчлаад яривал отрын бүсийн асуудал гээд олон асуудлууд байгаа.

Сууриараа бид бүхэн экспортын асуудал дээрээ яг үнэндээ дорвитой өөрчлөлт хийж чадахгүй байгаа. Салбар яам энэ дээр илүү сайжруулах чиглэлийн асуудлуудыг хийх хэрэгтэй. Миний асуугаад байгаа хамгаалагдсан аж ахуйн журам батлагдсан юм уу батлагдаагүй юм уу? Батлагдсан бол энэ журмынхаа дагуу аль аль улсуудтай хэлцэл хийх боломжууд бий болоод явж байгаа юм бэ? Амьд малын худалдаагаа илүү сайжруулах ямар хүсэлтүүдийг бид нар тавьсан юм, ямар уулзалтууд хийгдсэн юм.../минут дуусав./

Б.Бейсен: Гишүүдээс олон ч санал асуулт гарлаа. Ер нь Хөдөө аж ахуйн яам энэ хотын захиргаа энэ дээр бас анхаараад цаашдаа ажлаа тусгах шаардлагатай. Нөгөө талаар энэ малын тэжээлийн асуудал дээр эртнээс анхаараад яахгүй бол ер нь хүнд байдалтай болчихлоо. Нөгөө талаар гурил импортын асуудал байж байна. Энэ жил тариалалтын хэмжээ бас буурчихсан.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тийм учраас энэ өвөлжилтийн мэдэлд ажил дээр бас онцгой анхаарах шаардлагатай байгаа.

“Тавантолгой түлш” Улаанбаатар үйлдвэрийн захиргааныхан энэ дотооддоо коксжих тийм шахмал түлшний үйлдвэрийг яаралтай тэр хатаагч юутай нь хамт ер нь ашиглалтад оруулах тал дээр ер нь анхаарахгүй бол энэ гаднаас ингэж түлш авна гэдэг чинь арай болгохгүй асуудал. Нөгөө талаар гадаад руу бас валют явж байна. 224 тэрбум билүү, 240 тэрбум билүү? Тийм учраас энэ дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа.

Нөгөө талаар энэ 53 дугаар тогтоолын хувьд Их Хурлын бид утааны асуудлыг Их Хурлын чуулган дээр бас сонсох юм байгаа. Нөгөө талаар бид энэ хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажил, хаваржилт, өвөлжилтийн бэлтгэл ажил дээр бас ажлын хэсэг гаргаж бас ажиллаж болж байна. Чиглэл өгч болно. Тийм учраас энэ тал дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудлыг 1 дэх асуудлыг хэлж дууслаа. 2 дахь асуудалд орёе. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

13.28 цаг

2 дахь асуудал. Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсьё.

Ажлын хэсгээ оруулаарай. Мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батбаатар сайд танилцуулна. Батбаатар сайд 4 номерын микрофон. Батбаатар сайд микрофон асчихсан байна шүү.

Б.Батбаатар: Миний бие Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар томилогдсоноос хойших цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх хүрээнд хийсэн ажлуудын явцыг та бүхэнд танилцуулахаар бэлтгэлээ.

Энэ танилцуулгыг Засгийн газрын 2025 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн Үндэсний хороонд үүрэг болгосны дагуу бэлтгэсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолын дагуу Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх ажлын явцын мэдээллийг танилцуулахаар бэлтгэв.

Уг тогтоолоор Гадаад харилцааны дэргэдэх бэлтгэл ажлын албыг шинэчлэн зохион байгуулж, Үндэсний хорооны ажлын алба болгож өөрчилсөн. Үндэсний хороо ажлын алба нь хурлын бэлтгэлийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Барилга байгууламжийг бэлтгэх ажлын хүрээнд хурлын байрны суурь дэд бүтцийн ажлын явцын тухай мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ таталт бүрэн дууссан. Ус хангамж болон ариутгал татуургын систем суурилуулах ажил 88

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хувьтай, цахилгааны сүлжээ таталт болон зогсоолын засварын ажил 45 хувьтай байна. Цаг агаарын өдөрт дэд бүтцийн ажил гүйцэтгэхэд хүндрэлтэй болсон тул ажлыг ирэх оны 3 дугаар сараас үргэлжлүүлнэ. Өнгөрсөн долоо хоногт газар дээр нь ажилласан конвенцын Нарийн бичгийн дарга нарын төлөвлөлтийн багаас өгсөн дүн шинжилгээгээр 2026 оны 7 дугаар сарын эцэс гэхэд барилга, байгууламжийн ажил бүрэн хийгдэж дуусах боломжтой.

Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Нарийн бичиг нарын дарга нарын газраас талуудын 17 дугаар Бага хурлын бэлтгэлтэй танилцан чиглэл, зөвлөмж үзүүлэхээс гадна зарим удаашралтай асуудлуудаар шийдэлд хүрэх зорилго бүхий төлөвлөлтийн баг 10 дугаар сарын 26-ны өдрөөс 31-ний өдрүүдэд Монгол Улсад ажилласан.

Ажиллах хугацаандаа хурлын байр, байгууламж, аюулгүй ажиллагаа, зочид буудал, зам, тээвэр болон энэ жилийн хувьд тэргүүлэх бусад чиглэлүүдийн ажлын явцтай танилцсан. Хурлын байрны өрөө, тасалгааны төлөвлөлтийн зураглал гарсан учраас Үндэсний хорооны ирэх жилийн бэлтгэл ажил хурдацтай явагдах боломж бүрдэж байгаа.

Талуудын 17 дугаар Бага хурал эхлэх хүртэл 285 хоног үлдсэн байна. НҮБ-ын стандарт бүхий хурал гэдэг агуулгаар COP зохион байгуулж байсан туршлагатай олон улсын туслан гүйцэтгэх байгууллагатай хамтарч ажиллах нь эрсдэлээс сэргийлэх, бэлэн байдлыг хангахад чухал шаардлагатай зэргийг харгалзан шалгуурт нийцүүлэн хүсэлтээ илэрхийлсэн туршлагатай гадаадын компанийг сонгон шалгаруулж конвенцын Нарийн бичгийн дарга нартай гуравласан гэрээгээр ажиллахаар тогтож байна.

2. Монгол Улсаас дэвшүүлэх санаачилгыг боловсруулах ажлын хүрээнд

Үндэсний хорооны ажлын албанаас боловсруулж буй олон улсын байгууллагуудаас гадна Булангийн Европын холбоо, Африк болон Төв Азийн улсуудын сонирхлыг ихэд татан олон улсын хэмжээнд сайжруулалт хийгдэж буй гандуу бүсийн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх ус ба газрын менежментийг хөхүүлэн дэмжих, хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалт төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих байгальд суурилсан шийдлийг ашиглан тогтвортой дэд бүтцийн салбарыг бэхжүүлэх санаачилга зэрэг санаачилгыг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр боловсруулж байна.

Санаачилгуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийг газрын менежментийн чиглэлд татах говийн эко системийг нөхөн сэргээж, усан хангамж болон зохистой менежментийг дэмжих төслүүдийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглүүлнэ. Монголын талаас НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын мэргэшсэн байгууллагууд хамтран талуудын 17 дугаар Бага хурлын үеэр Монгол Улсаас олон улсын хэмжээнд танилцуулахаар бэлтгэж буй бэлчээрийн тэргүүлэх санаачилгын төслийг боловсруулж эцэслэж байна. Энэхүү санаачилгын үр шим байгаль орчны салбараас гадна хүнс, хөдөө аж ахуй, эдийн засаг, нийгэм болон ногоон шилжилтийн хурдасгуур чухал нэмэртэй тул улсаас олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх томоохон манлайлал мөн гэж үзэж байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Уг санаачилгаар дамжуулан Монгол Улсад хамгийн багадаа 500 сая ам.долларын өртөг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ гэсэн урьдчилсан тооцоолол гаргаж байна.

3. Санхүүжилт, хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд

Салбарын сайдын хувиар Үндэсний хорооны даргаар томилогдсоноос хойш зохион байгуулж оролцож буй 2 болон олон талт арга хэмжээнүүдийн хамгийн чухал хэсэг нь дээрх 3 санаачилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилт татах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ талуудын 17 дугаар Бага хурлын байр, барилга байгууламжийн зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг, туслалцаа авахад чиглэгдлээ. Үүнд:

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Даян дэлхийн байгаль орчны сан, Уур амьсгалын ногоон сангаар дамжуулан санхүүжилт, хөрөнгө оруулалт татах ажилд тодорхой ахиц гарч, нааштайгаар шийдвэрлэж буйг та бүхэнд дуулгахад таатай байна.

Талуудын Бага хурлын барилга байгууламж, зохион байгуулалтад 2 талт байгаль орчны хамтын ажиллагааг үндэслэн шууд санхүүжилтийн яриа хэлэлцээг эрчимжүүлж байна. Булангийн орнуудаас Саудын Арабын Хаант Улс, Катар Улс, Оман Улс болон Арабын Нэгдсэн Эмират Улсууд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн ба ойрын үед албан ёсны хариуг авах ухаар төлөвлөж ажиллаж байна.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд олон улсын байгаль орчны мэргэжлийн мэргэшсэн байгууллагууд өөрсдийн албан хаагчдыг Монгол Улсыг дэмжин олон улсын жишигт нийцсэн төсөл, хөтөлбөрүүд боловсруулах, байгаль орчны болон хамаарах салбаруудын чадавхыг бэхжүүлэх, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллуулах амлалтыг өгсөн бөгөөд эхний төлөөлөл 2026 оны 2 дугаар сараас ажиллах гэж байна.

Европын холбооны гишүүн улсууд Хятад, Солон, Монгол, Япон зэрэг улсуудын Засгийн газар болон хувийн хэвшлийн байгууллагуудаас шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж өгөхийг манай талаас хүссэн бол Швейцар, Англи, Энэтхэг, Непал, Зүүн өмнөд болон Төв Азийн улсууд, Африкийн зарим улсууд бодлогын түвшинд хамтран ажиллахаа илэрхийлсэн.

Дотоод хөрөнгө оруулалт, нөөцийг ашиглах ажлыг зохион байгуулж эхэлсэн. Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран бизнес 4 лэнд буюу бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий олон улсын санаачилгад үндэсний оролцогч талуудын түншлэлийг баталгаажуулах ажлыг хийж эхлээд байна.

Монголын аж ахуйн нэгж байгууллага, ТББ-ууд, хүүхэд, залуучууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулах, бэлтгэл ажилд хамруулах хүрээнд харилцан ашигтай байдлаар ажиллах боломжийг бүрдүүлж эхэлсэн.

Түүнчлэн талуудын 17 дугаар Бага хурлыг сурталчлах, олон нийтэд зөвөөр таниулах, хөрөнгө оруулалтын чиг баримжааг томсгох хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Э.Болормаа болон Л.Мөнхбаясгалан нарыг тусгай ээлжээр томилсон нь Монгол Улсын төрийн бүхий л байгууллагууд ач холбогдол өгч

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгааг нотлон харуулах, шийдвэр гаргах түвшинд байгаль орчны асуудалд анхаарал хандуулан оролцох оролцоог нэмэгдүүлж байна. Үүн дээр мөн Засгийн газрын хуралдаанаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргыг энэ албан тушаалаар нь бас тусгай ээлжээр томилсон байгааг нэмж дурдъя.

Монгол Улсад бүртгэлтэй байгаа байгаль орчны салбарын финтекс зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн байгууллагуудтай инновацад түшиглэсэн түншлэлийг хөгжүүлэх ажлыг мөн эхлүүлээд байна.

4.Бага хурлын ерөнхий агуулгын хүрээнд

Дэлхийн 197 улс нэгдэн орсон олон талт гэрээ, конвенцын шийдвэр гаргах үндсэн хуралдааны агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг зохион байгуулагч улсын Засгийн газар болон конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар хамтран шийдвэрлэдэг. Энэ зарчмын дагуу Үндэсний хорооны ажлын алба конвенцын удирдах түвшний албан тушаалтнуудтай ажиллан дараах асуудлуудыг ажлын түвшинд тохиролцоод байгаа бөгөөд Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн болно.

Нэгд, Ерөнхий уриа “Эх байгалиа сэргээж, итгэл найдварыг бадраа” гэж нэрлэх саналыг дэвшүүлж байна. Үүнтэй холбоотойгоор “Эдийн засгаа сайжруулъя”, “Амьдралыг тэтгэе”, “Усны нөөцийг хамгаалъя”, “Өв соёлоо хадгалъя”, “Эрүүлийг эрхэмлэе”, “Тэсвэрлэх чадвараа нэмэгдүүлье” гэсэн дэд урианууд газрыг нөхөн сэргээж гэдэг агуулгатай холбоос хэлбэрээр хэрэглэгдэх ч боломжтой гэж төслийн хүрээнд үзэж байна.

2-т нь ерөнхий уриатай нийцүүлэн 12 өдрийн хурлыг зохион байгуулахдаа 6 сэдэвт өдөртэй байхаар тогтож байна, тогтохоор төлөвлөж байна. Үүнд:

Усны сэдэвт өдөр, газрын сэдэвт өдөр, Хүн төвтэй өдөр, Санхүүжилтийн өдөр, Тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх сэдэвт өдөр, Хүнс, хөдөө аж ахуйн сэдэвт өдөр гэж байна.

3-д нь талуудын 17 дугаар Бага хурлын үндсэн сэдвийг конвенцын Нарийн бичгийн дарга нарын газартай шууд харилцан ажиллах ажлын алба болон Бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын дэд хороо 11 дүгээр сардаа багтаан хэлэлцэн ажлын шугамаар тохиролцон Үндэсний хороо, Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.

5.Гадаадын төлөөлөгч нарыг оролцуулах ажлын хүрээнд

Үндэсний хорооны өндөр дээд зочид, төлөөлөгчдийн оролцоог хангах үүрэгтэй Гадаад харилцааны яамаар ахлуулсан дэд хорооноос төр, Засгийн газрын тэргүүд болон олон улсын байгууллагуудын удирдлагуудыг өргөн оролцуулах асуудлыг тусад нь хариуцан ажиллаж байгаа.

Одоогийн байдлаар 30 орчим өндөр дээд зочдод урилга хүргүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хурлын ерөнхий сэдэв тодорхой болохыг хүлээж байна. Саудын Араб Улсын Риад хотноо болсон талуудын 16 дугаар Бага хуралд нэгдэн орсон улсуудын Засгийн газрыг төлөөлөн нийт 141 сайд оролцсон тул манай улс

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

энэ тоог бууруулахгүй байх чиглэлтэйгээр ажиллаж байна. Энэ чиглэлийн яриа хэлэлцээг олон улсын байгаль орчны арга хэмжээнүүдийн үеэр илэрхийлэх, албан ёсоор урих, Монгол Улсад хэрэгтэй хамтын ажиллагааны амлалт өгүүлэхийг баримталж байна.

Өндөр дээд болон сайд нарын түвшнээс бусад оролцогчдын тоог нэмэгдүүлэх хүрээнд олон улсын санхүүгийн байгууллага болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад үйл ажиллагаа явуулж буй улс орнуудаасаа төлөөлөл оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүсэлтийг илэрхийлсэн дэмжлэг, амлалтыг эхнээс нь аваад байна. Жишээ нь Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк бүрэн дүүрэн дэмжсэн. Эдгээр байгууллагуудаас гадна Европын комисс болон Европын холбооны гишүүн орнууд хүүхэд, залуучууд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж эхэлсэн бөгөөд өөрсдийн санхүүжилтээр COP-17 албан ёсны арга хэмжээ эхлэхээс өмнөх 2 өдөр төрөөс бусад оролцогч нарын зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо хийх хүсэлтээ илэрхийлсэн.

6.Бусад асуудлын бэлтгэл хангах ажлын хүрээнд

Төлөөлөгчдийн байрлах буудал болон бусад төрлийн газруудын бэлэн байдлыг хангах ажлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамаар ахлуулсан дэд хороо хариуцаж байгаа бөгөөд боломжит байдлаар байршуулах судалгааг энэ долоо хоногт дуусган Үндэсний хороонд танилцуулан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Талуудын 17 дугаар Бага хурлын албан ёсны цахим хуудсыг энэ оны 12 дугаар сард эхлүүлэх бөгөөд үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газраас авч хэрэгжүүлж буй мэд мэдээллээс гадна буудаллах боломжтой гэрээт зочид буудлуудын захиалга, аялал жуулчлалын олон төрлийн маршрут зэрэг мэдээллүүдийг нэгтгэсэн байхаар ажиллаж байна. Уг веб сайтыг конвенцын Нарийн бичгийн дарга нарын газрын веб сайттай холбон олон улсад түгээн оролцох төлөөлөгч нарт танилцуулж байх юм.

Талуудын 17 дугаар Бага хурлын албан ёсны бүртгэлийг ирэх жилийн 3 дугаар сараас конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар албан ёсоор эхлүүлснээр зочдод үйлчлэх хот доторх унаа тээвэр, нислэг болон хоол хүнс, сайн сайн дурын ажилтан угтах, зочлох зэрэг бусад үйлчилгээний урьдчилсан тооцоолол гаргах тул ирэх жилийн эхний улиралд дотоодын бэлтгэлийг эхлүүлэхээр төлөвлөсөн болно. Баярлалаа.

Б.Бейсен: Батбаатар сайдад баярлалаа. Ажлын хэсгийг нь танилцуулъя.

Б.Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ч.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Батмөнх Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны дарга, Б.Бат-Өлзий Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Д.Ариунтуяа Гадаад харилцааны хэлтсийн дарга, Б.Ундраа Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ж.Цэрэндулам Олон талт оролцооны хэлтсийн дарга, Ц.Энхсайхан Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Баттулга “COP-17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар” ОНӨААТҮГ-ын захирал,

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Болормаа гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлууд бас овоо цэгцтэй сайн явж байгаа харагдаж байгаа. Тэгээд бас сая Батбаатар сайдын хэлж байгаа танилцуулсан танилцуулга дотроос бас нэлээн сайн цэгцтэй явж байгаа харагдаж байх шиг байна. Хэд хэдэн асуудал байна. COP-17 талуудын Бага хурал ялангуяа цөлжилттэй тэмцэх асуудал Монгол Улсад болж байгаа, Улаанбаатар хотод зохион байгуулагдаж байгаа хүрээнд иргэн төвтэй талуудын Бага хурал утгатай явж болох уу? Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэд тухайн талуудын Бага хуралд аль болох олноор оролцох боломжийг хангаж өгөх бололцоо бий юү? Энэ бол урьд нь талуудын Бага хурал дээр, Уур амьсгалын өөрчлөлтийн талуудын Бага хурал дээр бас явагдаж байсан туршлага байдаг. Тэгэхээр аль болох Монгол Улсын иргэдийг цөлжилттэй тэмцэх Бага хуралд оролцуулах боломж байгаа юу гэдгийг 1 дүгээрт асуух гэж байгаа юм.

2 дугаарт, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэж ойлголоо. Манай ундны усны нөөц газар гэж бодож байгаа, ойлгож байгаа. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хийгдэх болсон үндсэн суурь шалтгаан юу вэ барилга, байшин байгуулагдах? Энэ дээр та бүхэн өөрөө цэвэр усны ундны нөөц газар гэдгээ тооцож Байгаль орчны яам энэ зөвшөөрлийг олгосон юм уу гэдгийг асуух гэж байна.

Сая Батбаатар сайд 500 сая орчим ам.доллартой тэнцэх хэмжээний төсөл, хөтөлбөр үлдэнэ гээд хэлчихлээ. Урьд нь бол 1-1.5 тэрбум доллар Монгол Улсад шууд үр өгөөжөө үлдэхээр төсөл, хөтөлбөр хэрэгжинэ гэж ярьж байсан. Тэгээд энэ 2-ын хоорондын зөрүү юу болов? Магадгүй дахиад 200 гаруй хоног дутуу байгаа учраас нэмэгдэх байх гэж найдаж байна. Тэгээд энэ ямар төсөл, хөтөлбөрүүд вэ? Та өөрөө шууд 500 сая орчим доллартой тэнцэх хэмжээний төсөл, хөтөлбөр гэж хэлсэн учраас тухайн төсөл, хөтөлбөрийн агуулгыг шууд асуучихъя гэж бодож байна.

4 дүгээрт, Монгол Улсад урьдчилсан байдлаар ямар лобби уулзалтууд, хэлэлцүүлэг, форумууд яах вэ энэ дээр бол гадаад харилцаатай холбоотой асуудал дээр Европын Холбоотой холбоотой 2 хоногийн өмнөх юм байна. Би 200 хоногийн өмнөөс төлөвлөгдөж байгаа ажлуудтай холбогдуулж асууж байгаа юм. Энд тодорхой хэмжээний лобби уулзалтууд, хөрөнгө оруулалтууд, эдийн засгийн чиглэлийн форум хэлэлцүүлэг зохион байгуулах, эсвэл тодорхой төсөл, хөтөлбөртэй холбогдсон нарийвчилсан улсуудын буюу эсвэл хөрөнгө оруулагчдын уулзалт, форум зохион байгуулагдах төлөвлөлтүүд байгаа юу? Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ялангуяа Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч гэж томилогддог. Яаман дээр өнөөдөр Ерөнхий сайдын захирамжаар томилогдсон тусгай элч хэн байгаа вэ? Энэ Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч бол маш том сүлжээ байдаг. Энэ сүлжээг бид нар өнөөдөр ашиглаж чадаж байгаа юу? Ямар ч сураг сонсогдохгүй байгаа. Тэгээд энэ тусгай элчтэй холбоотой асуудал буюу энэ Болормаа гишүүн,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Мөнхбаясгалан гишүүн энэ тэртэй хамааралгүй шүү. Энэ өөр тусгай элч шүү. Энийг асуух гэсэн юм. 1 минут нэмээд өгөөч гүйцээгээд асуучихъя.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч гэж Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар томилогддог элч байдаг. Энийг би асууж байгаа юм шүү. Нөгөөдөх нь веб сайттай холбоотой асуудал хөндөгдөж байна. Энэ аппликэйшн давхар хийгдэх үү гэдгийг би асуух гэж байна. 6 өдөртэй, 6 өдөр ийм нэрэмжит болж байгаа юм байна. Бид нар 1 зүйлийг ерөөсөө хаячхаад байна. Хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой асуудал. Бид нар сая Батбаатар сайд ч бас хэллээ COP-ын үеэр хүлэмжийн хийтэй холбоотой хэлэлцээр буюу бас байгуулахаар төлөвлөж байгаа гээд. Хүлэмжийн хийн ялгарал дэлхий дахинд өнөөдөр гол асуудал болчихоод байгаа цаг хугацаа. Тэгэхээр энэ хүлэмжийн ялгаралтай холбоотой өдөр дээрээ ч юм уу аль нэг өдөрт, аль нэг зоогдсон байгаа агуулгынх нь хүрээнд тооцогдож байгаа юм байгаа юу гэдгийг би асуух гэж байгаа юм.

Дээрээс нь ерөнхий уриа бол хэтэрхий ерөнхий байна аа. Энэ дээр жоохон нарийвчилсан яг чиглэсэн уриа байна уу гэдгийг асуух гэж байна. Тэгээд дараа нь тодруулъя. Баярлалаа.

Б.Бейсен: 4 номер Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: COP-17 иргэн төвтэй талуудын Бага хурал оролцоо энэ хэдийг байнга дэмжиж байгаа. Монголын иргэд энэ COP-17 юу болж байгаа юм, Монгол Улсын газар нутгийн 77 хувь цөлжилтөд өртсөн гэж байгаа. Энэ чиглэл рүү идэвх санаачилгыг гаргаж байгаа. COP-17 болох цэнхэр, ногоон 2 бүс байгаа. Ногоон бүс рүү ороход Монгол Улсын иргэд зүгээр орж байгаа тооны хувьд бүртгэгдэж байгаа шүү. Ямар нэг тийм хашилт, хаалт байхгүй. Чөлөөтэй оруулах. Хэрвээ шаардлагатай тохиолдолд нэмэлтээр талбай засаж анхаарах энэ чиглэл рүү их анхаарч байгаа. Орон нутгаас иргэдийг оролцуулах энэ чиглэлд идэвх санаачилга гаргаж ажиллана гээд санаа нэг байгаа гэдгийг нь хэлчихье.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дээр болох ажил нь ер нь COP зохион, талуудын Бага хурал зохион байгуулагдах газар, байшин сав юу байдаг юм тэр байршлыг нь НҮБ-ын конвенцын Нарийн бичгийн талуудын газартай хамт ингээд тохирдог. Ганцаараа Монгол Улсын Засгийн газар хийчихдэггүй. Тэгэхлээр энэ газрыг хэзээ тохирсон бэ гэхлээр 2024 оны 11 дүгээр сард Гадаад харилцаа, Байгаль орчин, уур амьсгалын болон Нийслэлийн Засаг дараг нар, нэг ёсондоо Батцэцэг сайд, Одонтуяа сайд, Нямбаатар дарга гэсэн энэ 3 хүн яриад конвенцын Нарийн бичгийн талууд тийм хүмүүс нь Монголд ирж 3 байршлыг үзээд, ярилцаад тэгээд энэ дээрээ тохирсон юм байна лээ. Ингээд 25 оны 1 сард байх аа андуурчихсан бол хэлээрэй 25 оны сард НИТХ хуралдаж тэр газар дээр COP-17-г зохион байгуулах тэр газрыг нь гаргасан, тогтоол шийдвэр гаргасан.

Одоо энэ асуудлыг зүгээр би нөгөө өөрчилж болох арга байна уу гэсэн боломгүй юм байна лээ. Буцах аргагүй болчихсон. Тэгэхлээр энэ дээр өөрчлөлт хийх боломжгүй болчихсон. Тэгэхээр энэ асуудлыг тэгж ойлгоод явсан нь зүйтэй байх.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хэрвээ зүгээр магадгүй Мишээл экспо ч байдаг юм уу, Дүнжингарав зах дээр ч байдаг юм уу хийсэн бол барилга, байшин нь болох боломжтой гэж үзэж байсан. Хэрвээ тэгж болсон бол бид нар татвар төлөгчдийн мөнгөнөөс 100 тэрбум төгрөг хэмнэх боломж байсан гэж би хувьдаа харж байгаа. Гэхдээ энийг бид нар нөгөө НҮБ-ын конвенцын Нарийн бичгийн дарга нартай хамтдаа эцэслэж шийдвэр нь гарчихдаг учраас үүн дээр буцааж хойш нь татах, залуур эргүүлэх боломжгүй болчихоод байгаа юм аа.

500 сая доллар гэдэг зөвхөн бэлчээрийн санаачилга юм байгаа юм. Бэлчээрийн тэргүүлэх санаачилга. Тэр урьд нь хэлж байсан 1.5-3 тэрбум доллар. Ер нь болж өгвөл 2 тэрбум, 1.5-аас.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулъя Батбаатар сайд.

Б.Батбаатар: 500 сая долларын тухайд бол тийм байгаа. Өшөө бусад зүйлүүд нь хөрөнгө оруулалтууд үргэлжилнэ. Энэ бол 1.5 дээрээ очно оо гээд ойлгочих хэрэгтэй.

Урьдчилсан лобби юу байна вэ, уулзалт хөрөнгө оруулалт энэ чиглэлийн ажлууд юу байна вэ гэж. Одоо 1 санаачилгыг гаргаад эхлүүлж байгаа. Хятад, Япон, Солонгос, Монголын Байгаль орчны сайд нар уулзаж энэ шар шороон шуурга, туурэнг СОР-ын сэдэвт оруулах тухай санаачилга болгож 4 улсын манлайлалд доор. Тэгэхээр энэ чиглэлийн ажлууд дөнгөж эхэлж байгаа. Энийг хэрвээ үр дүнд хүргэвэл энэ маш том Монгол Улсын энэ цөлжилтийг байхгүй болгож байж л энэ шороон шуурга алга болно шүү дээ. Тэд нарт очдог нөлөөллүүд нь арилна. Тийм болохоор энэ дөнгөж эхэлж байгаа.

Дээрээс нь бусад урьдчилсан санал, санаачилгууд явж байгаа зүйлүүд бас СОР-17 хурлаас өмнө нэлээдгүй зүйлүүд.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж яриулъя. 2 минут өгчихье. Батбаатар сайдад.

Б.Батбаатар: 6, 7 асуулт учраас минутыг нь сунгаж өгөхгүй бол.

Тэгээд энэ хөрөнгө оруулалтуудыг хийх чиглэл рүү ажиллаж байна. Ер нь гадаад томилолтоор Фижи, Абу Даби, Вашингтон Ди-Си, Америк гэсэн ийм 3 чиглэлд явсан. Үүн дээрээс одоогийн байдлаар гарч байгаа хөрөнгө оруулалт, зүгээр хурал зохион байгуулахуйц шүү. Тэгэхэд ойролцоогоор хамгийн багадаа 40, 50 сая долларт магадгүй өшөө нэмэгдэх энэ хурал зохион байгуулахад оруулж байгаа хөрөнгө оруулалтаар татвар төлөгчдийн мөнгийг бүтнээр нь хэмнэж үлдээхийн төлөө ажиллана. Гэхдээ бид нар эрсдэлээ тооцох учраас дээрээс нь Монгол Улс өөрөө оролцоотой ажиллаж байгаа гэдгээ илтгэх үүднээс бид нар төсөвт байгаа СОР-ын мөнгийг татаж авч болохгүй гэдэг ийм байр суурьтай ажиллаж байгаа.

Бэлчээр, ус, газар энэ байгальд суурилсан шийдэл. Энэ чиглэлд нэлээдгүй зүйлүүдийн хөрөнгө оруулалтууд яригдаад эхэлчихсэн. Манай усны чиглэлийн нэлээн хэдэн төслүүдийн ТЭЗҮ болоод бусад хөрөнгө оруулалтыг гадна талын байгууллагууд, компаниуд, олон улсын байгууллагууд хийе гэж байгаа. СОР-17-тойгоо холбоотойгоор бас хэрэгжиж байгаа гэж.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тусгай элч гээд Батхишиг гээд байгаа. Одонтуйа сайдын үед Засгийн газраар өөрийн чинь асуугаад байгаагаар томилогдсон тэр хүн хэвээрээ байж байгаа. Аппликэйшн Бат-Өлзий дарга нэмээд хариулж байгаарай.

Хүлэмжийн хийн асуудал, хүлэмжийн хий болоод энэ усны асуудал дээр эн тэргүүнд анхаарч ажиллаж байгаа. Тийм болохоор хүлэмжийн хийн асуудлаар бид нар байнга ярьж байгаа. Сая эндээсээ 3- шинэчилсэн. Тэр уур амьсгалын өөрчлөлтөд “Тэсвэрлэх өдөр” гээд тэр чинь хүлэмжийн хий ер нь явж байгаа гэж ойлгоход болно доо.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Ерөнхий ерөнхий хүрээний хувьд одоо бид нар зүгээр яг ярилцаж байгаа шүү.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Сайд андуураад хэлчхэв үү эсвэл шинэчилсэн тооцоо, судалгаагаар цөлжилтийн хувь хэмжээ 87 хувь хүрсэн юм уу? Та сая 87 хувь гээд хэлчихлээ цөлжилтөд нэрвэгдсэн газар нутгийн хэмжээ. Тэгвэл би буруу сонссон байна.

Хувийн хэвшил бизнес эрхлэгчтэй холбоотой зохион байгуулалтын ажлууд эхэлсэн байгаа юу? Ерөөсөө энэ уул нь СОР чинь бол хувийн хэвшлийн л хийх ёстой ажил. Тэр үйл ажиллагааных нь хүрээнд. Тэр хоол унд илүү дутуу асуудлууд. Албан хуралдаанаа төр хийгээд явах байх. Энэ дээр ямар ажлууд хийгдэж явж байгаа вэ? НҮБ оролцсон гэж байна. Энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дээрх усны нөөцтэй холбоотой хэдэн га газар гаргасан юм? Сүүлд сонсоод байхад наад зөвхөн СОР биш Үндэсний урлагийн их театр баригдах болсон сураг сонсогдоод байгаа юм. Тийм. Тэрийгээ та бүхэн маань хариулаад хэдэн га газар вэ гэдгээ хариулаад өгчихсөн нь зөв байх.

Мишээл экспо дээр Батбаатар сайдтай би санал нэг байна. Уул нь хамгийн анх Мишээл экспо дээр хийе гэдэг төлөвлөлттэй байсан юм. Тэр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн шиг байсан учраас. Зохион байгуулалтын хүрээнд ч гэсэн зун хийгдэж байгаа юм яах.../минут дуусав./

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгээд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээ биш ээ Мишээл экспо-г хийгээгүйд харамсалтай байна. Уул нь тэр рүүгээ чиглээд явчихсан бол илүү боломж байсан болов уу гэж харж байсан. Ер нь яах вэ энэ эдийн засгийн тооцоо судалгаа ялангуяа хүлэмжийн хийтэй холбоотой асуудлууд, олон улсын хооронд гэрээ хийгдэж байгаа контрактын асуудал гээд ингээд харахаар бүх улсын эдийн засгийн хөгжлийн яамнуудын холбоотой асуудлууд энэ дээр орж ирнэ. Байгаль орчны яам дангаараа биш.

Тэгэхээр бусад улс орнуудын эдийн засгийн хөгжлийн яамнуудтай хэр харилцаа тогтоож байгаа вэ? Манай Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам энэ дээр хэр оролцоотой байгаа вэ гэдгийг би бас асуумаар байна. Зөвхөн

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байгаль орчны яам энэ дээр дангаараа ажиллаад эдийн засгийн тооцоо судалгаа, төсөл, хөтөлбөр хариуцах, хэлэлцээртэй холбоотой асуудлыг бол Байгаль орчны яам дангаараа хийж чадахгүй л дээ. Сингапур гэхэд л хүлэмжийн хий чинь бол эдийн засгийн хөгжлийнх нь яамны асуудал шүү дээ. Байгаль орчных нь яамны ч асуудал бас биш нэг талдаа хамтардаг. Тэгэхээр энэ дээр бас та бүхэн маань уулзалтууд хийгдэж байгаа юу гэдгийг би нэмж.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. 6 номер. Дараа нь 1 номер хариулах юм байна.

Б.Баттулга: Эрхэм гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн “СОР-17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар” орон нутгийн өмчит байгууллага.

Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулахад байршлыг түрүүн сайд хэлсэнчлэн Гадаад харилцааны сайд, Байгаль орчны сайд, Нийслэлийн Засаг дарга нарын хамтарсан танилцуулга хурал дээрээс энэ байршлыг НҮБ-д зөвлөх үйлчилгээ үзүүлдэг зөвлөх компаниудын гаргаж өгсөн байршлуудын үнэлгээ, дүгнэлт дээрээс үндэслэж шийдвэрлэсэн. Тухайн үед өмнө нь ажлын хэсэг Засгийн газар дээр байгуулагдсан ажлын хэсэг хэд хэдэн байршлууд дээр үзлэг, танилцуулга хийсэн байсан. Мишээл экспогийн хэсэгт бид бүхэн бас дахиж очиж танилцуулга юмнуудтай нь танилцсан. Тэр үед энэ олон улсын зочид буудал, үзэсгэлэн, хурлын танхимуудын төсөл нь зогссон байдалтай 26 онд ашиглалтад орох боломжгүй гэсэн ийм хариуг тухайн төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя. 1 минут.

Б.Баттулга: Энэ шийдвэрийн дагуу 3, 2 сайд Нийслэлийн Засаг даргын хамтарсан энэ хурлын дагуу НИХ-ын 2026 оны 2 сарын 26-ны өдрийн 25/23 НИХ-ын тогтоолоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 38 га талбай дээр энэ СОР-17 хурлыг зохион байгуулах байршлыг баталсан. Энэ байршил дээр ердөө 8 га талбай дээр нь түр байгууламж барихаар шийдсэн. Бусад хэсэг дээр тохижилт, ногоон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулахаар шийдсэн. Энэ нь Байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн яамны 25 оны 5 сарын 12-ны өдрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг бас үндэслэж гаргасан шийдвэрүүд.

Цаашлаад Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд энэ төлөвлөлттэй уялдуулаад иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх энэ зүүн хэсгийн тохижилт, ногоон байгууламж үлэмж хэмжээгээр нэмэгдэн. Дэд бүтцийн асуудлууд шийдэгдэнэ. Одоогоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд төвийн дэд бүтэц холбогдсон.../минут дуусав./

Б.Бейсен: 1 номер хариулах юм уу хэдэн номер? 6 номер гүйцээж хариулъя.

Б.Баттулга: Сүүлд яригдсан тэр Үндэсний урлагийн их театр яг энэ СОР-17 хурлын байршлаас өөр хэсэгт шийдвэрлэгдсэн. Энэ оны сая сүүлд хуралдсан НИХ-аас гарсан шийдвэр. СОР хурлыг зохион байгуулах энэ ажил олон үе шаттай энэ судалгаа тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг үндэслэж гаргасан ийм байршил гэдгийг эрхэм гишүүдэд хэлье. Баярлалаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Б.Бейсен: Байж байгаарай. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэн хариулах вэ? 3 номер.

Д.Батмөнх: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ажлын албаны дарга Батмөнх. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Ер нь хурлын ажлыг 2 шат, 3 шатад хувааж харж. 1 дүгээр шат мэдээж хэлэлцээрийн шат байсан. Энэ Монголын Засгийн газар НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар. Энэ хэлэлцээр бол дууссан.

Хэлэлцээрийн 2 дугаар шат бэлтгэл ажлын шат. Энэ бэлтгэл ажлын шатдаа бид нар ажиллаж байна. Энэ хүрээнд хамгийн чухал зүйл бол үнэхээр яагаад энэ COP гэдэг хурлыг бас хөгжиж байгаа оронд хийдэг нэг зорилго нь энэ шууд хөрөнгө оруулалт. 140 орны юм уу 150 орны Засгийн газар, НҮБ-ын бүх байгууллагууд, олон улсын байгууллагууд, байгаль орчны салбарт ажилладаг бүх ТББ-ууд ирж байгаа. 7-10 мянган хүн.

7-10 мянган хүнийг нөгөө талаар нь харвал жуулчин гэж харах ёстой. Тийм болохоор 11 сарын 13-нд бизнес зөвлөлтэй хамтраад 100-аад томоохон компаниудтай яавал би COP-16.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Д.Батмөнх: COP-16-гийн бизнес фортландтай холбоод бид нар тэр нөгөө байгальд ээлтэй дэд бүтэц гэдэг дээр ерөнхийдөө хувийн хэвшил рүү чиглэж байгаа гэсэн үг. Тэр дээр COP-16-гийн дарга ч гэсэн мэндчилгээ дэвшүүлэх байх. Тэрнээс гадна 11, 12 сардаа багтаад Зочид буудлуудын холбоо зочид буудлууд, болон тур операторуудад та бүхэн бид нар 7-10 мянган нэг талаар жуулчид, гаднынхан ирэх юм байна. Энд тохирсон аялал жуулчлалын хөтөлбөр та нар гаргаж өгөөч гэдэг хүсэлтээ тавиад энийгээ бид нар НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулаад ингээд тараана. Ерөнхийдөө бид нар 100-150 тэрбум төгрөг шууд орж ирнэ гэж харж байгаа. Энэ 11, 14 хоногийн хугацаанд.

Б.Бейсен: Мандхай гишүүн. 1 номер гүйцээж хариулъя. 1 номер.

Б.Бат-Өлзий: Эрхэм гишүүд энэ өдрийн амгаланг эрье. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Бат-Өлзий. Бат-Эрдэнэ гишүүний асуусан апп, вебсайттай холбоотой асуултад хариулъя.

Вебсайтын хувьд түрүүн хэлсэнчлэн хуралд оролцох, хурлын бүх төрлийн мэдээлэл Монгол Улсад хөрөнгө оруулбал ямар ямар байгаль орчны холбогдолтой өгөгдөл, мэдээллийг веб сайтдаа байршуулна гэж үзэж байгаа. Апп-ын хэмжээнд хувийн хэвшлийнхээ олон шийдлүүдтэй танилцсан. Жишээ нь “JCI ASPAC” хийж байх үеийн маш олон туршлагауд харахад буудал Монгол Улсад ирээд такси, буудал, ойр хавийн аюулгүй үйлчилгээгээр үйлчлүүлэх дэлгүүр хоршоо бүх мэдээллүүдийг апп-аар шийдэж болж байгаа. Тэр апп-аараа тэр төлбөр, тооцоогоо хүртэл шийдэх боломжтой. Мөн аюулгүй байдал, аюулгүй

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

асуудал үүсэх үед шууд түргэн тусламж авах боломжтой гэсэн ийм үйлчилгээнүүдийг нэгтгээд хувийн хэвшилтэйгээ хамтарч хийхээр ярилцаж байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсдаа СОP-17-г амжилттай зохион байгуулах юм бол ганцхан байгаль орчин, эдийн засаг гээд зогсохгүй гадаад бодлого мэдээж бас гаднын энэ хөрөнгө оруулалтын хувьд ч гэсэн илүү таатай түвшинд, бид нар бас шинэ түвшинд гарах байх гэж бас хүлээлттэй байгаа. Гэхдээ энэ тайлангуудыг ингээд уншаад үзэхээр өнөөгийн бэлтгэлийн явц ер нь зохион байгуулалт ч тэр, санхүүжилтийн баталгаажуулалт, хүний нөөц ч гэсэн бас хангалттай түвшинд байхгүй байгаа юм биш үү гэсэн ийм дүр зураг харагдаж байна. Жишээлбэл, ялангуяа энэ манайх улирлын шинж чанартай энэ барилгын салбар 3 сараас үргэлжлүүлэхээр энэ барилга, дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлнэ гээд тайлан дээр тусгачихсан байна. Гэтэл энэ арга хэмжээ маань 10 сарын 16-нд болохоор төлөвлөгдөж байдаг. Тэгэхээр энэ хугацаандаа багтаж ингээд дуусах уу энэ бодитой баталгаа гаргаж өгч чадах уу? Дотоодын болон энэ хяналтын механизм хэрхэн зохион байгуулалттай ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа вэ?

Хоёрдугаарт санхүүжилтийн хувьд Саудын Араб ч гэдэг юм уу, Катар, Эмират, Оманы ингээд Султаны Улс гээд ингээд олон улсуудаас бас тодорхой хэмжээний санхүүгийнх нь дэмжлэг бараг 30 сая орчим долларын дэмжлэг ирж байгаа юм байна. Гэхдээ жишээлбэл зөвхөн Оманы Султани улсаас авах хөрөнгө оруулалтын санхүүжилт 9 сард багтаан эцэслэнэ гэж байгаа юм. Тэгтэл энэ 10 сард болох арга хэмжээ 9 сард хэрэв санхүүжилтээ эцлэгдэхээр байх юм бол ер нь бид нар ингээд яг энэ төлөвлөгдсөн ажлуудаа, зарцуулалтаа хийж чадах уу? Энэ нийт зардлын хэдэн хувийг ер нь энэ гаднын хөрөнгө оруулалт эзэлж байгаа вэ гэдгийг бас тодруулъя.

Олон улсын хамтын ажиллагаа дээр энэ бэлчээрийн тэргүүлэх санаачилга, гандуу бүсийн менежментийн төслүүдийг хэрэгжүүлнэ гээд тусгачихсан байсан. Энэ төсөв хэрэгжилтийн хугацаа болон энэ гол түншүүд нь хэн байх юм бэ гэдэг асуултыг асууя. Манайд яг дотооддоо өөрөө энэ тэргүүлэх үүргийг бод бодитой гүйцэтгэх ийм чадавхтай хувийн хэвшлийнхэн байгаа юу? Дотоодын бэлтгэл, хүний нөөцтэй холбоотойгоор хуралд 30 орчим өндөр, дээд төлөөлөгчид ирэхээр төлөвлөгдсөн байгаа юм байна. Үүнтэй холбоотойгоор бид нар тэдэнд үйлчлэх үйлчилгээ, аюулгүй байдал, орчуулга, магадгүй сайн дурын энэ ажилтнуудын бэлтгэлийн бэлтгэл хэр хангагдаж байгаа вэ, хангалттай түвшинд байгаа юу? Энэ ажлыг хариуцаж байгаа ямар байгууллага байгаа вэ гэдгийг бас тодруулж өгөөрэй. Тэгээд хурлын дараах үр ашиг. Бид нар ингээд 500 орчим сая доллар гэх шиг боллоо сая доллароор 180 орчим тэрбум төгрөг, 160-аас 80 орчим тэрбум төгрөгийн бодит хөрөнгө оруулалт орно гэж хэлж байгаа. Эндээс яг ямар бодит хүлээлттэй энэ төсөл хэрэгжих вэ гэдэг ийм дараах асуултуудад хариулж өгнө үү.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя 4 номер.

Б.Батбаатар: Манай хариуцсан хүмүүс Гадаад харилцааны яам, Төрийн тусгай хамгаалалтын газар, ажлын алба, яамны хүмүүс маань хариулчхаарай. Ерөнхийдөө бид нар Их Хурлын гишүүд нэг зүйлийг бодох хэрэгтэй. Олон улсын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өмнө үүрэг хүлээгээд аваад ирсэн арга хэмжээ. Одоо бидэнд ухрах гарц, цаг хугацаа, гарц, боломж байхгүй болсон. Бид нар үүн дээр Их Хурал бас бодит дэмжлэг үзүүлэх шийдвэрээ гаргаж өгөөсэй гэж хүсэж байна. Энэ арга хэмжээг зохион байгуулж байгаа түрүүн тэр 30, 40 сая доллар гээд хандив, тусламж гэж байна шүү дээ тэр чинь зөвхөн хуралд зориулж байгаа. Хурлын зардалд. Тэр бол хамгийн бага дүнгээр нь хэлж байгаа тоо. Бас өндөр хүлээлт үүсгээд дараа нь тэр мөнгө нь хаана байна вэ гэдэг зүйл рүү орчихвол бас бид нар яг өнөөдөр шууд төсөөллөө хэлчхэж хараахан болохгүй байна.

Бэлчээрийн тэргүүлэх санаачилга, гандуу бүс нутаг, энэ дэд бүтцийн тухайд тэр хурал зохион байгуулагдах газрын дэд бүтцийн 80 гаран хувь нь хийгдээд дуусчихсан. Одоо түр байгууламж барихад 2 сарын хугацаа л хэрэгтэй. Тэгэхээр 3 сард эхлэхэд 5 сар дуусчихна. Угсралтын ажил, түр байгууламж бол бэлэн. Угсрагдах зүйл хүрч ирээд баригдана. Чимгүүндарь-аас эхлээд. Энэ дугаар дээр суухгүй бол.

Б.Бейсен: Тийшээ юунд суучих. 1 номерын микрофон.

Н.Чимгүүндарь: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Би энэ Батцэцэг сайдыг төлөөлж Үндэсний хорооны дэргэд байгуулсан 12 дэд хорооны 1 буюу өндөр, дээд түвшний арга хэмжээний дэд хороог төлөөлөн ажиллаж байгаа, хариуцан ажиллаж байгаа. Өндөр, дээд түвшний зочдын хувьд бол энэ конвенцын хүрээнд, Цөлжилттэй тэмцэх конвенцын хүрээнд өндөр, дээд түвшний арга хэмжээ ердөө л 3 удаа болж байсан юм байна лээ. Одоо та бүхэн харах юм бол COP-17 гээд бид нар 17 дахь удаагийн хурлыг нь хийх гэж байгаа. Гэхдээ ердөө 3-хан удаа буюу 3 дахь удаа нь манайд ирэх гэж байгаа өндөр, дээд түвшний арга хэмжээ болно. Дээд тал нь 14 хүн, 14 улсын өндөр, дээд түвшний зочид оролцож байсан. Доод тал нь бол 5 улсын өндөр, дээд түвшний зочид оролцож байсан ийм статистик үзүүлэлттэй байгаа.

Манай хувьд бол өндөр, дээд түвшний зочин авах туршлага бол харьцангуй сайн. Бид одоогоор бол Засгийн газрын хуралдаанд 30 улсын төлөөлөгчийг урихаар жагсаалтаа гаргаад энэ чиглэлээр ажиллана. Хурлын ерөнхий сэдэв, агуулга тодорхой болсны дараа бид нар урилгаа хүргүүлээд манай Элчин сайдын яамнууд дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулаад урилгаа хүргүүлээд араас нь хөөцөлдөөд оролцоогоо хангахаар ажиллана. Энэ өндөр, дээд түвшний арга хэмжээг зохион байгуулах эсэх дээр бол манай Гадаад харилцааны яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төрийн тусгай хамгаалалтын газартай нягт холбоотой ажиллаж энэ дутуу байгаа зүйлсээ бэлтгэхээр ажиллаж байгаа. Хүндрэлтэй асуудлууд нь бол унаа машин, өндөр, дээд түвшний зочдыг хүлээж авах сайн чанарын хамгаалалттай машины дутагдал байгаа. Энэ асуудлыг бол бид нар бас зам, тээврийн асуудал хариуцсан дэд хороотойгоо нягт холбоотой ажиллахаар төлөвлөж байгаа.

Б.Бейсен: Хэдэн номер вэ? 3. 2 номер микрофон.

Ш.Цэрэндулам: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Мандхай гишүүний асуултад хариулъя. Асуултын сайн дурын ажилтнуудыг хэрхэн бэлдэж байгаа вэ? Мөн хүлээн авагч улсын ажилтнуудыг хэрхэн бэлтгэж байгаа вэ гэсэн энэ асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газар конвенцын Нарийн бичгийн газартай байгуулсан хэлэлцээрийн дагуу хэлэлцээрийн хавсралт 3 бол Монгол Улсын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Засгийн газраас конвенцын Нарийн бичгийн газарт хүлээлгэж өгөх ёстой хүлээн авагч улсын ажилтнуудыг бэлтгэх асуудал бий. Нийтдээ бид нар төрөл, ангиллаар нь авч үзэх юм бол 12 төрөл, ангиллын нийтдээ 297 орчим ажилтнуудыг бэлтгэж өгөх ёстой байгаа. 7 хоногоос 1 сарын хугацаанд ажиллуулахаар. Тэгэхлээр зэрэг энэ ажлыг бол бид нар зохион байгуулахдаа конвенцын Нарийн бичгийн газраас өгч байгаа зөвлөмжийн дагуу хэлний өндөр шаардлагууд тавигдаж байгаа учраас хэлний өндөр шаардлагатай боломжит төрийн албан хаагчид болон бусад албан хаагчдыг ажиллуулахаар ингэж бол төлөвлөгөөгөө гарган ажиллаж байгаа.

Хоёрдугаарт нь сайн дурын ажил ажлуудыг бэлтгэх асуудлууд. Сайн дурын ажилтнуудыг бэлтгэх асуудал бол одоогийн байдлаар Үндэсний хорооны дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа Хамтын ажиллагааны дэд хороон дээр бол хариуцан ажиллаж байгаа. Бид бол 2026 он өөрөө бас зөвхөн Монгол Улсад бас СОР зохион байгуулаад зогсохгүйгээр НҮБ-ын сайн дурын ажилтнуудын бас жил гэж ингэж зохион байгуулагдах юм байна лээ. Үүнтэй уялдуулаад НҮБ-ын сайн дурын байгууллага буюу сайн дурын ажилтныг хариуцдаг энэ байгууллагатай хамтдаа сайн дурын ажилтнуудыгаа бэлтгэх, мөн хэрэгцээтэй байгаа сайн дурынхаа ажилтнуудын тоо хэмжээг гаргах, түүндээ тулгуурлаж ажиллах гэсэн ийм байдлаар ажиллаж байгаа. Энэ оны 12 сарын 10 гэхэд бол бид нар НҮБ-ын сайн дурын энэ ажилтнуудыг бэлтгэн байгууллагатайгаа хамтдаа эхний ээлжийн шаардлагатай байгаа ажилчдынхаа тоог бол тодорхойлох, цаашлаад ямар график, төлөвлөгөөгөөр хүмүүсээ бэлдэх вэ гэдгээ гаргахаар байгаа юм.

НҮБ-ын сайн дурын ажилтнуудын байгууллага бол тодорхой хэмжээгээр бид нарт бол шууд юу гэдэг юм техникийн туслалцаа үзүүлэх байдлаар хамтран ажиллана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Б.Бейсен: 3 номер хариулъя нэмж.

Д.Батмөнх: Би тэр орлоготой холбоотой хэсэг хариулъя. Ер нь 7-10 мянган оролцогч, нөгөө талаар жуулчин ч юм уу хүн оролцоно гэж тооцож байна. Тэгэхдээ энэ чинь нэг дор ирэхгүй ингээд цуварч ирнэ. Яагаад гэвэл хурал 12 хоногийн турш үргэлжлэх учраас. Орлого дотор бид юу тооцож байна 1 дүгээрт онгоцны билет, 2 дугаарт нь буудал, service apartment, service house-ын түрээс, 3-д нь маршрут, аялал жуулчлал, 4-д нь худалдаа, бүх төрлийн худалдаа, 5-д нь хоол catering, 6-д нь манайх шууд хурал дээр өөрөө хөх болон ногоон бүсийн түрээс sponsorship гээд энэ орлогуудыг багцлаад 150 гэж бид нар харин хамгийн бага тоогоор авсан л гэж үзэж байгаа юм. Тэгээд ер нь бол одоо хэлээд байгаа.

Жишээлбэл, Европын орнуудын хэлээд байгаа зүйл нь манай энэ 8 сарын хурлын үе маань Европын хүмүүсийн гэр бүлээрээ амардаг хугацаатай давхцаж байна аа. Тэгэхээр та нар энийг анхаараад хэрвээ юу гэдэг юм тэртээ тэргүй гэр бүлээрээ амрах гэж байгаа юм чинь хуралд суунгаа Монгол Улсыг очиж үзээрэй гээд аялал жуулчлалын сайн маршрут гаргаад ирвэл наадах чинь бас сайн санаа болно шүү, сайн санаачилга болно шүү гэж хэлсэн. Тийм ч учраас бид нар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, манай яам 2 хамтраад тур операторууд, зочид буудал энэ бүгдтэй нь ингээд хамтарсан арга хэмжээ зохион байгуулаад аль болохоор боломжийн олон үйлчилгээ санал болгооч гэдэг маягаар л хэлж байгаа юм.

Б.Бейсен: 5 номер микрофон. Нэмж хариулах юм байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Ариунтуяа: Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газраас СОР-17-г, талуудын 17 дугаар бага хурлыг ашиглан олон улсын тавцанд гаргахаар 3 санаачилга байгаа. Энэ 3 санаачилгын тус тусад нь товчоор танилцуулгыг нь танилцуулъя. Тэгээд дэлгэрэнгүй мэдээллийг нь бас танд өгье.

Бэлчээрийн тэргүүлэх санаачилгын хувьд 26 он өөрөө онцлогтой жил байгаа. Олон улсын бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил, бэлчээр буюу бүх төрлийн өндөр уулын оройгоос бусад бүх төрлийн хуурай газрыг агуулдаг бэлчээр гэдэг ойлголтод хамаарах газар нутгийн менежментийн асуудал хоёр 26 онд олон улсын байгаль орчин, хөдөө аж ахуйн салбар давхцаж байгаа учраас Засгийн газраас бэлчээрийн тэргүүлэх санаачилгыг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн.

Дээрээс нь энэ нь энэ санаачилга маань конвенцын Нарийн бичгийн даргын газраас бас сайшаагдаад НҮБ-ын системийн байгууллагуудын хүрээнд дэмжигдсэн ийм санаачилга байгаа. Монгол Улс энэ олон улсын санаачилга байна. Энэ олон улсын санаачилгаас Монгол Улсын бүхий л оролцогч байгууллагууд өөрсдөө төсөл, хөтөлбөрөө боловсруулан санхүүжилт татах бүрэн боломжтойгоор энэ санаачилгыг боловсруулж байгаа. Ялангуяа бэлчээрийн тэргүүлэх санаачилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх байгууллага нь Байгаль орчны яам байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байна. Монгол Улсад Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас гаргаж өгсөн мэдээллээр яг бэлчээр, нүүдлийн мал аж ахуй эрхлэгч газар ашиглалтыг дэмжсэн 15 төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, холбоод байдаг. Тэгэхээр эд нар маань бас энэ арга хэмжээг, энэ төслийг санаачлахыг бодит хэрэгжилтийг нь хангахад оролцох боломжтой болж байгаа.

Усны санаачилгын хувьд.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж яриулъя.

Д.Ариунтуяа: Усны нөөцийн нэгдсэн менежментийг Монгол Улс энэ энэ конвенцын талуудын 17 удаагийн, 16 удаагийн түүхэнд анх удаа усны асуудлыг чухалчилж гаргаж ирж байгаа улс болж байгаа. Усны асуудлыг гаргаж ирж байж цөлжилт, газрын доройтолтой тэмцэнэ. Эргүүлээд бас гандуу хуурай бүс буюу нэн эмзэг экосистемийг нөхөн сэргээх асуудлыг илүү түлхүү оруулж ирэх ажлыг олон улсын талдаа ч 2 талаараа, олон тал дээрээ хариу санаачлаад явж байгаа. Улс орнууд маш ихээр дэмжээд хамтарч ажиллахаа илэрхийлсэн. Энэ хүрээнд жишээлэх юм бол Ажлын албанаас болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Онги-Цагаан бургастайн экологийн төслийг яг одоо энэ усны нөөцийг, менежментийг илүү хөхүүлэн дэмжиж байгаа энэ санаачилгынхаа хамгийн эхний үндэсний хэмжээнд хэрэгжих төслийн нэгээр бас бид нар гадаад талдаа хөрөнгө оруулагч нартаа тавиад улс орнууд болон хөрөнгө оруулалтын олон улсын банк, санхүүгийн байгууллагууд сонирхоод эхэлсэн байгаа.

Тэгэхээр ирэх жилээс ямар ч байсан ТЭЗҮ байхгүй байсан энэ төслийн экологийн төслийн ТЭЗҮГ нь хийлгэх ажлыг гүйцэтгэнэ гэдэгтээ ажлын албаны зүгээс итгэлтэй байгаа. Байгальд суурилсан шийдлийг ашиглан тогтвортой дэд бүтцийг хөхүүлэн дэмжих гэдэг санаачилгын хувьд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг илүү татах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ялангуяа шугаман дэд бүтцийг байгаль орчинд хор хөнөөл багатай, хохирол багатай, дээрээс нь нөхөн сэргээлтээ дэмждэг байх зарчмыг илүү түлхүү гаргаж тавихаар боловсруулаад байгаа. Тэгээд санаачилгууд маань төсөл, хэлбэрээрээ байгаа. Энэ санаачилгууд бүгдээрээ талуудын 17 дугаар бага хурлыг эхэлсэн үед.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Миний нөгөө хурлын дараах гарах нөгөө үр дагавар дээр бас яг энэ санаачлах болон төсөлтэй холбоотой би асуулт асуусан тээ. Энэ Монгол Улсад хүлээгдэж байгаа яг ямар бодитой энэ төсөл, хөтөлбөр хэрэгжих вэ гэдэг асуулт байгаа байгаа юм. Тэгэхлээр яах вэ нөгөө бэлчээрийн тэргүүлэх санаачилга ч бай энэ гандуу бүсийн тэсвэрлэх чадвар, ус, газрын менежмент гээд энэтэй холбоотойгоор залгуулаад энэ хөдөө орон нутгийг хамарсан нөхцөлд нийгмийн тодорхой хэмжээний бас нийгмийн энэ нөхцөл байдлыг сайжруулах, ард иргэд, орон нутгийн энэ нөхцөл, байдлыг бас адилхан хамтад нь сайжруулах тийм төслүүд хэрэгжих юм болов уу ер нь хүлээгдэж байгаа ямар төсөл, хөтөлбөрүүд байгаа вэ гэдэг дээр хариул авчихъя.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Д.Ариунтуяа: Төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа зөвхөн бэлчээрийн асуудлыг юм уу эсвэл усны нөөцийг хангах, эсвэл хувийн хэвшил, хувийн хэвшлийн оролцоог, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэдэг чиглэлээр нь бид нар боловсруулахгүй байгаа. Аль болохоор давхар үр ашиг бүхий төслүүдийн саналуудыг боловсруулаад ажиллаж байгаа. Нэг жишээ аваад үзэх юм бол Онги-Цагаан бургастайн экологийн төслийг сэргээгдэх эрчим хүч эрчим хүчийг ашиглан газар тариалангийн төслүүдийг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтай, амьжиргаатай байлгах гэдэг асуудлыг бас давхар оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ 3 санаачилгын хүрээнд хэрэгжих төслүүд олон зорилтот давхар үр ашигтай төслүүд байна гэдгийг байлгахаар ажлын албанаас төслийн баримт бичгээ боловсруулж байгаа гэдгийг хэлмээр байна.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Танилцуулсан мэдээлэлд төр, хувийн хэвшлийн түншлэлийг мөн газрын менежментийн чиглэлд говийн эко системийг нөхөн сэргээж усан хангамж болон зохистой менежментийг дэмжих төслүүдийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ гэсэн байна. Үнэхээрийн энэ төслүүд хэрэгжихээр энэ СОР-ын хурлын үр дүн ингэж гарвал үнэхээрийн талархах байна аа. Яг энэ санаачилгын хүрээнд бас та бүхний таны мэдээлэлд, сайдын мэдээлэлд 500 орчим сая долларын төслүүдийг хэрэгжүүлнэ гэсэн урьдчилсан тооцоо байгаа гэжээ. Яг яг ямар ямар төслүүдийг бэлдэж байна вэ? Тэр төслүүдийг хэн, хаана бэлдэж байна вэ? Сая энэ харин хариултад дурдагдаж байх шиг байна тэр Орхон-Онгийн Цагаан бургастайн далангийн асуудал, нөгөө Хэрлэн-Тооно төсөл энэ дээр орж байна уу? Мөн “Эй Ди ...” констракшны шалгарсан нөгөө шинэчилсэн ТЭЗҮ хийх төсөл хэр болж байгаа вэ? Энэ СОР-17-гоос өмнө амжих уу? Тэгээд яг тодорхой төслүүдийг хэн хэн хаана бэлдэж байна вэ, олон улсын стандартаараа бэлдэж байна уу гэдэг асуудал байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрдугаарт нь энэ чинь ерөөсөө 285 хоног гэдэг бол энэ том арга хэмжээнд богинохон хугацаа үлдээд байна. 8 сарын 17-ноос 28-нд билүү? Энэ чинь нөгөө жуулчны peak time юм байна шүү дээ. Тэгээд энэ нөгөө аялал жуулчлалынхаа захиалгатай яаж уялдуулж байгаа вэ? Хувийн хэвшил аялал жуулчлалын салбартаа бас хүндрэл учруулаагүй биз? Энэ дээр хэн хариулах вэ? Тэгээд хамгийн гол нь энэ их том хурал хийгээд бид энэ улс оронд бас үр дүнтэй үлдэх нь чухал. Тэрнээс хурал хийсэн болоод баахан арга хэмжээ болоод үр дүнгүй үлдвэл ямар ч хэрэггүй шүү дээ тийм ээ. Миний 2 асуултад хариулт авчихъя.

Б.Бейсен: 3 номер хариулъя.

Д.Батмөнх: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр бид нар тэр 500 сая доллар гээд байгаа чинь, нэг юмыг бид аягүй сайн ойлгох ёстой. Энэ хурал ганцхан Монгол Улс буюу бид нарт зориулсан бид нар зовлонгоо ярих гэж байгаа хурал бас биш шүү. НҮБ-ын 197 орон болон НҮБ-ын энэ цөлжилттэй тэмцэх конвенцын Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газар бид нар бүгдээрээ нийлээд дэлхий дээр бид нартай адилхан асуудалтай байгаа улсуудыг цуглуулаад хамтарсан маягаар шийдэл гаргах ийм юм байгаа юм. Энэ 500 сая доллар гэдэг маань бид нар урьдчилсан байдлаар тодорхой хэмжээнд яригдчихсан тоо гэсэн үг. Тухайлбал, манай энэ түрүүний COP-16 болсон улс Саудын Араб хамгийн амжилттай зохион байгуулсан хуралд тооцогдож явж байна. Энд 12.1 тэрбум доллар хэмжээний асуудал босгосон, мөн яригдсан.

Тэгэхдээ энэ чинь 5 жил, 10 жилээр хэрэгжих юм. Яг Ганбаатар гишүүний асууж байгаа асуулт яг мөн. Өнөөдөр бид нар усны санаачилга бай аливаа “rangeland” дээр ярихаар бид нарт нөгөө л яриад байдаг “bankable feasibility study” буюу ТЭЗҮ байхгүй баахан санаанууд яваад байгаа. Тэгэхээр бид нар энэ одоо үлдсэн хугацааны 3 том хурал блем, COP-30 дараа нь Панам, Найроби энэ Байгаль орчны ассамблей дээр улсуудтайгаа хамтраад ярихдаа одоо бид нар дээр байгаа төслүүдээ хамгийн эхний ээлжид ТЭЗҮ-гийнхээ мөнгийг ярих хэмжээнд эхлээд ярьж байгаа. Тэр ТЭЗҮ-тэй болсны дараа бид нар энэ санаачилгуудыг чинь бүгдийг нь тэр хурлын үеэрээ зарлах юм. Хурлын үеэрээ зарлахтайгаа зэрэгцээд манай ийм ийм төслүүд ТЭЗҮ-тэй энэ дээр бид нар тийм хэмжээний мөнгө босгоно гэдгээ зарлаад энд хэдэн улс орон нэгдэж орох тэр хэмжээнд нөгөө тодорхой хэмжээний боломжтой хөгжингүй орнууд, том сангууд, олон улсын сангууд болон хөрөнгө оруулалтын банкнууд хамгийн чухал нь өнөөдөр ер нь Европ, Америкт ойрх Дорнодын баян гэр бүлүүдийн сан гэж байгаа. Энэ байгаль орчны салбар руу мөнгө гаргадаг. Энэний мөнгийг нь “manage” хийдэг томоохон дэлхийн компаниуд байгаа. Хөрөнгө оруулалтын сангууд тэд нарт бид нар өөрсдийгөө сайн ойлгуулж чадсанаар энэ төсөл маань цаашаа урагшаа явдаг ийм л зарчимтай юм байна лээ. Бид нар аль болохоор энэ дээр НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газартайгаа олон улсын байгууллагуудтайгаа, тухайн улсын яамнуудтайгаа нийлээд ингээд энийг урагш нь явуулна.

Түрүүн ярьсан НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас ер нь устай холбоотой асуудал дээр нэг зүйл анхаар анхааруулж байгаа юм. Яагаад урьд нь устай холбоотой санаачилгууд гардаггүй байсан бэ гэхээр ус өөрөө улс төр шүү гэдгийг анхааруулж байгаа юм. Тэгэхээр манай нөгөө Хэрлэн-Тооно, Орхон-Онги чинь нэг нь Орос, нэг нь Хятадтай холбоотой улс төр учраас энийгээ анхаараарай гэж анхааруулсан. Тэгэхээр энэ дан ганцхан ажлын хэсэг, Засгийн газрын ажил

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

биш энэ бол бас нэлээн тийм томоохон хэмжээний ажил болж таарах гээд.../минут дуусав./

Б.Бейсен: Үлдэх үр дүнгийн талаар Батбаатар сайд. 4 номер.

Б.Батбаатар: Засгийн газрын хуралд 1 санал оруулахаар бид нар бэлтгэж байгаа. Энэ долоо хоногийнх дээр амжихгүй. Ирэх долоо хоногт оруулахаар ирэх жилийн хичээлийн шинэ жилийг 9 сарын 15 болгох, дээрээс нь Отгонтэнгэрийн тахилгыг энэ COP-17-гийн хурал зохион байгуулагдах үеэр зохион байгуулах хүсэлт тавих тухай. Тэр бол Ерөнхийлөгч зарлиг, Ерөнхийлөгч хугацааг нь товлон учраас аль өдрийг нь яах вэ гээд. Яагаад вэ гэхлээр энд Улаанбаатар хотод арга хэмжээ зохион байгуулагдахад түгжрэл болоод бусад асуудлууд үүснэ. Аялал жуулчлалыг ч гэсэн ингээд орон нутгуудад тараах, иргэдийн зорчих энэ боломжийг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газар тодорхой байр суурийг эрт илэрхийлээд ингээд явсан нь зүйтэй гэж үзэж байна.

Дээрээс нь энэ COP-17-г зохион байгуулахын үр дүн юу юм бэ, Улс орны гадаад нэр хүнд капиталын тухайд та бүхэн ойлгож байгаа. Тогтвортой хугацаан дотор 5 жил, 10 жил, 2 жил, 15 жилийн хугацаатай хөрөнгө оруулалтууд байгаль орчны салбарт орж ирнэ. Өнөөдөр газар нутаг, байгаль орчин, ан амьтан ярихгүй Монгол хүн байхгүй. Бүгдээрээ нөхцөл байдлыг маш сайн ойлгож байгаа. Тэгэхээр энэ чиглэлд нэлээн том ахиц дэвшил гарна. Дээрээс нь COP-17-гийн хурлын үеэр бий болсон санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсөл санаачилгууд бүс нутаг болоод бусад газар дэлхийд хэрэгжих болоход тэрийг манлайлж, удирдаж, хааш нь ямар хэмжээнд яаж хэрэгжүүлэх вэ гээд дараагийн ирэх хугацаанд явах хурлуудад Монгол тал даргална. Нэг ёсондоо НҮБ-ын Ассамблейн конвенцын Ерөнхийлөгчийн ажлыг Монгол тал хүлээж авна гэсэн үг Саудын Арабаас. Тэгэхээр энэ зүйлүүд маань яваад ирнэ гэдгийг бас нэмж хэлье. Ер нь зүгээр яг цэвэр хэд босож ирдэг юм 100 босож ирлээ гэж бодоход тэрний 20, 30 хувь нь ч юм уу, 40 хувь нь ч юм уу Монголд хөрөнгө оруулалт болоод үлдэнэ. 100 гэдгийг би.../минут дуусав./

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Батбаатар сайдын саяын хариулт нь тэгээд 8 сарын 17-ноос 28-ныхаа хооронд тэр хугацаагаа 9 сард хичээл хойшлуулж хойшлуулах гэж байгаа юм уу? Би юм ойлгосонгүй.

2 дахь асуудал нь яг энэ жуулчдын оргил үе юм байна 8 сарын дундуур чинь энэ хувийн хэвслүүд өдийд захиалгаа өгчихсөн байдаг байхгүй юу аялал жуулчлалын салбарынхан. Энийг нь яаж зохицуулах гэж байгаа юм? Эсвэл тэр захиалгуудыг нь цуцлах юм бол компенсаци өгөх юм уу? Энэ чинь яг иймэрхүү юмнууд болно шүү дээ амьдралд. Харахад жоохон деталь юм шиг боловч энэ чинь яг амьдрал дээр ийм юм тохиох байхгүй юу.

Дараагийнх нь асуудал яах вэ тэр улс, улс төр энэ тэр санал л нэг байна л даа. Хэрлэн-Тооно бас хүндрэлтэй юмнууд гарч байгаа. Энэ нөгөө “Монхидро” констракшн нь өнгөрсөн жил Оюу толгойгоос 10 тэрбум 3 сая орчим юу яагаад доллар гаргаад тэр ТЭЗҮ чинь энэ энэ оны 1 дүгээр улиралд бэлэн болох ёстой гэрээгээрээ, одоо 26 оны 1 дүгээр улиралд. Энэ ТЭЗҮ бэлэн болсон уу энэ төслөө танилцуулах уу гэж би асуугаад байгаа байхгүй юу.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. 4 номер.

Б.Батбаатар: Тэр төслийн тухайд төсөл одоохондоо бидэн дээр бэлэн болж ирээгүй байна. Ирсэн үед нь цаг тухай бүрд нь энэ бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ажил нэг талаасаа. COP-17-д харин энийгээ оруулах уу оруулахгүй юу гэдэг нь 2 дахь дараагийн асуудал нь. Тэгэхээр тэр Засгийн газар дээр болоод Улсын Их Хурлын гишүүдэд төсөл, ТЭЗҮ бэлэн болоод ирэхээр танилцуулагдчихна. Тэрэнд бол ирээгүй байгаа зүйлийг хэлэхэд хэцүү байна. 3 номерт микрофон өгье.

Б.Бейсен: 3 номерын микрофон.

Д.Батмөнх: Тэр юу шүү Ганбаатар гишүүн ээ нөгөө 17-28 чинь нөгөө хичээлийн бэлтгэлтэй давхцаж байгаа учраас хичээл сургууль, цэцэрлэг, их дээд сургуулийн хичээл 10-н жил, ерөнхий боловсрол, цэцэрлэгийн эхлэх хугацааг 9 сарын 15 болгоё оо гэдэг хойшлуулъя л гэдэг тийм зүйл, санал оруулах гэж байгаа юм. Тэгэхгүй бол үнэхээр ямар хэмжээнд түгжрэл байгаа билээ гэдгээ харж байгаа.

2 дугаарт бид нар зочид буудлаа сонгохдоо Цэцэрлэгт хүрээлэнгийн 5км-ийн радиус дотор сонгож байгаа. Энэ чинь нөгөө shuttle bus-ууд, автобуснууд явна. Ингээд тийм учраас бид нар бас маршрутаа тооцоолоод энэ дээр Зам, тээврийн яамны Төрийн нарийн ахлуулсан дэд хороо болон нийслэл ажиллаж байгаа.

3 дугаарт нь зочид буудлуудын хувьд үнэхээр хамгийн их санаа зовж байсан, миний хувьд ажлын албаны дарга байгаад хамгийн санаа зовж байсан хүн нь тэр зочид буу буудлын асуудал байсан. Зочид буудлуудын нэгдсэн холбоо гэж байдаг юм байна лээ. Зочид буудлуудын холбоо манай ажлын алба, Соёл, спорт, аялал жуулчлалын яам бид нар гуравласан гэрээ хийгээд 3 сарын 31 хүртэл зочид буудлууд 70 хүртэлх хувиа блоклож байгаа. Тэр дээр нь бид нар одоо энэ оны төсөв дээр байгаа мөнгөнөөсөө анх 4, 5 тэрбум гээд байсан бид нар ингээд ярилцаад 6, 700 орчим сая төгрөг өгөөд блоклоод тэгж буцаад ороод ирнэ гэсэн үг шүү дээ. Тэр чинь угаасаа хүмүүсийн нь төлөхөөр. Энэ ингээд 3 сарын 31 хүртэл зочид буудлуудаа бид нар блоклож юм. 5 мянга орчим ор гэж ойлгож байгаа. Тэгээд дээрээс нь нэмээд Airbnb буудлууд, service house-ууд байна, guest house-ууд байна, дээрээс нь apartment-үүд байна эд нар ингээд бүгдээрээ сонголттойгоор орно гэсэн үг. Тэр веб сайт дээр Монголын COP-17-д Улаанбаатар хот очиход ийм ийм сонголт байна. 5 одтой буудал нь ийм байх юм байна гээд. Яагаад тэрийг блоклуулж байгаа вэ гэхээр үнийг нь битгий замбараагүй нэмчхээсэй гэсэндээ блоклуулж байгаа. Жишээлбэл, COP30 дээр Бразилд оролцогчдынх нь тоо нэмэгдсэнээс болоод буудлын үнэ хоногийн 1000 доллар болчихоод байгаа юм. Тэгэхээр ийм асуудал битгий гаргаарай гэдэг зүйл НҮБ-аас анхааруулсан.

Б.Бейсен: Одонтуяа гишүүн асуулт асууя.

С.Одонтуяа: 3 асуулт байна аа. Энэ Үндэсний хорооны төлөвлөгөөний биелэлт ер нь хэдэн хувьтай байгаа бол? Сая нөгөө НҮБ-ын конвенцынхонтой ийм ирээд ер нь эд нартай хамтарсан төлөвлөгөө хийх гэж байгаа юу энэ талаар ийм төлөвлөгөө ер нь гарсан уу гэдэг асуудал.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрт дэд хороод ер нь хэр ажиллаж байна аа? Би зүгээр Үндэсний хороо ажиллаад байгаа, дэд хороодууд тийм идэвхгүй л ажиллаад байх шиг байгаа юм. Тэгэхээр Улсын Их Хурлаас бид нар Засгийн газраас энэ дэд хороодыг маш идэвхтэй ажиллуулах тал дээр анхаарах ёстой юм биш үү гэсэн ийм санал байна. Олон улсын менежментийн зөвлөх үйлчилгээ авах гэж байгаа юу? Ер нь яах вэ ихэнх СОР-ууд авдаг юм байна лээ. Зөвхөн барилга байгууламж гэхээс илүү бас тэр хурлын бүх үйл ажиллагааг зохицуулах ийм зөвлөх үйлчилгээ авах гэж байгаа юу гэдгийг асууя.

Тэр байршлын хувьд Бат-Эрдэнэ гишүүнд би бас хэлье. Энэ анх Мишээл экспог нэлээн сонгож байсан юм байна лээ. Тэгээд Мишээл экспог их олон улсын ийм convention төв хийх гэж байгаа юм байна. Зочид буудал хийх гэж байгаа юм байна эхлээд сонгоод. Гэтэл энэ олон улсын convention төв нь санхүүжилтгүй учраас зогсчихсон, зочид буудлууд нь болиод айлын орон сууц болгоод айлуудад зараад захиалгаа аваад эхэлчихсэн гэсэн ийм хариуг өгсөн учраас Мишээл ерөөсөө болохгүй юм байна гээд орхисон. Ингээд бүх аюулгүй байдлаа бодоод ер нь ихэнх СОР-ууд хотоос гадна ийм том байгууламж барьж бүх юмаа нэг дор хийдэг учраас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэсэн ийм шийдвэр гарсан. Энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр бүгд хэлэлцэгдэж, яригдаж дэмжигдсэн байгаа. Усны юунд ямар ч хамаагүй юм байна лээ ундаргын тэр юунд. Гол нь тэр худгийн хамгаалалтын бүсүүд нь муудчихсан, хашаа нь муудчихсан байсныг бүгдийг СОР-ийн энэ зардлаар сольж байгаа гэж би ойлгосон. Ингээд 50 метрийн радиустай байсныг 100 метр болгож байгаа юм билээ.

Ер нь энэ сая бол Саудын Араб энэ СОР-ийг хийгээд тэрнээс хойш Саудын Араб бол маш олон том том арга хэмжээг хийгээд байна шүү дээ. Ийм зоригтой арга хэмжээнүүдийг хийж эхэлсэн гэсэн үг. Тэгэхээр нэг ёсондоо Монгол улс бид энэ “Go Mongolia” гээд л их олон бас мөнгө зардаг. Тэгэхээр энд нэг мөр ингээд л 5-10 мянган хүн пар гэж ирээд л бүгд зочид буудалд буугаад л хоол идээд л ингэхэд уг нь хувийн хэвшилд асар их ач холбогдолтой юм билээ. Гагцхүү бид энэ төр байгууламжаа барих асуудлууд байгаа. Тэгэхээр би зүгээр Батбаатар сайдад юу гэж зөвлөх гэсэн юм бэ гэхээр энэ түр байгууламжаа Нийслэлийн онцгой байдлын газар, Онцгой байдлын ерөнхий газартай яриад эртхэн ер.../минут дуусав./

Б.Бейсен: Одонтуяа гишүүнд 1 минут.

С.Одонтуяа: Онцгой байдлын ерөнхий газартай яриад манай гамшгийн ийм том төв байдаггүй. Одоо бид нар чинь ийм гамшгийн сургалт гээд тэгэхэд юу ч байдаггүй Монголд. Тэгэхээр ямар нэгэн ийм осол, гамшиг гарахад бид нар тэнд ингээд бүх юм нь бэлэн байж байдаг, тэр асрууд нь хураалттай газар хадгалагдсан, номерлогдчихсон энд эмнэлэг нь байна энд юу нь байна ч гэдэг юм уу ингээд оффис нь байна гээд ийм гамшгийн том төв болгоод сургуулилтаа 1 хийж аваад энийгээ хадгалах тийм юм эртнээс ярьж байвал зардал их буурна гэж үзэх гээд байгаа юм.

Дээрээс нь энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд нэлээд хөрөнгө оруулалт оруулж байгаа юм байна лээ тээ? Тэр бохирын асуудал, усны асуудал, цахилгааны. Тэгэхээр энийгээ тэр СОР-ийн зардлаас нь хасаад Цэцэрлэгт хүрээлэн рүүгээ үндсэн хөрөнгө рүү нь өгөөд хасахгүй бол сүүлд тайлан гаргасан

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чинь л COP дээр баахан зардал гарчихсан. Бид нар чинь бол 1 сумаар 2 туулай буудаж бас тэр Цэцэрлэгт хүрээлэнг чинь тохижуулж өгч амь оруулах гээд байгаа бас.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Одноо гишүүн, Одонтуяа гишүүн бас сайн ойлгож байгаа. Дэд хороод бас бүрэн гүйцэд ажиллаж өгөхгүй байсан. Одоо харьцангуй эрчимжиж байгаа. Дэд хороодын дарга нар долоо хоногт хагас сайн өдөр болгон Бямба гараг бүрд Үндэсний хорооны ажлын албатай нийлж хуралддаг. Энэ механизм руу шилжиж орсон. Ажлууд нь харьцангуй эмх цэгцдээ ороод эхэлсэн гэж ойлгож болно.

Ер нь тэр COP-17 зохион байгуулагдахад баригдсан барилга байгууламжуудыг яах вэ гэдэг дээр янз бүрийн саналууд явж байгаа. Бидэнд бас гашуун туршлага байгаа. Хурал зохион байгуулагдсаны дараа орж ирсэн тоног төхөөрөмж, байшин барилга, машин тэрэг хаашаа алга болсон бэ гэдэг гаднын хандив, тусламжаар ирсэн зүйл хаашаа алга болсон бэ гэдэг зүйл байнга яригдаж байдаг. Энийг нээлттэй хэлэлцэж байгаад нэг бол аймгуудын Засаг дарга нар, нэг бол Онцгой байдал, нэг бол Хархорин гээд ингээд янз бүрийн хувилбарууд яригдаж байгаа. Энэ хувилбаруудыг ярилцаж байгаад Засгийн газрын хурал руу оруулаад алийг нь аль руу нь шилжүүлбэл зөв бэ гэдэг талаас нь шийдвэр гаргаад нээлттэй, ил тод явж байх нь зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа. Мэдээж энэ дээр сайн “идея” хэлж байвал бас бүгдэд талархана. Энэ асрууд тийшээ очвол хамгийн зөв шүү гэдэг зүйлийг хэлж байгаа хүн болгонд бас талархаж хүлээж авна гэж хэлмээр байна.

Б.Бейсен: 3 номер.

Д.Батмөнх: Одоо менежментийн компани гэж бид нар авъя гэвэл хөх бүс дээр л авна. COP16 хүртэл ногоон бүс гэж байгаагүй юм байна лээ. Дандаа зөвхөн НҮБ-ын “blue zone” буюу хөх бүсээс. Саудын Араб бид нар нэгэнт ийм их хэмжээний хөрөнгө зараад хурал хийж байгаа, олон хүн ирж байгаа юм чинь бид улсаа сурталчилмаар байна гээд ногоон бүс гэж гаргаж ирсэн юм байна лээ. Тэгэхээр бид нар ч гэсэн бас ийм зарчим байдаг юм байна. Энэ чинь түрүүний явсан COP-ийнхоо санаачилгыг бас дэмжээд явах ёстой гээд. Тэр үүднээс бид нар ногоон бүсээ төлөвлөөд явж байгаа. Ногоон бүсийг Монголын компаниуд маань хийх байх гэж бодож байгаа. Тэнд бид айхтар оролцох зүйл байхгүй. Энэ дээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон манай ажлын алба ингээд хамтраад явж байгаа. Ногоон бүсийг Монголын компаниуд аваад явах нь зөв. Тэр нь илүү их Монгол Улсыг сурталчлах яах вэ Риад дээр явсан ногоон зооны, ногоон бүсийн 1 алдаа нь хэтэрхий их нөгөө технологиор балбачихсан юм байсан учраас тэрийг их хүмүүс сонирхохгүй байна гэсэн.

Тэгэхээр болбол бид нар илүү уламжлал руугаа чиглэсэн маягийн юм хийх байх. Энийг event зохион байгуулж чаддаг компаниуд нь хийсэн нь дээр байх. Бид тэнд нээх айхтар. Хөх бүсийн хувьд “orientation event” гээд энэ бүх уур амьсгалын бүх COP-ийг зохион байгуулж байгаа ч одоо ч “blaming management”-ийг нь хийж байгаа компани байгаа юм. Тэд нар орлого хуваах зарчмаар мөнгө авахгүйгээр ажиллая гэж байгаа юм. Гэтэл “Юу Эс Си Си Ти” болохоор GL events-ийг та нар авах нь илүү оновчтой гэж зөвлөөд байгаа. Ер нь бидэнд энэ ойрын үед гаргах

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ёстой шийдвэр Үндэсний хороо болон Засгийн газар дээр тулгамдаад байгаа асуудал энэ л байгаа. Энийг тэгэхдээ бид энэ 11 сардаа багтаж шийдэхгүй бол байгууламжийн маань асуудал ч хойшоо сунжрах тийм нөхцөл байдалтай байгаа.

Б.Бейсен: Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ингээд COP-17-гийн бэлтгэл ажлын хүрээнд бас олон ажлууд хийгдэж байгаа талаар мэдээлэл, тайлан хүргэлээ. Энэ дундаас мэдээж нэг том хэсэг нь аж ахуйн шинж чанартай ажлууд байгаа. Барилга байгууламж, төсөв, хөрөнгө ингээд л бүсчилсэн ногоон zone, цэнхэр zone гэх мэтчилэн. Миний асуух асуулт яг энэнтэй холбоотой бодлогын шинж чанартай асуудлууд дээр асуулт асууя гэж бодож байна. Одоо энэ хамгийн чухал зүйлийн дунд бол Монгол Улсад ямар өгөөж ирэх вэ? Мөн Монгол Улс дэлхийд энэ тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн чиглэлээр ямар манлайлал үзүүлж ажиллаж чадах вэ гэдэг ийм 2 зүйл дээр ирж байна л даа. Эхний зүйл болох Монгол Улсад хамгийн багадаа 500 сая ам.доллар бүхий төслүүдийг хэрэгжүүлнэ гэсэн энэ тооцооллын дэлгэрэнгүйг авъя гэж бодож байна. Энэ дээр бас хүлээлтийг зөв удирдахгүй бол хэдий хэмжээний зардал гаргаж байгааг бид ярьж байгаа. Олон нийт байтугай ер нь ордон дотор COP гэдэг энэ хурлын бэлтгэл ажлыг нүд үзүүрлэж байгаа. Энэ чинь нэл зардал юм биш үү. Энэ мөнгө орно гэж яриад байгаа. Тоо яриад байгаа боловч яг энэ хэрхэн бодит вэ гэдэг дээр олон хүмүүс асууж байгаа, асуух нь ч зүйтэй. Тэгэхээр энэ 500 саяынхаа тооцоог яг бодитоор гаргаад хүлээлтээ зөв удирдаасай гэж би хүсэж байгаа. Яг ийм боломжтой энэ дотор энэ маш бодитойгоор хэрэгжихээр хийгдээд эхэлчихсэн, эсвэл зүгээр агаарын тоо яриад байгаа юм уу гэдэг энэ эхний асуудал.

2 дахь асуудал нь энэ бодлогын манлайлал дээр бид олон улсдаа яг ямар зүйл хийх гэж байгаа вэ? 2026 оныг НҮБ-аас “International Year of Rangelands” буюу бэлчээрийн газар нутгийн жил болгон зарласан байгаа. Тэгэхээр энэ дээр бид ямархуу бодлогын манлайлал үзүүлэх гэж байгаа вэ гэдгийг би одоо асууя. Яагаад гэхээр бид олон улсын манлайлал үзүүлэхээсээ өмнө бас энэ улсынхаа хэмжээнд ч гэсэн энэ дээр хийгдэх ёстой хэдэн ажлууд байгаа. Тэрийгээ бас яарч шахаж хийх нь энэ Байнгын хорооны ч гэсэн ажил болов уу гэж хараад байгаа юм. Онцгойлж хэлэх юм бол Бэлчээрийн тухай хуулийн асуудал маш олон жил гацаж ирсэн. Бид ирэх жил олон улсад манлайлна гээд байдаг. Энэ дээрээ дотооддоо яг ямар ажил хийж байгаа вэ? Энэ мэдээж зөвхөн танай Байгаль орчны яам биш Хүнс, хөдөө аж ахуйн яамтай ч гэсэн холбоотой эдгээр асуудлууд дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа вэ? Энэ мөнгө босгоно гээд байгаа суурь зүйл нь мэдээж карбон кредит буюу энэ ногоон санхүүжилтийн суурь болох энэ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг хэзээ оруулж ирэх вэ? Миний мэдэхийн өмнөх Засгийн ийн газрын үед бүрэн бэлдсэн байсан бас би түүнд нь ч орж байсан яг энийг хэзээ өргөн барих вэ гэдгийг тодорхойлж асууя.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. 4 номер.

Б.Батбаатар: 500 сая доллар гээд тэр 3 санаачилгын зөвхөн 1 нь шүү. Бүтнээрээ биш бэлчээрийн тэргүүлэх санаачилгын хүрээнд багтаж байгаа санаачилгуудад төсөл, хөтөлбөрт 500 сая долларын хөрөнгө оруулалт татна гэсэн. Нэг ёсондоо эргэж төлөх биш энэ байгаль орчин энэ чиглэлд зарцуулагдана гэж ингэж ойлгох хэрэгтэй. Тэгээд энэ 500 саяг яаж ямар яг тэр задаргаа танилцуулга гээд байгаа зүйлийг ажлын албанаас гишүүнд явуулъя аа. Тэгэхгүй ингээд

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

задлаад тавихаар баахан зүйл гаргаж тавих хэрэг гарч байна. Мөн өөр бусад гишүүдээс бас энийг сонирхож байгаа хүмүүс байвал бүгдэд нь явуулжээ. Байгаль орчны байнгын хороон даргад явуулахаар ингээд гишүүдэд мэдээллийг хүргэчих байх гэж бодож байна.

Бодлогын асуудлаар манлайлах, 2026 оноос 2028 он хүртэл 197 улс нэгдсэн цөлжилтийн эсрэг конвенцын Ерөнхийлөгчөөр Монгол Улс даргалж ажиллана. Энэ хугацаанд жилд 11 орчим ийм олон улсын хурлууд, байгаль орчны салбарын хурлууд болдог. Төсөл, хөтөлбөр, хөрөнгө санхүүжилт, байгаль орчин энэ жилд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт энэ чиглэлүүдэд ямар зүйлүүд хийх вэ гээд ингээд ярихад тэрийг удирдаж байдаг нь Монгол хүн сууж байна гэсэн үг. Энэ улс төр болон олон улсын манлайлал талдаа маш том үр өгөөж түүгээр дамжиж гарч ирнэ гэдэгт би бүрэн дүүрэн итгэлтэй байна.

Нөгөө талдаа COP-17-г зохион байгуулж байна гэдэг чинь дэлхийн 197 улс нэгдсэн боловч 197 улс нэгдсэн байхад тэндээс 17-г нь Монгол Улс авч чадаж байна гэдэг чинь бас нэг манлайллын нөгөө харагдаж байгаа хэлбэр. Олон улсын манлайлал болоод бүс нутагт бид нарын нөлөөлөх нөлөөлөл өснө өө гэсэн ийм санаа. Дээрээс нь энэ конвенцыг даргалж байгаа хугацаан дотор НҮБ-ын чуулган Ассамблейд асуудлууд оруулах, олон талт хамтын ажиллагаа өргөжүүлэх энэ асуудлууд яваад ирэхээр бид нарыг хөрш зэргэлдээ улс орнууд болон хөгжилтэй улсууд Монгол Улсад энэ байгаль орчны чиглэл гэхээр биологийн олон янз, ингээд олон янзын ургамал төрөл зүйл тусгай хамгаалалттай газар нутаг ч гэдэг юм уу энэ зүйлүүд дээр бас нэмэлт давуу боломжууд бий болно оо гэсэн ийм манлайллууд бий болж чадна.

Ер нь миний тавьж байгаа зорилго бол нөгөө зарим зүйлийг өндөр хүлээлт үүсгээд, үгүй бол зарим зүйлийг танайх та өөрөө Улсын Их Хурал дээрээ ингээд хэлчихсэн байна шүү дээ гэдэг байдлаар боломжит зүйлээ үгүйсгэх эрсдэл байгаа учраас зарим зүйлийг гүйцэд бас хэлэлгүй хамгийн доод бага дүн гэдгээр аваад явж байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна.

Б.Бейсен: 4 номер Батбаатар сайд.

Б.Батбаатар: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль явсан, тодорхой хэмжээнд ажилласан. Засаг руу орох гэж үзээд бас болж өгөөгүй асуудлууд байгаа. Гэхдээ бид нар ажлын хэсгээ дахин өөрчлөөд Эдийн засаг, хөгжлийн Учрал сайд, Сангийн сайд Жавхлан сайд тэгээд миний бие хамтраад ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг нь хуралдаад, үр дүнгээ гаргаад одоо Засгийн хурлаар оруулж Их Хуралд өргөн барихад бэлэн болгочихсон. Одоо бол Эдийн засгийн хөгжлийн яам болон Сангийн яаман дээр үүн дээр ямар гацаагүй болсон гэж ойлгож болно. Бэлэн болчихсон өргөн барих. Бэлчээрийн тухай хууль байхгүй. Тэр Бэлчээрийн жил болоход зарласантай холбоотой асуудал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр байгаа. 11 сард Засгийн газарт оруулж танилцуулна гэсэн чиглэлтэй байгаа юм байна лээ.

Б.Бейсен: Болормаа гишүүнд тодруулъя.

Б.Болормаа: Мэдээж Монгол Улс COP-17-г ахална гэдэг бол тодорхой хэмжээний олон улсад манлайлал үзүүлж байгаа гэдгийг үгүйсгэхгүй ээ. Хурал удирдаад явах нь нэг төрлийн манлайлал мөн. Гэхдээ энэ дээр илүү их зоригтой

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

реформын шинж чанартай юм яриасай гэж би хүсээд байгаа юм. Би өөрөө яг энэ салбарын хүн болохоор ч тэр юм уу чин сэтгэлээсээ Монгол Улсын цаашдын хөгжил өөрөө ногоон байгаасай, ногоон байх бүрэн боломжтой гэж итгэдэг учраас бид энэ хурлыг ашиглаад бас үнэхээр томоохон өөрчлөлтүүдийг оруулаасай л гэж хүсээд байгаа юм л даа. Яг үнэндээ бид нар явдаг процедураар нөгөө Сангийн яамаа хүлээгээд л, Эдийн засгийн хөгжлийн яамаа хүлээгээд л байх юм бол дандаа л нөгөө бор чиглэлийн хөгжлийн асуудлууд яригдана. Тэгэхээр энэ COP-оо ашиглаад үнэхээр Монгол Улсынхаа ч гэсэн хөгжлийн зүг чигийг тэр чигээр нь ногоон болгох зоригтой бодлогын өөрчлөлтүүдийг манлайлж хийгээч гэж танд захиж хэлье ээ.

Б.Бейсен: Болормаа гишүүн үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбоотой үг хэлэх гишүүд байна уу?

Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Батбаатар сайд харин богино хугацаанд ажлаа сайн ойлгочихсон байгаа юм аа. Ногоон намын дарга гэдэг чинь бас Ногоон намын дарга л байдаг юм шиг байна. Тэгээд ер нь яах вэ зүгээр бид нар Улсын Их Хурал ялангуяа Байнгын хороо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам COP-той холбоотой яамнууд энэ үйл ажиллагааг бид нар зайлшгүй дэмжиж ажиллах шаардлагатай байгаа. Тэгэхгүй бол энэ бол зөвхөн яамнуудыг хариуцаад явах ёстой үүрэгт ажил биш гэдгийг нэгдүгээрт хэлмээр байна. Батбаатар сайд энэ Засгийн газар болон Үндэсний хорооноос томилогдсон тусгай элч нарыгаа хэрхэн ашиглах вэ, энэ хүмүүсээрээ дамжуулж тодорхой хэмжээнд Улсын Их Хурлын гишүүдээ бас хэрхэн ашиглах вэ гэдгээ сайн бодоод энэ хүмүүсээ бас ашиглаасай гэж хүсэж байна. Яагаад гэхлээр энэ чиглэл дээр туршлагатай хүмүүс байгаад байгаа учраас энэ хүмүүсээ бас хий дэмий зүгээр тусгай элч гэдэг автор өгөөд орхимооргүй байгаа юм аа. Монгол Улсад ямар төсөвт хөтөлбөр үлдэх вэ л гэдэг асуудал. Үйл ажиллагааг бид нар яаж ийж байгаад хийчихнэ. Асуудал байхгүй хийнэ, ард нь гарна. Энэ дээр Монгол Улс нэр хүнд унаад, асуудал үүсээд байх юм байхгүй гэж би бодож байгаа. Харин ч тодорхой жишиг тогтоосон сайн үйл ажиллагааг COP-17 буюу талуудын Бага хурал дээр хийж дэлхий нийтэд таниулж Монгол Улсаа сурталчилж чадах байх гэж найдаж байгаа. Бүрэн итгэлтэй байгаа.

Энэ төсөл, хөтөлбөрүүдээ яг ний нуугүй эсвэл тодорхой хэмжээнд Улсын Их Хурлын гишүүд, зарим гишүүдийг яаман дээр юм урьж байгаад яг нарийн мэдээллүүд өгмөөр байна аа. Тэгэхгүй болохоор та бас нөгөө дэлгэрэнгүй ярьж болохгүй байна. Тэгээд амлачихаар тэгэхгүй байна гээд ингээд явсаар байтал үйл ажиллагаа маань хэр байгаа билээ, олон улсын стандартад тухайн төсөл, хөтөлбөрүүд нийцэж байгаа юу үгүй юу гэдгээс чинь авхуулаад л олон асуудлууд яригдана. Тэгэхээр бид нар энэ дээр нарийн мэдээллүүдийг бол ний нуугүй хэлэхэд авмаар байна. Зөвхөн 2026 оны 8 сарын 17-ноос 28-ны хооронд энэ үйл ажиллагаа яваад дуусахгүй. 2026-аас 28 оны дараагийн COP18 хүртэл бид нар 2 жилийн хугацаанд жилийн хугацаанд юу хийх ёстой юм бэ, ямар уриатай орох юм, ямар агуулгаар хийх юм, энэ агуулга маань 2 жилийн хугацаанд хэрхэн үргэлжлэх юм? Эхний алхам. Цаашлаад бид нарын гаргасан ялангуяа бэлчээр дээр явж байгаа энэ санаачилга маань хэдэн COP дамжиж хэрэгжих бүрэн боломжтой юм

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бэ гэдгээ бид нар нөгөө талдаа мэргэшсэн мэргэжилтэн боловсон хүчинтэйгээ яриад улс төрийнх нь хувьд ч тэр, төрийнх нь хувьд ч тэр, концепцынх нь хувьд ч тэр бид нар бол ярих ёстой зүйл байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Улс бол улс төржсөн сэдэв гэдэгтэй санал нэг байна.

Гэхдээ улс төржих тусмаа бид нар энэ усны асуудлыг бол шийдвэрлэх боломжтой ийм төсөл байхгүй юу. Тэгээд энийг бол бид нар хамтдаа хийгээд явъя гэдэг саналыг дэвшүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг яаралтай эцэслээд өргөн бариад Зөвшөөрлийн тухай хуульдаа яаралтай нэмэлт, өөрчлөлтүүдээ оруулахгүй бол саяын Сингапур улстай байгуулсан, дараагийн улсуудтай байгуулах энэ хүлэмжийн хийн зах зээлтэй холбоотой карбон марктай холбоотой олон ажлууд гацна. Энэ явахгүй. Яагаад гэвэл зөвшөөрөл олгогдохгүй. Манай Зөвшөөрлийн тухай хуулиар заагдсан ямарваа нэг зүйл, заалт байхгүй байхгүй юу. Тэгэхээр бид нар олон улсад гарах гэж байгаа бол бүрэн эрхийг нь нээж өгөх хэрэгтэй. Бүрэн эрхийг нээхийн тулд бид нар Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулчих. Тэгэхээр Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг Эдийн засгийн хөгжлийн яам өргөн бариа явна гэж ойлгосон. Энэ дээр бас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам маань шахаж дэмжиж ажиллаасай. Бид нар ч бас шахъя, дэмжье. Зөвшөөрлийн тухай хууль дээр ямар зүйл, заалтууд оруулах вэ гэдэг дагалдах хуулиудтай холбоотой асуудлуудыг бас эртхэн шиг авч үзээд шийдвэрлээд явах нь бол зөв болов уу гэж бодож байгаа.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн бол зөвхөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэн биш шүү. Энэ Улаанбаатар хотын 1.7 орчим сая хүн, дээрээс нь байнгын ирж, очиж байгаа гээд 2 сая гаруй хүний цэвэр усны нөөцтэй холбоотой асуудал шүү. Тэгээд энийгээ их сайн бодох ёстой. Миний үед ч гэсэн энийг ашиглая гэж НҮБ-ээс санал тавьсан юм. Тэгээд бид нар татгалзсан юм. Уучлаарай энэ бол цэвэр усны нөөц учраас болохгүй. Баас, шээсээ ингээд цэвэр усны нөөц дээр аваачиж илүү дутуу стандартын бус асуудал үүсгээд цэвэр усны нөөцөө бохирдуулчихвал бид нар цааш цаашдын үр дагавар нь маш хортой. Тэгээд энийг бас бодож шийдэх ёстой гэдэг алхмуудыг бид нар хийж байсан шүү гэдгийг бас хэлмээр байна. Баярлалаа.

Б.Бейсен: Болормаа гишүүн үг хэлье.

Э.Болормаа: Ингээд бид нар олон нийтэд энэ COP гэдэг зүйлээ аягүй зөв бодитоор танилцуулах ёстой гэж би бодоод байгаа юм. НҮБ-ын байгаль орчинтой холбоотой 3 COP-ийн нэг болох Цөлжилт болон газрын доройтолтой тэмцэх гэсэн COP-ийн хурлыг манай Монгол Улсад хийх гэж байгаа. Энэ боломжийг ашиглаад цаашдаа Монгол Улс маань хэрхэн газрын доройтолгүй, өнөөдөр манай бэлчээрийн мал аж ахуй дээр суурилсан улс орны маань цаашдын хөгжлийн чиг хандлага хэрхэн ногоон байгаль орчинд ээлтэй байх вэ гэдэг ийм бүүр цогц реформын шинж чанартай юм хийх боломж оо гэж би энэ хурлыг харж байгаа. Тэрнээс биш Монгол Улс зүгээр сайхан олон улсын хурал хийгээд өнгөрөх биш Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг эргүүлэх тийм боломж юм болов уу гэж хүн болгон хараасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Энэ хурлын зохион байгуулах ажил өөрөө бодлогын ажлын нэг том хэсэг байна. Мэдээж аж ахуйн ажил байгаа.

Тэгээд аж ахуйн ажилдаа сатаараад хаана барилга барих вэ, түр байгууламж уу юу гэдэг эндээс сатаараад хамгийн гол энэ бодлогын ажлаа битгий мартаасай гэж энэ бүх энэ дээр ажиллаж байгаа хүмүүсээсээ чин сэтгэлээсээ хүсмээр байгаа юм. Энэ маань л эргээд бид нарын энийг хийж байгаа

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гол зорилго. Тэрнээс биш бид нар зөвхөн сайхан харагдах гэж биш олон улсын хүмүүсийг Монголдоо авчраад үзүүлээд, харуулаад, гоё гоё юм яриад тойрч суугаад бүгдээрээ мундаг байна шүү гэхээсээ илүүтэйгээр Монголдоо үлдэх төсөл, хөтөлбөр тэрнээс илүү чухал Монголын хөгжлийн чиг хандлагыг өөрчлөх ийм боломж оо гэж харж байгаа. Энэ бодлогын юман дээрээ онцгойлж анхаараарай. Энэ маань хаягдаад байгаа юм шиг харагдаж байна шүү. Өнөөдрийн танилцуулга дээр ч гэсэн 4 хэсэг юм ярихдаа бодлогын юм гэдэг дээр маш бага агуулга явж байна. Тэгэхээр энийг бүгдээрээ анхаараарай гэж хэлмээр байгаа юм.

2 дахь энэ аж ахуйн юман дээр ч гэсэн аж ахуй дээр ажиллаж сурсан хүмүүс туршлагатай ч гэсэн энэ ямар хурлын аж ахуй вэ гэдгийг бас аягүй сайн анхаарах ёстой шүү. Бүх юм нь өөрөө ногоон байх ёстой гэдэг дээр аль болох энэ боломжуудыг эрэлхийлэх ёстой. Тэрнээс биш бид нарын өмнөх яг л юм хийдэг зарчмаараа ингээд л нөгөө байдгаараа статусгүй хадгалаад байх биш наад захын энэ хурлын бүх юм дахин боловсруулсан rescue цаасан дээр байх юм уу, барилга байгууламж чинь өөрөө усаа дахиж ашиглах юм уу, барилга байгууламж нь өөрөө ногоон эрчим хүчээр хангагдах юм уу гэх мэтчилэн энэ хурлын өөрөө бүх уур амьсгал нь гэх юм уу даа хурлын бэлтгэл ажил өөрөө ногоон байхаас эхэлнэ шүү. Тэрнээс биш нөгөө аж ахуй мэддэг хүмүүс гээд би энийг бас онцолж нийслэлийнхэндээ хэлэх гээд байна л даа. Ингээд ажил явуулаад л аж ахуй мэддэг гээд тэндээ орхилгүйгээр тэр аж ахуйн ажил өөрөө ногоон байх ёстой шүү гэдгийг хүртэл та бүхэн анхнаасаа анхаараарай гэж хүсмээр байна.

Үүгээрээ дамжуулаад манай Монголын аж ахуйн нэгжүүд бас үүн дээр маш их манлайлал үзүүлж байгаа шүү дээ. Бас аягүй сайн эко, ногоон чиглэлийн аж ахуйн нэгжүүд байгаа. Түүнийгээ оролцуулж, тэднийгээ сонсож энийгээ хийх нь бас эргээд тэд нарыгаа ч гэсэн дэмжиж байгаа нөгөө бодлогын сэдэвтэй энэ манлайлал юм шүү. Тэгж байж бид цаашдаа энэ хурлын ачаар цаашдаа манай ер нь төрийн худалдан авалт яагаад ногоон байж болохгүй гэж, ногоон байхад ямар саад учраад байгаа юм, ийм байхын тулд нэмэлт зардал хэдий хэмжээ гарах юм, тэгвэл тэрийг бид нар яаж бусад зах зээлээр, ногоон зах зээлээр олох гэх мэтчилэн энэ бүгдийг цогцоор нь бодоосой гэж та бүхэндээ.../минут дуусав./

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дуусаж байна. Нэгэнт COP-17-г хийнэ гээд манайх үүрэг авчихсан байгаа. Нэгэнт товлогдсон хурал болох нь болно. Тийм учраас бүх яамд, бусад газар холбогдох Үндэсний хороо, дэд хороодууд хариуцлагатай ажиллах шаардлагатай байгаа. Монгол Улсын Их Хурлын COP-той холбоотой төсвийг аль болохоор хасахгүй байхаар анхаарч байгаа. Сая бүх ажил сайн юм шиг ярьж байна энэ бэлтгэл ажил муу байгаа шүү ер нь. Сайд, яамныхан гүйгээд байна. Тэгэхдээ энийг Засгийн газрын түвшинд, Их Хурлын түвшинд болох асуудал дээр бид нар бас чиглэл өгөөд тогтоол гаргая.

Монгол Улс энэ хуралд ямар уриатай оролцох юм, ямар бодлого, чиглэл барих юм энийг маш тодорхой болгох хэрэгтэй. Бэлтгэл ажил дээр нэлээн сайн анхаарах шаардлагатай байгаа. Байнгын хороо энд бүх чиглэлээрээ туслахад бэлэн байгаа. Манай Байнгын хорооны гишүүдийг бас анхаарч ажиллаарай. Бас хувийн хэвшлийнхэн бас энд оролцож байгаа юм байна. Түрүүн энэ Залаатын аманд энэ МАК-ынхан бас өндөр, дээд түвшний хүлээн авалт буудлын асуудлыг бид нар шийдэж байгаа гэж ярьж байна. Би бас очоод танилцсан.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гэтэл тэрний нөгөө энэ өндөр барилга, буудал барьж байгаа юм байна шүү дээ. Энэний зөвшөөрлийг нь Барилгын хөгжлийн төвийнхөн олгохгүй байгаа юм байна. Энэ асуудал дээр Батбаатар сайд бас анхаарахгүй бол тэр үнэхээр бас өндөр, дээд түвшний хүлээн авалтын асуудлууд дээр нэлээн хамтарч ажиллана гээд тийм хувийн хэвшлийнхэн ч бас оролцох тийм төлөвлөгөөтэй байгаа юм байна. Тийм учраас энэ дээр нэлээн хамгаалалтын асуудлууд байж байна. Энэ дээр нэлээн анхаараад нөгөө талаар бид сая Их Хурлын даргатай Казакстан явсан, Ерөнхийлөгчтэй Киргиз, Тажик явахад тэр улсууд урилгаа эрт явуулаад бид нар төсөв дээр чинь бас юмаа тусгах ёстой гэдэг асуудал ярьсан. Би бас сайдад бас дамжуулаад хэлсэн. Энэ талаар бас анхаарч ажиллаад бэлтгэл ажил дээр нэлээн анхаараад хөрөнгө босгох асуудал байж байна. Энийг эртхэн шиг шийдэхгүй бол бас болохгүй асуудал байж байна. Тийм учраас бид нар бас тогтоол, Байнгын хорооноос тогтоол өгөөд ажиллах, чиглэл өгөх тал дээр анхаараад ажиллая, бас ажлын хэсэг гаргая гэдгээ хэлье.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд бас баярлалаа гэж хэлье.

3 дахь асуудал энэ өнөөдөр хурлаар бид нар нэлээн чухал өвөлжилтийн бэлтгэл ажил, СОР-ийн асуудалтай холбоотой нэлээн олон гишүүд асуулт асууж, хариулт авсан учраас хурал сунжраад дараагийн Байнгын хорооны хурал давхацсан учраас 3 дахь асуудлыг хойшлуулж байна. Жич зарлая тэрийг.

Байнгын хорооны гишүүдэд, ажлын хэсэгт баярлалаа. Хурал дууслаа.

14.56 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР